# ХАА-Н САЛБАРЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР БА ОРОН НУТГИЙН ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ТҮВШИН

*Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн*
*Боловсруулсан: Судалгааны багийн ахлагч Б.Түвшинтөгс*
*Судалгааны багийн гишүүд: Г.Бумчимэг*
*Д.Эрдэнэбулган*
*2015 оны 9 сар*

## ТОВЧИЛСОН ҮГ

| | |
|---|---|
| АХБ | Азийн хөгжлийн банк |
| АНУ | Америкийн нэгдсэн улс |
| БНХАУ | Бүгд найрамдах Хятад ард улс |
| БНСУ | Бүгд найрамдах Солонгос улс |
| БАХ | Бэлчээр ашиглагчдын хэсэг |
| ГШХО | Гадаадын шууд хөрөнгө оруулалт |
| ГТ | Газар тариалан |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| ЕХ | Европын холбоо |
| ЗГ | Засгийн газар |
| МХААХҮХ | Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний хороо |
| МЭМ | Малын эрүүл мэнд |
| МАА | Мал аж ахуй |
| ОХУ | Оросын холбооны улс |
| СБАХ | Сумын бэлчээр ашиглагчдын хэсэг |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| УЦУОШГ | Ус цаг уурын орчны шинжилгээний газар |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| ҮХААЯ | Үйлдвэр хөдөө аж ахуйн яам |
| ХАА | Хөдөө аж ахуй |
| ХБНГУ | Холбооны бүгд найрамдах Герман улс |
| ХҮИ | Хэрэглээний үнийн индекс |
| ХААМИТ | Хөдөө ах ахуйн мэдлэг инновацийн тогтолцоо |
| ХААИС | Хөдөө аж ахуйн их сургууль |
| ХААҮШУОНТ | Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв |
| МҮХАҮТ | Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим |
| ХХААЯ | Хүнс хөдөө аж ахуйн яам |

| | |
|---|---|
| AQSIQ | Administration of Quality Supervision, Inspection Quality |
| CNCA | China National Certification and Accreditation Administration |
| EU SCAR | European Union, the Standing Committee on Agriculture Research |
| OECD | The Organization for Economic Co-operation and Development |
| RCA | Revealed Comparative Advantage |
| SDC | Swiss Development Cooperation |

# ӨМНӨХ ҮГ

Хөдөө аж ахуйн (ХАА) салбар бусад салбартай харьцуулахад ихээхэн онцлогтой. ХАА-н салбарыг хөгжүүлснээр нэгдүгээрт, хүнсний аюулгүй байдлыг хангадаг, хоёрдугаарт, орон нутгийн иргэдийн амьжиргаа, орлогыг дэмждэг, гуравдугаарт, газрын нөөцийг оновчтой ашиглахад чухал үүрэгтэй.ХАА-н салбарын өсөлт бусад салбараас илүүгээр ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулдаг болохыг ч зарим судалгаа харуулдаг (Joe Dewbre, Dalila Cervantes-Gody, Silvia Sorescu, 2011).Монголын ХАА, тэр дундаа орон нутгийн дийлэнх өрхүүдийн эрхэлдэг мал аж ахуй нь байгаль цаг уурын онцлогт зохицож шалгарсан уламжлалт салбар бөгөөд дан ганц уул уурхайн салбараас хараат, хэлбэлзэл ихтэй эдийн засгийг тогтворжуулахад ихээхэн хувь нэмэр оруулах боломжтой салбарын нэг.

Манай улсын ХАА-н салбар сүүлийн 5 жилийн дунджаар ДНБ-ий 13 хувийг эзэлж, ажиллах хүчний 30 орчим хувийг хамарч байна. Нийт өрхийн 36 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байгаа өнөө үед тус салбарын өрсөлдөх чадвар эдгээр хүмүүсийн амьжиргааны түвшинд шууд нөлөөтэй. Эдийн засаг эрчимтэй өсөхийн хэрээр ХАА-н салбарын өрсөлдөх чадвар суларч байгаа дүр зураг тод харагдаж байна. Тухайлбал, ҮСХ-ны мэдээллээс харахад, 2000 онд ХАА-н салбар ДНБ-ий 27 хувийг эзэлж байсан бол 2014 онд 14 хувь болж эрс буурчээ. Түүнчлэн Монгол Улсын өрсөлдөх чадварын тайланд орон нутгийн эдийн засагт нь ХАА, тэр дундаа мал аж ахуй зонхилдог аймгуудын өрсөлдөх чадварын үзүүлэлт бусад аймгаас нэлээд доогуур байгааг тэмдэглэсэн байна.

Энэхүү судалгаагаар манай улсын ХАА-н салбарын өрсөлдөх чадвар болон орон нутгийн иргэдийн амьжиргааны түвшин, эдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг судалж, цаашид ХАА-н бүтээмж сайжирч орон нутгийн иргэдийн амьжиргаа, орлогыг тогтвортой нэмэгдүүлэхэд шаардлагатай арга хэмжээний талаар авч үзэхийг зорилоо. Хэдийгээр бэлчээрийн талхигдал, даац хэтрэл зэрэг хүчин зүйлсийн салбарын өрсөлдөх чадвар болон амьжиргааны түвшинд үзүүлэх нөлөөллийн талаар зарим судалгаа (SDC, 2015) хийгдсэн байдаг ч бид судалгаандаа энэ сэдвийг авч үзээгүй.

Эхний бүлэгт, ХАА-н салбарын өнөөгийн байдал, өрсөлдөх чадварыг, дараах бүлгүүдэд, орон нутгийн иргэдийн амьжиргааны түвшинд нөлөөлж буй хүчин зүйлс, ХАА-н салбарыг хөгжүүлсэн олон улсын туршлага, Монгол улсын ХАА-н салбарыг хөгжүүлэх цаашдын боломжийг тодорхойлж, эцэст нь дүгнэлт өгөх юм

# I. БҮЛЭГ. ХАА-Н САЛБАРЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР

Өрсөлдөх чадвар гэдэг нь өрсөлдөх чадвартай байх, өрсөлдөөнд амжилт гаргах, эрэлтийн үнэ, чанар, тоо хэмжээний шаардлагыг хангахын зэрэгцээ тухайн бизнес нь цаг хугацааны турш олох ашгаараа оршин тогтносоор байхыг хэлнэ (Latruffe, 2010). Өрсөлдөх чадвартай байхын тулд бизнес эрхлэгч ижил бүтээгдэхүүн борлуулагчидтай өрсөлдөхүйц үнээр, адил чанар стандартыг хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох чадвартай, үйлдвэрлэлд ашиглаж буй нөөцүүдийн зохих өгөөжийг хангадаг байх ёстой. Өрсөлдөх чадвартай аж ахуйн нэгж, улс орон бусадтай харьцуулахад ерөнхийдөө тухайн төрлийн бүтээгдэхүүнийг өртөг багатай, эсвэл тухайн үнэ, зардалийн түвшинд илүү чанартай үйлдвэрлэдэг.

Аливаа улсын нөөц, технологи, төсөв ба мөнгөний бодлого, валютын ханшаас өрсөлдөх чадвар нь голчлон шалтгаалдаг гэж үздэг. Тухайлбал, аж ахуйн нэгжийн татвар, зээлийн хүү өндөр, ханш нь чангарч буй эдийн засаг өрсөлдөх чадвар муутай байна. Харин газар, хөдөлмөр, капиталын зардал багатай, илүү сайн технологитой, хүчин зүйлсийн бүтээмж өндөртэй улсын өрсөлдөх чадвар сайн байна. Өрсөлдөх чадварын стандарт шинжилгээ эдгээр хүчин зүйлд төвлөрөх ба үйлдвэрлэлийн орцын зардал, бүтээгдэхүүний чанар, үнэ, бүтээмжийн олон янзын үзүүлэлтийг харьцуулан авч үздэг.

ХАА-н салбарын өрсөлдөх чадварыг тодорхойлоход эдгээрээс гадна зах зээлийн хувирал болон уур амьсгалын өөрчлөлтөд хүнс, ХАА-н үйлдвэрлэлийн дасан зохицох чадварыг шинжлэх шаардлагатай. ХАА-н бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг хэмжихэд дэд салбарууд (мал аж ахуй, үр тариа, хүнсний ногоо гэх мэт) болон газар зүйн байршлын ялгаатай үйлдвэрлэлийг нэгтгэж судлах шаардлага гардаг учраас нэлээд ярвигтай байдаг. Тухайлбал, ХАА-н бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар нь тухайн газар нутгийн хэмжээ, фермийн хэмжээ, бүтэц, бүтээмж, зах зээлээс алслагдсан байдал, үнийн өөрчлөлтөд тэсвэртэй, хүний нөөцийн хүрэлцээ (ур чадвартай ажиллах хүч, маркетингийн чадавхи), технологийн дэвшил, эсцийн бүтээгдэхүүний чанар, тээврийн зардал, дүрэм журам, бодлого (төсвийн, гадаад худалдааны, салбарын гэх мэт) зэргээр тодорхойлогддог (Janet Dwyer et all, 2012).

ХАА-н салбарын тогтвортой өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлдөг хоёр гол хүчин зүйл бий. Нэгдүгээрт, тус салбарын бэлтгэн нийлүүлэгч ба худалдан авагчид төвлөрсөн байдаг учраас ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчид зах зээлийн эрх мэдэл багатай байдаг. ХАА-н ихэнх бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн тоо маш их байдаг боловч тэдний үйлдвэрлэлд шаардагдах орцыг нийлүүлэгчид буюу бордоо, үр, машин тоног төхөөрөмж, малын эрүүл мэндийн бүтээгдэхүүн, зээл нийлүүлэгчид ихээхэн төвлөрсөн байдаг. Мөн ХАА эрхлэгчдээс бүтээгдэхүүнийг

нь худалдан авагчид цөөн тоотой, төвлөрсөн байдаг. Өөрөөр хэлбэл, төгс өрсөлдөөнөөр үнэ нь тогтдоггүй салбараас орцоо авч, олигополь шинжтэй худалдан авагчдад бүтээгдэхүүнээ нийлүүлдгээс тэдэнд зах зээл дээр үнэд нөлөөлөх боломж тааруу байдаг ба өрсөлдөх чадварын сул талыг бий болгодог. Хоёрдугаарт, ХАА-н үйлдвэрлэгчдийн зах зээлийн нөхцөлулирлын чанартайгаас гадна урт хугацааны мөчлөгт өртөмхий, байнгын өөрчлөлт савлагаандоршдог. Энэ нь ХАА-н салбарын жижиг дунд бизнес эхлэгчдэд ихээхэн эрсдэл учруулдаг. Тэд өндөр өртөгтэй судалгаа, хөгжлийн хөрөнгө оруулалт бага хийдэг тул тогтвортой өрсөлдөх чадвартай болж чаддаггүй (Janet Dwyer et all, 2012).

Тогтвортой өрсөлдөх чадварыг дэмжихийн тулд ХАА-н зах зээлийн төгс бус байдлыг бууруулах, мөн тухайн салбарын үр ашигтай байдал, бүтээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай. Инноваци нь ХАА-н салбарын урт хугацааны тогтвортой байдал, эрсдэл даах чадварыг бий болгох нэг гол стратеги юм. Иновацийн уламжлалт хандлага технологийн болон менежментийн өөрчлөлтийг чухалчилдаг бол орчин үеийн хандлага нь бизнес эрхлэгчдийн аж ахуй эрхлэх ур чадвар, овсгоог нэмэгдүүлэх, инноваци хийх чадвартай болгох, институцийн болон бодлогын инновацид анхаарал хандуулдаг болсон (C.Martin Webber, Partrick Labaste, 2010). ХАА-н салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах боломжийн талаар гуравдугаар бүлэгт дэлгэрэнгүй авч үзнэ.

Дараагийн хэсгүүдэд Монгол улсын ХАА-н салбарын өнөөгийн байдал, өрсөлдөх чадварын талаар тоймлож, экспортын давуу тал бүхий ХАА-н бүтээгдэхүүнийг RCA индекс ашиглан тодорхойлж, уг бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх боломжийн талаар судална.

## 1. Монгол улсын ХАА-н салбарын өнөөгийн байдал, өрсөлдөх чадвар

Манай улсын эдийн засагт ХАА-н салбарын гүйцэтгэх үүрэг өндөр байсаар ирсэн. Сүүлийн 25 жилийн хугацаанд ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь дотоодын нийт бүтээгдэхүүний 21 хувийг бүрдүүлжээ. Монгол улсын ХАА-н үйлдвэрлэлийн 83 хувь нь уламжлалт бэлчээрийн мал аж ахуйд ноогдож байна (ҮСХ, 2014).

ХАА-н салбар 1990 онд ДНБ-ий 12 хувийг эзэлдэг байв. 1990-ээд оны эхээр болсон эдийн засгийн уналтын үед бусад салбарууд хүчтэй унасан, мөн шилжилтийн үед бусад салбарын сэргэлт удаан байсан зэрэг нь 1996 онд тус салбарын ДНБ-д эзлэх хувийн жинг өсгөж 38 хувьд хүргэжээ. Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар эрчимтэй өсч байгаа, мөн 2000-2002, 2010 оны зуданд мал ихээр хорогдсон зэргээс шалтгаалж ДНБ-д эзлэх хувь нь 2014 онд 14 хувь болж буураад байна (Зураг 2.1).

### 1.1. Мал аж ахуй (МАА)

Сүүлийн 25 жилд Монголын эдийн засаг дунджаар 4.5 хувиар, ХАА-н салбар 1.5 хувиар өсч, ХАА-гаас бусад салбарын өсөлт 5.4 хувь байлаа. ХАА-н салбарын дундаж өсөлт бусад салбарын өсөлтөөс бага байгаа төдийгүй илүү хэлбэлзэлтэй байна. Тухайлбал, 2000-2002 оны өвөл жил дараалан болсон зуданд 11 сая мал зүй бусаар хорогдож, нийт малын тоо 30-аад хувиар буурчээ. Ингэснээр ХАА-н салбар дээрх онуудад 16, 19, 11 хувиар тус тус унажээ. Мөн 2010 онд болсон зуданд дахин 10 сая мал зүй бусаар хорогдож, малын тоо 26 хувиар, ХАА-н салбарын үйлдвэрлэл 17 хувиар буурчээ (Зураг 1.2).

**Зураг 1.1 ДНБ-д эзлэх ХАА-н салбарын жин буурлаа**




**Зураг 1.2 ХАА-н салбар хэлбэлзэл ихтэй**




*Эх сурвалж: ҮСХ*

Уламжлалт бэлчээрийн мал аж ахуй (МАА) нь цаг агаарын нөхцөлөөс ихээхэн хараат байдаг боловч бусад салбараас буюу эдийн засгийн мөчлөгөөс харьцангуй хараат бус байдаг. Жишээлбэл, 2008 оны дэлхийн санхүүгийн хямралын сөрөг нөлөөгөөр манай улсын ХАА-гаас бусад салбарын үйлдвэрлэл 2.4 хувиар унасан бол ХАА-н салбар 3.6 хувийн өсөлттэй байжээ. Мөн сүүлийн жилүүдэд гадаад

эрэлт буурснаар бусад салбарын өсөлт эрс саарсан бол ХАА-н салбарын өсөлт харьцангуй өндөр байна.

МАА-н үйлдвэрлэл 1989-2014 онд 2010 оны зэрэгцүүлэх үнээр тооцоход 2.1 дахин нэмэгдэж 1.9 их наяд төгрөгт хүрээд байна[1]. Мөн энэ хугацаанд малын тоо толгой 2.1 дахин буюу 27 саяар өсч 52 саяд хүрсэн бөгөөд энэ нь малыг малчдад хувьчилсны үр дүн гэж дүгнэж болно. Энэ өсөлтөд ямаан сүрэг 17 саяар буюу 4.4 дахин өссөн нь гол нөлөө үзүүлсэн. Ямааны тоо толгой ингэж огцом өсөхөд зах зээлийн тогтолцоонд шилжиж, гадаад худалдааг чөлөөлснөөр ямааны ноолуурыг өндөр үнээр гадаад руу экспортлох боломжтой болж, ямаанаас авах ашиг шим бусад малынхаас илүү болсонтой холбоотой. Манай улсын адуу, үхрийн тоо толгой тус бүр 36 хувь ба 27 хувиар өсч 3 сая, 3.4 саяд тус тус хүрчээ. Харамсалтай нь тэмээний тоо 37 хувиар буурч 349 мянга болов (Зураг 1.3, Зураг 1.4).

**Зураг 1.3 МАА-н үйлдвэрлэл тогтворгүй**




**Зураг 1.4 Ямааны тоо толгойн өсөлт өндөр**




*Эх сурвалж: (ҮСХ, 1998-2014), судлаачдын тооцоолол*

[1] ҮСХ-оос гаргасан МАА-н салбарын тоон мэдээ нь 1993, 1995, 2000, 2005, 2010 оны зэрэгцүүлэх үнээр гаргасан ба үүнийг судлаачид өөрсдөө 2010 оны зэрэгцүүлэх үнэ рүү хувиргасан болно.

## 1.2. Газар тариалан

Манай улсад МАА нь олон зуун жилийн туршид эрхэлж ирсэн уламжлалт аж ахуй бол газар тариалангийн салбар 1950-аад оны сүүлчээр өргөн далайцтай хөгжиж эхэлсэн юм. Энэ үеэс атар газар шинээр эзэмшиж, газар тариалангийн үйлдвэрлэлд механикжилт нэвтэрч эхэлсэн бөгөөд 1980-аад оны төгсгөл гэхэд Монгол улс дотоодын улаан буудай, хүнсний ногооны хэрэгцээгээ бүрэн хангахаас гадна цаг агаарын тааламжтай жилүүдэд хэрэгцээнээсээ илүү гарсныг экспортлодог болсон. Мөн малын тэжээлийг тарьдаг болсноор бэлчээрийн МАА-г байгаль цаг уурын нөхцөлөөс хараат бус болгож, МАА-г тогтвортой өсөх нөхцөлийг бүрдүүлж байсан. Гэвч 1990-ээд оны өмч хувьчлалаар сангийн аж ахуйнуудыг олон жижиг хуваан хувьчлахын зэрэгцээ газар тариалангийн тоног төхөөрөмж, тэдгээрийн засвар үйлчилгээний баазыг эзэнгүйдүүлсэн нь тус салбарын хөгжилд сөргөөр нөлөөлж, зардлыг өсгөн, техник технологийн шинэчлэл хийх чадавхийг бууруулжээ (Гунгаадорж, 2009).

Үндсэн хөрөнгө, хүний нөөцийн сарнилт олон жил үргэлжилж, хүнд байдалд байсан газар тариалангийн салбар 2008 оноос, “Хүнсний хангамж, аюулгүй байдлын жил”-ийг зарласан үеэс сэргэж эхэлсэн юм (Хүн-Эвсэл, ТББ, 2008). Монгол улсын Засгийн газар дотоодын улаан буудайн гурил болон төмс, гол нэрийн хүнсний ногоогоор хэрэгцээгээ бүрэн хангах зорилго бүхий “Атрын гурав дахь аян” хэмээх тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг боловсруулан 2008-2011 онд хэрэгжүүлсэн. Энэ хөтөлбөрийн хүрээнд газар тариалангийн салбарын техникийг шинэчлэх хөрөнгө оруулалтын тодорхой хувийг төсвөөс санхүүжүүлж, хаврын тариалалтад хэрэглэх үр бордоо, гербицид авахад санхүүгийн дэмжлэг үзүүлж, тариалалтад хэрэглэх шатахууны үнийг хөнгөлөх зэрэг олон арга хэмжээг Засгийн газраас авч хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд улаан буудайн ургац 3 дахин өсч, төмс, хүнсний ногооны тариалалт 1989 оны түвшинг давжээ. Тэжээлийн ургамлын тариалалт харин төдийлөн сайн сэргэж чадаагүй байна (Зураг 2.5, 2.6).

**ЗУРАГ 1.5 Тариалалт өссөн[2].**




**ЗУРАГ 1.6 Атрын 3-р аяны үр дүн сайн**




*Эх сурвалж: (ҮСХ, 1998-2014), судлаачдын тооцоолол*

## 1.3. ХАА-н бүтээгдэхүүний экспорт, импорт

ХАА-н экспортын голлох бүтээгдэхүүн болох мах, ноолуур, арьс ширний экспорт сүүлийн 20 жилд дунджаар нийт экспортын 11 хувийг эзэлж байна. Харин 2014 оны байдлаар 325 сая ам.долларын ХАА-н бүтээгдэхүүн экспортолсон нь нийт экспортын 5.6 хувийг бүрдүүлж байна. Үүнээс ямааны ноолуурын экспорт 286 сая ам.доллар буюу дийлэнх хувийг бүрдүүлж байгаа юм. Сүүлийн жилүүдэд махны экспорт огцом буурсан нь монголын махны эрүүл ахуй олон улсын стандартыг хангахгүй байгаатай холбоотой. Мөн арьс ширний экспорт төдийлөн нэмэгдэхгүй байна (Зураг 1.7) (Гаалийн Ерөнхий Газар, 2014).

Дотоодод үйлдвэрлэх боломжтой ХАА-ны бүтээгдэхүүн болох улаан буудай, төмс, хүнсний ногоо, өндөг, гахайн мах, тахиан мах, шингэн сүү, цөцгийн импорт сүүлийн 20 жилд нийт импортын 1.8 хувийг эзэлжээ. 2014 оны байдлаар тус

[2] ҮСХ-оос гаргасан Газар тариалангийн салбарын тоон мэдээ нь 1993, 1995, 2000, 2005, 2010 оны зэрэгцүүлэх үнээр гаргасан ба үүнийг судлаачид өөрсдөө 2010 оны зэрэгцүүлэх үнэ рүү хувиргасан болно.

импортын хэмжээ 50 сая ам.доллар буюу нийт импортын 0.9 хувийг бүрдүүлж байна. Сүүлийн жилүүдэд улаан буудайн импорт ихээхэн буурч байсан боловч 2014 онд 11 сая ам.долларын импорт хийжээ. Мөн сүүлийн жилүүдэд дотоодод махны үнэ өссөнөөр орлох бүтээгдэхүүн болох тахианы махны импорт 15 сая ам.долларт хүрч өсөөд байна (Зураг 1.8) (Гаалийн Ерөнхий Газар, 2014).

**ЗУРАГ 1.7 ХАА-н бүтээгдэхүүний экспорт өсчээ[3]**




**ЗУРАГ 1.8 ХАА-н бүтээгдэхүүний импорт буурчээ[4]**




*Эх сурвалж:, (Гаалийн Ерөнхий Газар, 2015)*

## 1.4. ХАА-н бүтээдэхүүний өрсөлдөх чадвар

Энэ хэсэгт Монгол улсын ХАА-н бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дараах дараалын дагуу шинжилнэ. Үүнд:

- Тухайн салбарын бүтээгдэхүүний үр ашиг сүүлийн жилүүдэд нэмэгдэж

[3] Үүнд хонь, ямаа, үхэр, адууны хөлдөөсөн махыг оруулсан.

[4] Улаан буудайн импортын 2004 оноос өмнөх үнийн дүнгийн мэдээлэл байхгүй, харин тоо хэмжээний мэдээлэл байсан. Тоо хэмжээг олохдоо импортын хэмжээг дэлхийн зах зээл дээрх улаан буудайн үнээр үржүүлж тооцоолов. Хүнсний ногоонд лууван, манжин, байцай, сонгино, сармис орсон.

байгаа эсэх

- МАА, газар тариалангийн үржил шим бусад оронтой харьцуулахад ямар түвшинд байгаа
- Бодит ханшийн чангаралт, түүний ХАА-н үйлдвэрлэлд үзүүлэх нөлөө
- ХАА-н салбарын голлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт, импортын хэмжээ, дотоод, гадаад үнэ.

***ХАА-н салбарын үр ашиг***

Хэдийгээр МАА-н салбар, малын тоо толгой ихээр өссөн боловч нэг малаас авах ашиг шим сүүлийн 25 жилд өсөөгүй байна. 1989 онд нэг малаас 100 төгрөгийн нэмүү өртөг бий болдог байсан бол 2014 онд 60.2 мянган төгрөгийн нэмүү өртөг бий болж байгаа боловч энэ нь бүтээмжийн өсөлттэй холбоогүй байна. Тухайлбал, МАА-н үйлдвэрлэлийг 2010 оны үнэд шилжүүлэн нэг малд ноогдох үйлдвэрлэлийг тооцоход 1989 онд нэг малаас 37.5 мянган төгрөгийн нэмүү өртөг бий болж байсан бол 2014 онд энэ үзүүлэлт 37.6 мянган төгрөг байна (Зураг 1.9). Харин газар тариалангийн салбарын хувьд мөн хугацаанд нэг га талбайгаас авах ургацын хэмжээ 40 гаруй хувиар өсч, 2010 оны үнээр тооцоход 1989 онд нэг га талбайгаас 711 мянган төгрөгийн нэмүү өртөг бүтээж байсан бол 2014 онд 1017 мянган төгрөгийн нэмүү өртөг бий болгожээ (Зураг 1.10).

Газар тариалангийн салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмжийн шинэчлэл зэрэг нь ийнхүү тус салбарын өгөөжийг нэмэгдүүлсэн бол МАА-н салбар нь өрхийн аж ахуй дээр суурилсан бичил хэмжээтэй байдгаас малын ашиг шимийг нэмэгдүүлэхэд шаардлагатай судалгаа, хөрөнгө оруулалтыг хийхэд хүндрэлтэй байдаг. Тухайлбал, 2014 оны байдлаар нэг малчин өрх дундажаар 244 малтай, нэг малаас жилд дунджаар 60 мянган төгрөгийн орлого олдог гэвэл өрхийн орлого жилд дунджаар 15 сая төгрөгбайна. Энэ нь хөрөнгө оруулалт хийх хүрэлцээтэй орлого биш юм.

**ЗУРАГ 1.9 МАА салбарын бүтээмж сайжирсангүй**




**ЗУРАГ 1.10 Газар тариалангийн бүтээмж сайжирлаа.**




*Эх сурвалж: (ҮСХ, 1998-2014), судлаачдын тооцоолол*

## *ХАА-н салбарын бүтээмжийн олон улсын харьцуулалт*

ХАА-н салбарын үйлдвэрлэлийн бүтээмжийг бусад орныхтой харьцуулахад нэлээд доогуур байна. Тухайлбал, төл малын хорогдлын хувь 6 дахин их буюу 30%, нядалгаанд оруулах нас хонины хувьд 20-30 сар, үхрийн хувьд 36-46 сар байхад олон улсын жишгээр хонь 6-8 сар, үхэр 14 сар байна. Мөн нэг га талбайгаас авах ургацын хэмжээ хэдийгээр сүүлийн жилүүдэд өсч байгаа боловч олон улсын жишгээс 40-70 хувиар бага байна (Хүснэгт 1.1) (Х.Золжаргал, 2014).

**ХҮСНЭГТ 1.1 ХАА-н үйлдвэрлэлийн бүтээмж**

| **Мал аж ахуй** | | | | |
|---|---|---|---|---|
| | | **Монгол** | **Олон улс** | **Харьцаа** |
| Төлийн хорогдол/хээлтэгч эх мал | % | 30[5] | 5 | 6.0 |
| Хонины мах | | **Монгол** | **Австрали** | **Харьцаа** |
| Сүргийн нядалгаанд хамруулах хувь | % | 46 | 60 | 0.8 |

[5] 2009-2012 оны дундаж

| | | | | |
|---|---|---|---|---|
| Нядалгаанд орох нас | сар | 20-30 | 6-8 | 2,5-5 |
| Нядалгааны жин | кг | 45 | 50 | 0.9 |
| Гулуузны жин | кг | 16 | 23 | 0.7 |
| Үхрийн мах | | **Монгол** | **Канад** | **Харьцаа** |
| Сүргийн нядалгаанд хамруулах хувь | % | 18 | 30 | 0.6 |
| Нядалгаанд орох нас | сар | 36-46 | 14 | 2,5-3,3 |
| Нядалгааны жин | кг | 315 | 590 | 0.5 |
| Гулуузны жин | кг | 118 | 371 | 0.3 |
| **Газар тариалан** | | | | |
| | | **Монгол** | **Канад** | **Харьцаа** |
| Үр тарианы ургац | тн/га | 1.6 | 2.7 | 0.6 |
| Төмсний ургац | тн/га | 15 | 49[6] | 0.3 |
| Хүнсний ногоо | тн/га | 12.5 | 37[7] | 0.3 |

***Эх сурвалж:*** Х.Золжаргал, "ХХААЯ, Төрөөс ХАА-н талаар баримтлах бодлого" илтгэл, "ХАА-н салбарын санхүүжилтийн шинэ арга хэрэгслүүд" зөвлөгөөн. 2014 он

### *Бодит ханшийн чангаралт*

2000 оноос хойш уул уурхайн салбарт орж буй гадаадын хөрөнгө оруулалт ба уг салбарын экспортын орлого өссөнөөр гадаад валютын орох урсгал нэмэгдэж, улмаар төгрөгийн бодит ханш чангарах болсон (Зураг 1.11).

**ЗУРАГ 1.11 Урт хугацаанд бодит ханш[8] чангарч ирсэн**




*Эх сурвалж: (Монголбанк, 2015)*

Валютын бодит ханшийн чангаралт нь экспортод гаргадаг болон импортыг орлох салбарын, тэр дундаа, боловсруулах болон ХАА-н салбарын бүтээгдэхүүний

6 Усалгаагүй талбайгаас 49 тн, усалгаатай талбайгаас 65 тн

7 Усалгаагүй талбайгаас 37 тн, усалгаатай талбайгаас 52 тн

8 Төгрөгийн нэрлэсэн ба бодит үйлчилж буй ханшийн индекс нь гадаад худалдааны түнш орнуудын валюттай харьцах төгрөгийн ханшийн индексийн жигнэсэн дундаж ханшийг илэрхийлэх бөгөөд бодит үйлчилж буй ханшийн индексийн өсөлт нь төгрөгийн ханш чангарсныг, харин бууралт нь суларсныг тус тус илэрхийлнэ.

импортын үнийг бууруулж, экспортын үнийг өсгөснөөр өрсөлдөх чадваргүй болгодог. Бодит ханш чангарсан 2000-2008 онд ХАА-н гол бүтээгдэхүүн болох улаан буудайн дотоодын ургац ба импорт нэгэн зэрэг буурч байв. Энэ үед гурилын импорт өсч, дотоодын үйлдвэрлэл буурсан. 2008 онд газар тариаланг хөгжүүлэх Атрын 3-р аянг эхлүүлж тус салбарт ихээхэн хөрөнгө оруулснаар бодит ханшийн нөлөөгөөр сулраад байсан газар тариалангийн үйлдвэрлэл сэргэсэн юм.

МАА-н бүтээгдэхүүний хувьд 2010-2012 онд тахиа, гахайн махны импорт огцом өссөн[9] нь бодит ханшийн чангаралт, дотоодын махны үнийн өсөлттэй давхцаж байна. Мөн дотоодод бэлтгэсэн махны чанар олон улсын стандартад хүрдэггүйгээс гадна дотоодын хэрэглээ өндөр, дотоодод махны үнэ ихээхэн өссөн нь мах экспортлох үнийн хөшүүргийг сулруулж ирсэн. Харин экспортод голлох хувийг эзэлдэг ноолуурын үнэ олон улсын зах зээлд гадаад валютаар илэрхийлэгдэн тогтдог, мөн ноолуурын дотоодын хэрэглээ бага тул бодит ханшийн нөлөөнд төдийлөн өртөөгүй ажээ.

***ХАА-н бүтээгдэхүүний дотоод ба гадаад үнийн зөрүү***

Өрсөлдөх чадварт нөлөөлөх бас нэг үзүүлэлт нь дотоод ба гадаад үнийн зөрүү юм. Энэ үнийн зөрүү нь дотоод ба гадаад үнэ, ханшийн хөдөлгөөнөөр тайлбарлагдана. Хэрэв дотоодод бүтээгдэхүүний үнэ хурдтай өсч, гадаад үнэ, валютын ханш тогтвортой байвал дотооддоо үйлдвэрлэсэн бараанаас импортын барааны үнэ хямд болж ирнэ. Харин гадаад үнэ өсөх, эсвэл төгрөгийн ханш сулрах нь импортын барааг үнэтэй болгож дотоодын барааны эрэлтийг өсгөнө. ХАА-н бүтээгдэхүүний хувьд энэ хандлага тодорхой ажиглагддаг.

Манай улс сүүлийн үед жилд дунджаар 150 мянган тонн бог малын мах үйлдвэрлэж байгаа бөгөөд 2013 онд үүнийхээ 400 тонныг экспортлосон бол 2014 онд огт экспортлоогүй байна. Энэ нь зарим талаар дотоод ба гадаад үнийн зөрүүтэй холбоотой байж болох юм. Тухайлбал, 2011 онд дотоодод нэг кг хонины мах 4125 төгрөг[10] байсан бол дэлхийн зах зээл дээр тухайн үеийн валютын ханшаар үүнтэй ойролцоо буюу 3 ам.доллар[11] орчим байв. Харин 2012-2013 онд дотоодын махны үнэ дунджаар 7000 төгрөг буюу тухайн үеийн ханшаар 5 ам.доллар болсон. Хэдийгээр 2014 онд төгрөгийн ханш суларч нэг кг хонины махны дотоодын үнэ 4 ам.доллар болсон боловч дэлхийн зах зээлийн үнэ тогтвортой байсан тул гадаад дотоод үнийн зөрүү өндөр хэвээр байна. Үүний улмаас аж ахуйн нэгжүүдэд мах экспортолж ашиг олох сэдэл төрөхгүй байна. (Зураг 1.12, 1.13).

9 2009 онд 3.6 2010 онд 6.4, 2011 онд 10.1, 2012 онд 17.6, 2013 онд 20.0, 2014 онд 20.1 сая ам.долларын гахай, тахиан мах импортлосон байна.

10 Улаанбаатар хотын гол нэрийн бараа, үйлчилгээний жилийн дундаж үнэ. (Статистикийн Мэдээллийн Нэгдсэн Сан, 2015)

11 Лондонгийн Смитфилдийн зах дээрх хөлдүү хонины махны үнэ (IMF, 2014)

**ЗУРАГ 1.12 Махны экпорт өсөөгүй**




**ЗУРАГ 1.13 Махны дотоодын үнэ өндөр**




*Эх сурвалж: (Гаалийн Ерөнхий Газар, 2015), (Монголбанк, 2015), (Статистикийн Мэдээллийн Нэгдсэн Сан, 2015), (IMF, 2014)*

Төмсний тариалалт сүүлийн арваад жил эрчимтэй өсч 2012 онд хамгийн ихдээ 250 мянган тонн төмс хурааж авчээ. 2009 онд төгрөгийн ханш огцом суларсан, 2010-2013 онд төмсний импортын үнэ өссөн зэрэг нь импортын ба дотоодын үнийн зөрүү буурахад нөлөөлжээ. Ийнхүү дотоодын ба импортын үнэ ойртсоноор төмсний импорт эрс буурчээ. Харин 2014 онд төмсний импортын үнэ огцом буурч, импортын ба дотоодын төмсний үнийн зөрүү нэмэгдэж, төмсний импорт өсчээ (Зураг 1.14, 1.15).

**ЗУРАГ 1.14 Төмсний ургац өсч импорт буурав**




**ЗУРАГ 1.15 Төмсний үнийн зөрүү буурав**




*Эх сурвалж: (Гаалийн Ерөнхий Газар, 2015), (Монголбанк, 2015), (Статистикийн Мэдээллийн Нэгдсэн Сан, 2015)*

Атрын 3-р аяны үр дүнд улаан буудайн тариалалт бараг 2 дахин өсч 2008 онд 210 мянган тонн буудай хураан авсан. Тус аяны хүрээнд тариаланчдад урамшуулал өгч, хөнгөлттэй нөхцөлөөр зээл олгож, зээлийнхээ төлбөрийг Тариалан Эрхлэлтийн Санд буудайгаар төлөх боломж олгосон юм. Энэ дагуу 2008 онд 142 мянган тонн буудай тус санд тушаагджээ. Энэ урамшуулал үр дүнгээ өгч, 2014 онд улсын хэмжээнд 490 мянган тонн буудай хураасан (ХХААЯ, 2015). Энэ хооронд буюу 2011-2013 онд улаан буудайн дотоодын үнэ[12] дэлхийн зах зээл дээрх үнээс бага байх үед нийт 11 мянган тонн буудай импортлосон бол 2014 онд дотоодын үнэ импортын үнээс өндөр болсон үед 34 мянган тонн буудай импортлосон байна (Зураг 1.16, 1.17).

[12] Тариалан Эрхлэлтийн Сангийн худалдаж авсан буудайн үнэ (ХХААЯ, 2015)

**ЗУРАГ 1.16 Буудайн ургац өсч импорт буурав**




**ЗУРАГ 1.17 Ханш суларч импортын үнэ өсөв**




*Эх сурвалж: (Гаалийн Ерөнхий Газар, 2015), (Монголбанк, 2015), (Статистикийн Мэдээллийн Нэгдсэн Сан, 2015), (ХХААЯ, 2015)*

Буудайн дотоодын үнэ импортын үнээс бага байгаа нь гурил үйлдвэрлэгчдийн зардлыг импортын гурилын үнээс бага байх хөшүүрэг болсноос гадна үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд гурил үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгож байсан нь гурилын үйлдвэрлэлийг өсгөж импортыг бууруулахад нөлөөлсөн байж болох юм. Түүнчлэн гурилын импортын үнэ дотоодын үнээс хурдтай өссөн нь дотоодын гурилын эрэлтийг нэмэгдүүлжээ (Зураг 1.18, 1.19).

**ЗУРАГ 1.18 Гурилын үйлдвэрлэл өсч, импорт буурлаа**




**ЗУРАГ 1.19 Гурилын үнэ өсч байна**




*Эх сурвалж: (Гаалийн Ерөнхий Газар, 2015), (Статистикийн Мэдээллийн Нэгдсэн Сан, 2015), (Монголбанк, 2015)*

Энэхүү шинжилгээнд ноолуур, арьс шир зэрэг бүтээгдэхүүнийг хамруулаагүй. Ноолуур хэдийгээр ХАА-н бүтээдэхүүний экспортод голлох нөлөө үзүүлж байгаа боловч дотоодын хэрэглээ нь хязгаарлагдмал байдаг бол арьс ширний дотоодын үйлдвэрлэл бага хөгжсөн, дотоодын үнэ нь гадаад зах зээлийн үнийг шууд дагаж тогтоогддог онцлогтой.

## 2. Экспортын давуу тал бүхий ХАА-н бүтээгдэхүүн: RCA индекс

Энэ хэсэгт Монгол улсын ХАА-н салбарын дэлхийн зах зээл дээр харьцангуй давуу тал бүхий, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг тодруулж, цаашид тэдгээрийн экспортыг нэмэгдүүлэх боломжийг авч үзнэ.

Нортон нарын судалгаагаар (R.Kaplan, D.Norton, 2008) өрсөлдөөний онол нь харьцангуй давуу тал ба өрсөлдөх давуу тал дээр суурилдаг бөгөөд эдгээр нь холбоотой ойлголт юм. Харьцангуй давуу талын үзэл санаа нь аливаа улс бусад улстай харьцуулахад хямд зардалтай үйлдвэрлэх бүтээгдэхүүнээ экспортолж, харьцангуй өндөр зардалтай үйлдвэрлэх бүтээгдэхүүнийг импортолдог бол ашигтай гэсэн олон улсын худалдааны уламжлалт онолоос

үүдэлтэй. Харьцангуй давуу талын онолын уламжлалт хандлага нь алдагдсан боломжийн зардал (opportunity cost) болон хөдөлмөрийн төрөлжилтөд голлон тулгуурладаг. Тухайлбал, А.Смит (Smith, 1776), Ж.С.Милл (Mill, 1848) нарын үндэслэсэн үнэмлэхүй давуу талын тухай ойлголтоор аливаа улс хамгийн бага зардлаар үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнээ экспортлох хэрэгтэй хэмээн үздэг. Үүнийг Д.Рикардо (Ricardo, 1815) гүнзгийрүүлэн судалж, аливаа улс орон нөөцийг хамгийн үр ашигтай ашиглаж байхаар хуваарилах нь оновчтой гэж дүгнэсэн. Энэ тохиолдолд тухайн улс хамгийн бага зардлаар үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнээ импортлох нь оновчтой ч байж болно. Нэлээд хожуу Э.Хэкшер, Б.Олин (E.Leamer, 1995) нар худалдааны онолд шинэ хандлага оруулж, улс орнуудын нөөцийн буюу хүчин зүйлсийн ялгаатай байдал хамгийн чухал болохыг харуулсан. Тэд үзэхдээ аливаа улс өөртөө элбэг хүчин зүйл түлхүү ашигласан бүтээгдэхүүнээ экспортолдог гэжээ. Жишээлбэл, газрын нөөц ихтэй улс бол газрын нөөц түлхүү ашигладаг бүтээгдэхүүн, капиталын нөөц ихтэй улс капиталын орц давамгайлсан бүтээгдэхүүн экспортлох нь тухайн улсад харьцангуй давуу талыг бий болгох юм.

Худалдааны уламжлалт онолууд хүчирхэг боловч эмпирик судалгаа, тэр дундаа худалдааны бодит дүр зургийг тайлбарлахад учир дутагдалтай байдаг. Учир нь, харьцангуй давуу тал нь бодит эдийн засагтүл ажиглагдах олон хувьсагчийг харгалзаж үзэх хэрэгтэй болдог. Тиймээс харьцангуй давуу талыг эмпирикээр хэмжих Илэрсэн харьцангуй давуу талын (revealed comparative advantage-RCA) индекс гэх аргыг Баласса (Bela, 1965) боловсруулсан байдаг. Тодорхой ангиллын бараа үйлчилгээний гадаад худалдааны урсгалаар тухайн улс уг бараа үйлчилгээний хувьд бусдаас хэр давуу байгаа нь илрэх бөгөөд илэрсэн харьцангуй давуу талын индекс нь бүтээгдэхүүний үнэ, тариф, чанар, зардал, үйлдвэрлэлийн хүчин зүйлс, эдийн засгийн нөхцөл, хууль эрх зүйн орчин гэх мэт худалдаанд нөлөөлөгч хүчин зүйлсийг аль хэдийнээ агуулдаг гэж үздэг.

Манай улсын экспортын барааны бүтцийг авч үзвэл 2009-2014 онд эрдэс бүтээгдэхүүн дунджаар 82 хувь, ХАА-н бүтээгдэхүүн 9 хувийг эзэлж байна (Хавсралтын Хүснэгт A12). Уул уурхайгаас ихээхэн хамааралтай эдийн засгийн савлагааг тогтворжуулахад бусад салбарыг дэмжиж, өрсөлдөх чадварыг сайжруулан, экспортын бүтцийг төрөлжүүлэх шаардлагатай. Үүнд ХАА томоохон хувь нэмэр оруулах боломжтой салбарын нэг юм. Иймээс манай улс ХАА-н ямар бүтээгдэхүүнээр дэлхийн зах зээлд давуу талтай, тэдгээрийн өрсөлдөх чадварыг хэрхэн сайжруулах боломжтойг судлах шаардлагатай юм. Үүний тулд бид олон улсад түгээмэл хэрэглэгддэг RCA индексийг тооцов.

Тодруулбал, $i$ улсын $j$ бүтээгдэхүүний хувьд RCA тооцохдоо дараах аргачлалыг ашиглана.

$$RCA_{ij} = (EX_{ij}/EX_i) / (EX_{nj}/EX_n)$$

Энд $EX_{ij}$ нь *i* улсын *j* бүтээгдэхүүний экспорт, $EX_i$ нь *i* улсын нийт экспорт, $EX_{nj}$ - дэлхийн *j* бүтээгдэхүүний нийт экспорт, $EX_n$ нь дэлхийн нийт экспортыг илэрхийлнэ. Ерөнхийдөө RCA > 1 нөхцөлд тухайн бүтээгдэхүүн экспортын хувьд давуу талтай, RCA < 1 тохиолдолд эсрэгээрээ байна (G.Tasevska & E.Rabinowicwicz, 2014). Нарийвчилбал:

- RCA < 0.8 бол харьцангуй давуу талгүй
- 0.8 < RCA < 1 бол сулавтар харьцангуй давуу талтай
- RCA = 0.8 - 1.25 бол дундаж харьцангуй давуу талтай
- RCA = 1.25 - 2.5 бол хүчтэй харьцангуй давуу талтай
- RCA > 2.5 бол маш хүчтэй харьцангуй давуу талтай

Олон улсын худалдааны төвийн (International Trade Centre) тоон өгөгдөл болон Монгол улсын гаалийн тоо мэдээг ашиглан ХАА-н экспортын бүтээгдэхүүний хувьд 4 оронгийн нарийвчлалтайгаар[13] RCA индексийг тооцож дараах хүснэгтэд харуулав. Дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу.

**ХҮСНЭГТ 1.2 ХАА-н бүтээгдэхүүний RCA индекс**

| Бүтээгдэхүүний ангилал | Код | Бүтээгдэхүүний нэр (ITC) | RCA | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 2011 | 2012 | 2013 |
| Мал,амьтад тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн | '0101 | Амьд адуу | 0.08 | 0.09 | 0.26 |
| | '0202 | Үхрийн хөлдүү мах | 2.80 | 0.42 | - |
| | 204 | Хөлдөөсөн хонь, ямааны мах | | 0.07 | 0.03 |
| | 205 | Адууны мах, шинэ, хөлдөөсөн | 83.73 | 33.25 | 33.41 |
| | 210 | Гэдэс, цувдаа | - | 0.06 | 0.03 |
| | 504 | Өлөн гэдэс, давсаг, гүзээ | 7.73 | 8.12 | 8.14 |
| | '0506 | Яс, тугалмай | 3.89 | 2.72 | 0.01 |
| | '0507 | Зааны яс, боловсруулаагүй халимны яс | 5.77 | 4.32 | 14.79 |
| | '0511 | Амьтны гаралтай бусад бүтээгдэхүүн | 0.40 | 0.42 | 0.31 |
| Ноос, ноолууран болон сүлжмэл бүтээгдэхүүн | 6101 | Ямааны ноолууран пальто, хүрэм, жакет | - | 0.06 | 0.01 |
| | 6102 | Эмэгтэй, охидын ямааны ноолууран үйлс | 0.40 | 0.45 | 0.24 |
| | 6103 | Сүлжмэл костюм буюу комплект, ансамбль, жакет, өмд, комбинзон (эр) | 0.00 | 0.00 | 0.00 |
| | 6104 | Ноолууран өмд, цамц, пальто, банзал (эм) | 0.05 | 0.06 | 0.05 |
| | 6105 | Сүлжмэл цамц (эр) | 0.00 | 0.00 | 0.01 |
| | 6106 | Нэхмэл, сүлжмэл цамц (эм) | 2.24 | 1.49 | 0.07 |
| | 6107 | Дотуур өмд, гэрийн хувцас, усны алчуур (эр) | - | 0.01 | 0.01 |
| | 6108 | Дотуур өмд, гэрийн хувцас, усны алчуур (эм) | - | 0.02 | 0.02 |
| | 6109 | Сүлжмэл футболка, майк | 0.00 | 0.01 | 0.00 |
| | 6110 | Свитер, пуловер, джемпер болон бусад сүлжмэл гадуур цамц | 0.46 | 1.10 | 1.28 |
| | 6111 | Хүүхдийн сүлжмэл өмсгөл, хувцас | 0.04 | 0.02 | 0.01 |
| | 6114 | Бусад сүлжмэл хувцас | 0.01 | 0.04 | 0.06 |
| | 6116 | Сүлжмэл ноосон бээлий | 0.03 | 0.12 | 0.08 |
| | 6117 | Бусад, хувцасны сүлжмэл тоноглол | 2.56 | 5.07 | 2.12 |
| Тэмдэглэл: * Бүтээгдэхүүний Гаалийн мэдээлэл болон ITC-н нэршил ялгаатай тохиолдолд | | | | | |

[13] HS: Harmonized System Codes

Хүснэгтээс дүгнэхэд, Монгол улс малын гаралтай, түүхий болон боловсруулсан арьс шир, ноос, амьтны үс, нэхмэлийн утас болон даавуу, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн, ноос, ноолууран болон сүлжмэл бүтээгдэхүүн зэрэг бүтээгдэхүүний хувьд экспортын давуу тал өндөр байна. Мөн хивс болон бусад нэхмэл шалны дэвсгэр харьцангуй давуу тал сул болович сайжрах хандлага ажиглагдаж байна.

Мах, махан бүтээгдэхүүний хувьд адууны махны харьцангуй давуу тал хамгийн өндөр, 2013 оны байдлаар RCA индекс 33.41 гарчээ. Удаад нь үхрийн хөлдүү мах орж байгаа бөгөөд 2011 онд RCA индекс 2.8 байсан бол 2012 онд 0.42 болж буурчээ. Харин хонины махны тухайд өрсөлдөх чадвар сул байгаа бөгөөд 2013 оны байдлаар RCA индекс 0.03 байна. 2013 онд малын гаралтай бусад бүтээгдэхүүн болох өлөн гэдэс, гүзээний тухайд RCA индекс 8.14, яс тугалмайн RCA индекс 0.01 гарсан бол, малын эвэр туурай, соёо, шувууны хошуу саварны хувьд RCA индекс 14.79 тус тус гарчээ.

Үүний зэрэгцээгээр 2013 оны хувьд үхэр, адууны түүхий болон боловсруулсан арьс ширний RCA индекс 2.01, 5.24 тус тус болжээ. Мөн 2012 онд хонь, хурганы боловсруулсан арьс ширний индекс 69.3 байсан бол 2013 онд 61.53 болж буурчээ. Ямаа, ишигний боловсруулсан арьс ширний тухайд тус индекс 40.5 болж өссөн дүнтэй гарчээ. Эндээс харахад манай улс үхэр, адууны түүхий болон боловсруулсан арьс шир, хонь ямааны боловсруулсан арьсны экспортын хувьд харьцангуй давуу тал маш ихтэй байна.

Ноос, амьтны үс, нэхмэлийн утас болон даавуу, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүний тухайд харьцангуй давуу тал ихтэй байна. Тухайлбал, 2013 оны хувьд RCA индекс хонины сэмлээгүй буюу самнаагүй ноосонд 3.11, нарийн болон бүдүүн амьтны үс, сэмлээгүй буюу самнаагүй үсэнд 1679, ноосны хаягдалын хувьд 1.95, мал амьтны самнасан үс, хялгасны тухайд 107.33 гэж тус тус гарчээ. Ноос, ноолууран болон сүлжмэл бүтээгдэхүүний хувьд харьцангуй давуу тал эмэгтэй хүний ямааны ноолууран цамц, эмэгтэй нэхмэл цамцны хувьд сулавтар байгаа бол свитер, пуловер, жемпер, жилет болон бусад сүлжмэл гадуур цамцны хувьд өндөр байна.

Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар өндөр, эсвэл ирээдүйд сайжрах хандлагатай манай улсын ХАА-н бүтээгдэхүүнийг импортлогч гол түнш орнуудын 2010-2014 оны дундаж импорт болон тэдгээрийн дэлхийд эзэлж буй байрыг авч үзвэл, ОХУ үхрийн хөлдөөсөн махыг хамгийн ихээр импортолж (2.4 тэрбум ам.доллар) байгаа бол 3-р байрт Япон (1.3 тэрбум ам.доллар), 4-р байрт БНСУ (1.2 тэрбум ам.доллар), 11-р байрт БНХАУ (0.4 тэрбум ам.доллар) орж байна юм (Хавсралт, хүснэгт 1.5). Адууны махны импортоор Итали дэлхийд тэргүүлдэг бөгөөд жилд дунджаар 113 сая ам.долларын импорт хийдэг болович

Монгол улсаас импортолдоггүй. Харин ОХУ-ын адууны махны импорт дунджаар 74 сая ам.доллар буюу дэлхийд 4-р байр эзэлдэг. Энэ хугацаанд Монгол улс жилд дунджаар 1.7 мянган тонн буюу 4.5 сая ам.долларын адууны мах экспортолжээ (Хавсралтын Хүснэгт А.14).

Мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний импортоор Япон, БНСУ, БНХАУ зэрэг улс, түүхий болон боловсруулсан арьс ширний импортоор БНХАУ, Итали дэлхийд тэргүүлж байна. Манай улс ноос, ноосон бүтээгдэхүүн, хивс хивсэнцрийг БНСУ, БНХАУ, АНУ-д экспортлох боломж өндөр байна.

2011-2013 оны Монголын экспортын дундаж болон худалдааны түнш орнуудын импортод эзлэх хувийг Хавсралтын Хүснэгт А.15-д харуулав.

Үхрийн хөлдүү махны хувьд Монгол улс гол түнш ОХУ-д жилд дунджаар 7.5 сая ам.долларын буюу 2.9 мянган тонныг экспортолсон нь ОХУ-ын тус бүтээгдэхүүний импортын 2 хувийг эзэлжээ. Харин адууны махны хувьд ОХУ-д 4.5 сая ам.долларын буюу 1.7 мянган тонныг, БНХАУ-д 2.5 сая ам.долларын буюу 2.4 мянган тонныг тус тус экспортолжээ. Энэ нь ОХУ ба БНХАУ-ын адууны махны импортын 6 хувь, 72 хувийг тус тус бүрдүүлж байгаа аж.

Үхэр, адууны ширний тухайд Монгол улсаас БНХАУ-д жилд дунджаар 2.9 сая ам.долларын буюу 3.5 мянган тонн боловсруулсан шир ба 2.6 сая ам.долларын буюу 2.5 мянган тонн боловсруулаагүй ширийг тус тус экспортолжээ. БНХАУ нь эдгээр бүтээгдэхүүнээс тус бүр жилд дунджаар 2306 сая ам.доллар, 1411 сая ам.долларын импорт хийдэг, дэлхийн зах зээлдээр энэ түүхий эдийн хамгийн том худалдан авагч юм. Итали улс дээрх бүтээгдэхүүний импортоор БНХАУ-ын дараа дэлхийд хоёрдугаарт ордог бөгөөд төрөл тус бүрээс 1140 сая ам.доллар ба 1,3 сая ам.долларын импорт хийжээ. Манай улс дээрх хугацаанд Итали улсад жилд дунджаар 63.3 мянган ам.долларын буюу 30 тонн боловсруулаагүй шир, 3.6 сая ам.долларын буюу 1.3мянган тонн боловсруулсан шир экспортолсон боловч энэ нь тус улсын түүхий болон боловсруулсан ширний импортын 0.01 хувь, 0.03 хувийг тус тус бүрдүүлжээ. Энэ хувь хэмжээг цаашид нэмэгдүүлэх ихээхэн боломж ажиглагдаж байна.

Мөн Монгол улсаас БНХАУ-д 5.9 сая ам.долларын хонины самнаагүй ноос, 72.8 мянган ам.долларын мал, амьтны нарийн болон бүдүүн үс, сэмлээгүй буюу самнаагүй үсний экспорт хийсэн нь тус улсын эдгээр бүтээгдэхүүний импортод 0.2 хувь болон 83.3 хувийг тус тус эзэлж байна. Мал, амьтны самнасан үс хялгасны импортоор Их Британи (4,571 сая ам.доллар), Швейцарь (556 сая ам.доллар), ХБНГУ (309 сая ам.доллар), Итали (82 сая ам.доллар) нь БНХАУ-ын дараа ордог гол орнууд юм. Хэдийгээр эдгээр улсад экспортолж буй ноос, даавуун нэхмэл бүтээгдэхүүний хэмжээ бага боловч нөгөө талаас эдгээр улс тус

бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн гол импортлогчид юм. Тухайлбал, Итали улс жилд дунджаар 417.1 сая ам.доллар, ХБНГУ 206.6 сая ам.доллар, БНСУ 163.2 сая ам.доллар, БНХАУ 125.2 сая ам.доллар, Япон улс 90 сая ам.долларын импорт тус тус хийдэг. Иймд Итали, ХБНГУ, БНСУ, Япон зэрэг улсад экспортолж буй ноос, даавуун нэхмэл бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэхөргөн боломж харагдаж байна.

Үслэг биш хээгүй хивс болон бусад нэхмэл бүтээгдэхүүний хувьд манай улсын харьцангуй давуу тал сулавтар бөгөөд 2013 онд БНХАУ-д дунджаар 510 мянган ам.долларын буюу 42 тонн, ОХУ-д 73 мянган ам.долларын буюу 6 тонн нэхмэл бүтээгдэхүүн тус тус экспортолжээ. Энэ чиглэлээр манай улс нэхмэл ханын өнгөлгөө, дэнлүү, зуухны гол, цахилгааны нэхмэл гуурс болон хоолой зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох боломжтой. Эдгээр бүтээгдэхүүний гол импортлогчид нь АНУ, БНХАУ, ОХУ, ХБНГУ, Япон зэрэг орон юм.

Ноос, ноолууран болон нэхмэл сүлжмэл бүтээгдэхүүний экспортын тухайд манай улсын өрсөлдөх чадвар сайн байгаа нь “илэрсэн харьцангуй давуу талын индекс”-ээс харагдаж буй боловч үйлдвэрлэлийн технологийг сайжруулж, дэлхийн зах зээлд хэрэглэгчдийн шаардлагыг хангасан ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй. Жишээ нь, эмэгтэй хүний ноолууран цамцны хувьд АНУ, ХБНГУ, Япон зэрэг томоохон зах зээлийг онилох шаардлагатай бөгөөд өнөөгийн байдлаар манай улсын экспорт тус улсуудын импортын ердөө 0.0003 хувь (АНУ), 0.01 хувийг (Япон) эзэлж байгаа нь чамлахаар үр дүн юм.

Дээрх шинжилгээнээс дүгнэхэд, манай улсын ХАА-н экспортын бүтээгдэхүүнүүдээс харьцангуй давуу тал хамгийн ихтэй, цаашид гадаад зах зээлд орон зайгаа тэлэх боломжтой бүтээгдэхүүн бол мах, махан бүтээгдэхүүн болон ноос, ноолууран бүтээгдэхүүн байна. Эдгээр бүтээгдэхүүнийг худалдааны түнш орнуудад экспортлохын тулд ямар шаардлага, стандартыг хангасан байх талаар дараах хэсэгт танилцуулна.

## 3. Харьцангуй давуу тал бүхий ХАА-н бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх боломж

Өмнөх хэсэгт илэрсэн харьцангуй давуу талын (RCA) индексийн шинжилгээнээс манай улсын харьцангуй давуу тал бүхий, цаашид гадаад зах зээл дээрх орон зайгаа тэлэх боломжтой ХАА-н бүтээгдэхүүн бол мах, махан бүтээгдэхүүн, ноос, ноолууран бүтээгдэхүүн гэж гарсан билээ. Эдгээр бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх боломжийн талаар энэ хэсэгт дэлгэрүүлж авч үзье.

### *Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх боломж*

Хуучин ЗХУ байх үед жилд дундажаар 60 гаруй мянган тонн мах Монгол улс экспортолдог байсан (UNDP, 2009) бол 2014 оны байдлаар 2.6 мянган тонн мах экспортолжээ. Энэ хүрээнд Монгол улсын худалдааны гол түнш болох БНХАУ, ОХУ, Япон улсыг сонгон тэдний зүгээс мах, махан бүтээгдэхүүний импортод тавигдах шаардлага, стандартын талаар судлах шаардлагатай (дэлгэрэнгүйг Хавсралтаас үзнэ үү). БНХАУ-ын импортын хүнсний эрүүл ахуйн шаардлага нөгөө хоёр улсынхаас харьцангуй бага бөгөөд бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийхдээцөөн тооны бичиг баримт бүрдүүлэх шаардлагатай байдаг. Энэ үйл ажиллагаа цаг хугацаа шаардаж, процедурын тодорхойгүй байдал үүсгэж экспортлогчдод хүндрэл учруулж болзошгүй. Гэхдээ БНХАУ ХАА-н бүтээгдэхүүнд дунджаар 15.8 хувийн тариф тогтоосон нь манай экспортлогчдод таатай боломж байгааг илэрхийлж байна.

**ХҮСНЭГТ 1.3 Импортлогчдын бүтээгдэхүүнд тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэх**

| | | **Төлөв байдал** | | |
|---|---|---|---|---|
| | | БНХАУ | Япон | ОХУ |
| **Мах, махан бүтээгдэхүүн** | Эрүүл ахуйн стандарт | | x | x |
| | Чанар | ü | x | |
| | Зах зээлийн шаардлага | ü | x | |
| | Зах зээлийн боломж | ü | ü | ü |

*Эх сурвалж: (Enkhbold, V., Nomintsetseg, U., Bolor, B., 2015)*

Харин Япон улсын зүгээс тавьдаг хүнсний аюулгүй байдлын стандарт маш өндөр бөгөөд манай улсын мах, махан бүтээгдэхүүн уг шаардлагыг хангахгүй байна. Тус улс үхрийн маханд 38.5 хувийн өндөр тариф тавьдаг боловч хонь, адууны махны татваргүй. Энэ нь манай улс махны чанараа дээшлүүлэх замаар тус улсад экспортоо нэмэгдүүлэх боломжтойг харуулж байна (Enkhbold, V., Nomintsetseg, U., Bolor, B., 2015).

Махны экспортын хэмжээг хэр нэмэгдүүлэх боломжтой вэ? Үхэр, адуу, хонины махны экспортлох боломжит хэмжээ буюу дотоодын хүчин чадлыг тооцохдоо малын тоо толгойг бууруулахгүйгээр 2014 оны түвшинд хадгалан, 2015 онд хэдий хэмжээтэйг экспортлох боломжтойг тооцоолъё. Ингэхдээ 2015 онд малын тоо толгой өмнөх онтой адил өснө гэж үзэж, дотоодын хэрэглээг харгалзан тоо толгойн цэвэр өсөлтийг олж, үүнийгээ гулуузны жингээр үржүүлэн экспортлох боломжтой хэмжээг тодорхойлъё (Хүснэгт 1.4). Өөрөөр хэлбэл, 2015 онд малын тоо толгойг өмнөх оны түвшинд барьж, дотоодын хэрэгцээнээс үлдсэн хэсгийг экспортлоно гэж үзлээ. Тооцооллоос харахад 56.6 мянган тонн хонины мах, 68.6 мянган тонн үхрийн мах, 47.3 мянган тонн адууны мах тус тус экпортлох

боломжтой ба үүнээс нийтдээ 633 сая ам.долларын экспортын орлого олох боломжтой байна.

**ХҮСНЭГТ 1.4 Махны экспортын боломжит орлогын тооцоо**

| | Малын өсөлт, % | Малын тоо, мян.толгой | Дотоодын хүнсэнд, мян.толгой | | Боломжит экспорт, мян.тн | Гулуузны жин, кг | Боломжит экспорт, мян.тн | Үнэ, ам.доллар /кг | Экспортын боломжит орлого, сая ам.доллар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2014 | 2014, 2015 | 2014 | 2015* | 2015* | 2015* | 2015* | 2015* | 2015* |
| **Хонь** | 15.7 | 23,215 | 4,996 | 5,105 | 3,540 | 16 | 56.6 | 2.9 | 164.2 |
| **Үхэр** | 17.3 | 3,414 | 436 | 445 | 581 | 118 | 68.6 | 4.9 | 336.2 |
| **Адуу** | 14.4 | 2,996 | 239 | 244 | 426 | 111 | 47.3 | 2.8 | 132.5 |
| **Махны экспортын боломжит орлого, сая ам.доллар** | | | | | | | | | 633.0 |

*Эх сурвалж: (Статистикийн Мэдээллийн Нэгдсэн Сан, 2015), (Х.Золжаргал, 2014) (Т.Сэмчин, 2015), (IMF, 2014)*

Энэ тооцоололд байгаль цаг уурын нөлөөг тооцоогүй бөгөөд зуд, ган зэрэг байгалийн гамшиг тохиолдвол малын тоо толгойн өсөлт ихээхэн буурч үр дүн өөрчлөгдөж болно. Мөн экспортын үнийг хонины мах 2.9 ам.доллар, үхрийн мах 4.9 ам.доллар, адууны мах 2.8 ам.доллар гэж үзсэн. Дотоодын үнэ үүнээс өндөр байх тохиолдолд экспортлох боломж хумигдана. Одоогоор хонины цул мах 3.8 ам.доллар (7490 төгрөг) буюу дэлхийн зах зээлийн үнээс 35% өндөр, үхрийн цул мах 5.0 ам.доллар (9835 төгрөг) буюу дэлхийн зах зээлийн үнээс 10% өндөр байна[14]. Хэдийгээр сүүлийн жилүүдэд төгрөгийн ханш суларч, дэлхийн зах зээл дээрх махны үнэ өссөн боловч махны дотоодын үнэ дэлхийн зах зээлийн үнээс өндөр хэвээр байгаа юм.

Бүс нутгийн хэмжээнд, ялангуяа хөрш орнуудын эдийн засаг улам бүр тэлж, үүнтэй зэрэгцээд дундаж давхаргын мах, сүүн бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэх хандлагатай байна. Гэхдээ ОХУ-ын хувьд ЕХ, АНУ, Канад, Норвеги, Австрали улсаас хүнсний бүтээгдэхүүн импортлохыг хориглосон ч эрүүл ахуйн стандарт өндөр, үнээр өрсөлдөх чадвар сул байгаа нь манай улсын махны экспортоо нэмэгдүүлэх боломжийг бууруулж байгаа юм. Иймд юуны өмнө мах, махан бүтээгдэхүүний эрүүл ахуйн стандартыг сайжруулах, дотоодын махны үнийг гадаадын үнээс хямд байлгахын тулд малаас авах ашиг шимийг сайжруулах, МАА-н салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. ХАА-н бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулах цогц бодлогын талаар 3-р бүлэгт дэлгэрэнгүй авч үзэх болно.

### *Ноолуур, ноолууран бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх боломж*

Монголын ноолуур нь ХАА-н салбарын экспортын 88 хувийг, нийт экспортын 5 хувийг бүрдүүлж байна. Монгол улс дэлхийн ноолуурын 21 хувийг нийлүүлж, БНХАУ-ын дараа орж байна (Enkhbold, V., Nomintsetseg, U., Bolor, B., 2015).

[14] Улаанбаатар хотын Хүнсний барааны үнийн 2015 оны 7-р сарын 29-ны өдрийн ажиглалт file:///C:/Users/User/Downloads/7_khonogiin_uniin_taniltsuulga_2015_onii_7-r_sariin_29(2015-01-01).pdf

Боловсруулаагүй болон хагас боловсруулсан (угаасан, самнасан) ноолуурын экспортын харьцангуй давуу тал их байгаа нь өмнөх хэсгийн шинжилгээнээс харагдсан. Мөн одоогоор дотоодын хэрэглээ бага, ноолуурын дотоодын үнэ гадаад зах зээлийн үнээс шууд хамаардаг болохыг өмнө нь харуулсан. Гэхдээ боловсруулаагүй, хагас боловсруулсан ноолуурын экспорт 2014 онд 286 сая ам.долларт хүрсэн бол ноолууран хувцасны экспорт үүний 10%-д ч хүрэхгүй байна.

Монголын ноос, ноолууран бүтээгдэхүүнийг экспортлоход учирдаг гол гурван бэрхшээл нь: Нэгдүгээрт, Монгол улс жижиг, далайд гарцгүй, хоёрдугаарт, тогтвортой, их хэмжээгээр нийлүүлэх боломжгүй, гуравдугаарт, чанар муутай зэрэг болно. Тухайлбал, дэлхийн зах зээлд бэлэн бүтээгдэхүүнийг их хэмжээгээр гаргах боломж муу, бүтээгдэхүүний сурталчилгаа сул байна. Монгол улсын хэмжээнд нийт 1.6 сая ширхэг ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, гадаадын харилцагч их хэмжээгээр захиалга өгөхөд тогтвортой ханган нийлүүлэх боломж хязгаарлагдмал байдаг. Чанарын хувьд гол өрсөлдөгч болох Хятадын түүхий ноолуурын чанарт хүрдэггүй тул тансаг бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд гологддог (Г.Ёндонсамбуу, 2015).

Ноолуурын чанарын гол үзүүлэлт болох ноолуурын дундаж голчийг дэлхийн ноолуурын зах зээлийн гол гурван нийлүүлэгчдийн хувьд авч үзэхэд монгол ноолуур 16.0-16.8 мкм байхад хятад ноолуурын хувьд 15.6 мкм, иран ноолуурын хувьд 17.4 мкм байна (Г.Ганбат, 2012).

**ХҮСНЭГТ 1.5 Ноолуурын чанарын үзүүлэлт, орноор**

| | Монгол | Хятад | Иран |
|---|---|---|---|
| Ноолуурын диаметр (микрон) | 16.0-16.8 | 15.6 | 17.4 |
| Урт (мм) | 40-45 | 42-38 | 21.4-38.8 |
| Өнгө | 60% тод | 100% тод | Саарал |

*Эх сурвалж: (Г.Ганбат, 2012)*

Энэхүү чанараа дагаад үнэ нь зах зээл дээр тогтдог. Тухайлбал, Шнэйдэрийн Ноолуурын зах зээлийн индикатор[15]-аар 2015 оны 7 сарын эцсийн байдлаар хятад ноолуур 124.7 байхад монгол ноолуур 88.8, иран ноолуур 85.9 байна. Өөрөөр хэлбэл, монгол ноолуурын үнэ хятад ноолуурын үнээс 40 хувиар хямдаар үнэлэгдэж байна (Shneider, 2015).

1958-1965 онуудад ноолуурын чиглэлээр ямааг донын хавийн үүлдрээр эрлийзжүүлж, 1965-1971 онуудад эрлийз ямааг өөр дотор нь үржүүлж тохиромжтой хэвшлийн ямаан сүрэг бий болгосон, 1971-1983 онуудад шинэ үүлдрийн ямааг олшруулах, 1983 оноос хойш үүлдрийн ямааны үржил, ашиг

[15] Schneider Cashmere Market Indicatorsүзүүлэлт нь ам.доллар дээр суурьласан боловч үнэ биш бөгөөд ханшийн хэлбэлзэлээс хамаарахгүй.

шимийн чанарыг шинэчлэн тодорхойлж, үржил селекцийн ажлыг тодорхойлох зэрэг ажлуудыг хийж байсны үр дүнд 1980-аад оны сүүлээр монгол ноолуурын чанар эрс сайжирч 1988-1990 онд хятад ноолуурын үнээс 8-10 хувиар л хямд болж ирсэн (МАА-н эрдэм шинжилгээний хүрээлэн, 2013). Гэвч 1990-ээд оны эхээр малыг хувьчилснаар малын гаралтай бүтээгдэхүүнийг сайжруулах талаар төрөөс хийгдэж байсан ажил доголдож, мөн мал эмнэлгийн үйлчилгээ эрс муудсан (Дэлхийн банк, Мал Ахуйн Салбарын Судалгаа, 2008). Үүний уршгаар ноолуурын чанар ч мөн муудсаныг Зураг 2.21-ээс харж болохоор байна.

**ЗУРАГ 1.20 Хятад ноолуурын үнэлгээ өндөр**[16]




**ЗУРАГ 1.21 Монгол ноолуурын үнэлгээ буурсан**[17]




*Эх сурвалж: (Shneider, 2015), Судлаачдын тооцоолол*

Сайн чанарын ноолуур үйлдвэрлэхээ больж, ноолуурын чанарт бус малын тоонд анхаардаг болсоны улмаас ноолуурын чанар муудаж Монголын ноолуураар

16 1988-1997 оны ШНЗЗИ-ийг тухайн оны 2-р сарын 1-ний байдлаарх үзүүлэлтийг авсан бөгөөд 1998-2015 оны үзүүлэлтүүд нь 7-р сарын 31-ны байдлаарх үзүүлэлт болно.

17 Энэхүү зурагт үнийн зөрүүний үзүүлэлтийн хандлагыг харахын тулд Hodrick-Prescot filter-ийг ламбада 5-тай авч трэндийг авч үзүүлэв.

өндөр үнэтэй тансаг зэрэглэлийн эцсийн бүтээгдэхүүн гаргах боломжгүй болсон нь эргээд ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна (Дэлхийн Банк, 2003).

Монгол ноолуурын өрсөлдөх чадварыг сайжруулахад малчдаас эхлээд үйлдвэрлэгчид, бодлого боловсруулагчид, өөрөөр хэлбэл, ямаанаас эхлээд ноолууран бүтээгдэхүүний сурталчилгаа хүртэл анхаарах шаардлагатай байна. Тухайлбал, түүхий эдийн чанар талаас нь малчид дотоодын үйлдвэрлэгчидийн оролцоотойгоор ямааны үүлдэр угсааг сайжруулах, ноолуурыг будах дамжлагад оруулахад хэрэглэгддэг усны чанарыг сайжруулах (ус нь маш зөөлөн байх шаардлагатай), ноос ноолуурыг арчлахад чухал шаардлагатай химийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой болгох, дотоодын ээрэх хүчин чадлыг нэмэгдүүлэх[18], мөн ээрмэлийн чанарыг сайжруулж тогтвортой болгох зэрэг арга хэмжээг авах шаардлагатай байна (Г.Ганбат, 2012).

Ноолуурын чанарыг дээшлүүлэхэд төрийн зохицуулалт, бодлого чухал байна. Тухайлбал, үүлдэр угсааг сайжруулахад анхаарахаас гадна мал заазлалтын хөтөлбөрийг дэмжих шаардлагатай болно. Учир нь ямааны нас өндөр байх тусам ноолуурын чанар мууддаг бөгөөд үүний зохиуулалт нь 3-4 наснаас дээш ямаанд татвар ногдуулах зэрэг арга байж болох юм (Дэлхийн Банк, 2003).

Ямааны тоо толгой өсөх нь хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөтэй. Тухайлбал, ямаа нь бусад таван хошуу малтай харьцуулахад өвсийг хамгийн их зулгааж иддэг бөгөөд энэ нь зарим төрлийн хадан дээр ургадаг ургамал устахад нөлөөлж байна. Мөн ямаа хурц туурайтай тул хөрсийг хооронд нь тогтоон барьдаг зарим төрлийн ургамалд сөргөөр нөлөөлдөг байна. Түүнчлэн говийн бүсэд гардаг хаврын шороон шуурга ямааны тооны өсөлт, түүний сөрөг нөлөөллийн үр дүн байж болохыг Дэлхийн банкны Монголын хүрээлэн буй орчны мониторинг тайланд дурджээ (Дэлхийн банк, 2002).

Иймд ямааны тоо толгойг өсгөх бус ямааны ноолуурын чанарыг сайжруулж, экспортын үнээ нэмэгдүүлэх, мөн ноолуурыг түүхий эд хэлбэрээр бус бүтээгдэхүүн үйлдвэрлэж гаргах тал дээр анхаарах хэрэгтэй байна. Ноолуурын чанарыг 1989 оны түвшинд хүргэснээр 2015 оны байдлаар ноолуураас олох орлогоо 32 хувиар өсгөх боломжтой[19]. Тухайлбал, 32 хувийн орлогын өсөлт нь 2014 оны ноолуурын экспортын орлогын хувьд 92 сая ам.долларын өсөлт буюу ДНБ-ий 0.8% болж байгаа юм.

[18] Утас ээрэх хүчин чадал хангалтгүйн улмаар зарим хувцас үйлдвэрлэгчдийг түүхий эдээ хятад руу ээрэхээр ачин, ээрмэл эдлэлийг боловсруулахаар монголд импортоор оруулахад хүргэдэг

[19] 2015/07/31-ийн Хятад ноолуурын үнэ 124.7 үүнээс 6%-иар хямд гэвэл Монгол ноолуурын үнэ 117.2 болж одоогийн байгаа 88.8-иас 32%-иар өндөр үнэлэгдэхээр байна.

# II БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ХҮМ АМЫН АМЬЖИРГААНЫ ТҮВШИН

ХАА-н салбар нь эдийн засгийн хөгжил, ядуурлыг бууруулахад чухал нөлөө үзүүлдэг болохыг олон судалгааны үр дүн харуулдаг. ХАА нь эдийн засгийн өсөлтөд хүнсний хангамж, ажил эрхлэлт зэрэг олон сувгаар нөлөөлдөг. Бага орлоготой хүмүүсийн нэлээд хэсэг нь ХАА-н салбарт хөдөлмөр эрхэлдэг ба уг салбарын өсөлт ядуурлыг бууруулахад түлхэц үзүүлдэг (World Bank, 2008). ХАА-н салбарын өсөлт, ядуурлын хоорондох сөрөг хамаарлыг тоон шинжилгээгээр судалж харуулсан олон ажил бий (Irz et all,. 2001).

Гэхдээ, ХАА-н салбар нь ядуурлыг бууруулахад үргэлж тус болж чаддаггүй. ХАА салбар эдийн засгийн болон байгалийн эрсдэлтэй байнга тулгардаг. Ийм эрсдэлд ялангуяа хөгжиж буй орны малчид, тариаланчид өртөмтгий байдаг. ХАА-н бүтээгдэхүүн экспортлогч орнуудын хувьд дэлхийн зах зээл дээрх үнийн өөрчлөлт нь тэдний амьдралд шууд нөлөөлдөг тул гадаад эдийн засгийн нөхцөл байдалд мэдрэмтгий болно. Байгалийн гамшиг, халдварт өвчин зэрэг эрсдэлүүд хөдөө амьдарч, ажиллаж байгаа иргэдэд хүнд цохилт болдог. Нийт эдийн засагт ХАА-н салбарын эзлэх хувь хөгжингүй, хөгжиж буй орнуудын аль алинд нь буурч байгаа бол үүнтэй зэрэгцэн аж үйлдвэр, үйлчилгээний салбарын эзлэх хувь хурдтай өсч байна (Ruben and Van den Berg 2001).

Судалгааны ажлын энэ хэсэгт Монгол улсын орон нутгийн иргэдийн амьжиргааны түвшин, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг судална. Тухайлбал, ХАА-н салбар орон нутгийн өрхийн амьжиргаа, ядуурालд хэрхэн нөлөөлж байгааг судлах юм. Үүний дүнд өрхийн амьжиргааг дээшлүүлэх, ядуурлыг бууруулахад ХАА-н салбарын бодлого ямар чиглэл барих, өрхийн орлогыг дээшлүүлэхэд ямар бүтээгдэхүүний дэмжлэг илүү үр дүнтэй талаар хариулт өгөх боломжтой болох юм. Мөн энэ судалгаагаар ХАА-н үйлдвэрлэлийн орон нутгийн иргэдийн амьжиргаанд үзүүлэх нөлөөг хэмжихэд тогтмол-нөлөөний (fixed-effect) регрессийн үнэлгээг ашиглалаа. Түүнчлэн, орон нутгийн иргэдийн өрхийн орлого, бодит цалинд ХАА-н салбарын үзүүлэлтүүд, тухайлбал, ХАА-нбүтээгдэхүүний үнэ, малын тоо, орон нутгаас олгосон зээл хэрхэн нөлөөлөхийг үнэллээ.

Эхлээд Монгол улсын ХАА-н салбар ба орон нутгийн өрхийн амьжиргааны түвшний талаар танилцуулна. Дараань үнэлгээний үр дүнг танилцуулж эцэст нь орон нутгийн хүн амын амьжиргааны түвшинг сайжруулах боломжийн талаар авч үзнэ.

## 2.1. Орон нутгийн өрхийн амьжиргааны түвшин

Хотын өрхийн сарын дундаж орлого 2014 оны байдлаар 1174 мянган төгрөг байгаа бол хөдөөгийн өрхийн сарын дундаж орлого 916 мянган төгрөг байна.

Хөдөөгийн өрхийн дундаж орлого нь хотын өрхийн дундаж орлогоос 22% доогуур байна. Энэ зөрүү нь 2008 оноос хойш дорвитой буурахгүй байгаа нь хот хөдөөгийн амьжиргааны түвшин ихээхэн зөрүүтэй байсаар байгааг харуулж байна (Зураг 2.1). 1998 оноос хойш хотын өрхийн нэрлэсэн дундаж орлого 16.1 дахин өссөн бол хөдөөгийн өрхийн дундаж орлого түүнээс багаар, 15.4 дахин өсчээ. Мөн хугацаанд ядуурлын түвшин хотод 20 нэгж хувиар буурч 19 хувь болсон бол хөдөөд дөнгөж 7 нэгж хувиар буурч, ядуурлын түвшин 26 хувьтай байна (Зураг 2.2). Үүнээс үзвэл хөдөөгийн иргэдийн дөрвөн өрхийн нэг нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур амьдралтай байна (ҮСХ, 1998-2014).

**ЗУРАГ 2.1 Хөдөөгийнхний орлого хотынхоос бага**




**ЗУРАГ 2.2 Хөдөөд ядуурал өндөр байна**




*Эх сурвалж: (ҮСХ, 1998-2014)*

Хот, хөдөөгийн өрхийн ялгаатай байдлыг тодруулахын тулд тэдгээрийн орлогын бүтцийг авч үзье. Хотын өрхийн орлогын 60%-ийг цалин, 13%-ийг тэтгэвэр тэтгэмж бүрдүүлдэг бол хөдөөгийн өрхийн орлогын 13%-ийг цалин, 14%-ийг тэтгэвэр тэтгэмж, 38%-ийг мал аж ахуйн орлого бүрдүүлж, 22%-ийг өөрийн

хувийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүн ээлж байна. Өөрөө хэлбэл, үнэгүй хэрэглэсэн хүнсээ оруулбал хөдөөгийн өрхийн орлогын 60% нь мал аж ахуйн салбараас бий болж байна (Зураг 2.3, 2.4) (ҮСХ, 2014). Иймд МАА-н салбарыг хөгжүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх, МАА-н бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах зэрэг нь орон нутгийн иргэдийн амьжиргааг тогтвортой байлгах суурь болж байна.

**ЗУРАГ 2.3. Хотын өрхийн орлого цалингаас**




**ЗУРАГ 2.4. Хөдөөгийн өрхийн орлого МАА-аас хамаарна**




*Эх сурвалж: (ҮСХ, 2014)*

Улаанбаатар хотын дундаж цалинтай харьцуулахад орон нутгийн цалин 26 хувь доогуур байна. 2001 онд энэхүү үзүүлэлт нь 25 хувь байсан бол арав гаруй жилийн хугацаанд бараг өөрчлөгдөөгүй байна. Уул уурхайн олборлолт өндөртэй аймгууд болох Өмнөговь, Орхон, Говьсүмбэр зэрэг аймгуудын дундаж цалин бусад аймгуудыг бодвол өндөр, Орхон аймгийн хувьд Улаанбаатар хотынхоос ч өндөр байна (Зураг 2.5) (ҮСХ, 1998-2014).

Орон нутгийн иргэдийн цалин ийнхүү бага байгаа нь тэдний ихэнхийг бүрдүүлдэг малчдын цалин бусад ажиллагсдынхаас бага байгаатай холбоотой. Улсын дундаж цалин 2014 онд 797 мянган төгрөг байхад ХАА-н салбарт үйл ажиллагаа явуулдаг компанийн дундаж цалин 753 мянган төгрөг байна. Зураг 2.6-гаас харвал ХАА-н салбарын дундаж цалин сүүлийн жилд огцом өссөн харагдаж байгаа боловч ҮСХ-ны дундаж цалинг тооцох аргачлал өөрчлөгдсөнөөс болсон байж болох юм. Тухайлбал, 2014 оноос өмнө дундаж цалинг тооцохдоо 1020 компаниас түүвэр судалгаа авч хийдэг байсан бол 2014 оноос Нийгмийн даатгалын мэдээллийн сангийн 35 мянга орчим компаний мэдээлэл дээр үндэслэж гаргадаг болсон. Харин ХАА-н мэргэжилтэй ажилтны цалин 433 мянган төгрөг байгаа нь улсын дундаж цалингаас 1.8 дахин бага байна (С.Дарьмаа, 2015).

**ЗУРАГ 2.5. Хот, хөдөөгийн орлогын ялгаа өндөр**



**ЗУРАГ 2.6 ХАА-н ажилтны цалин бага байна**[20]




*Эх сурвалж: (ҮСХ, 1998-2014)*

Орон нутгийн иргэдийн орлогод МАА-н орлого дийлэнх хувийг бүрдүүлж байгаа тул МАА-н үйлдвэрлэл, малын тоо толгойн өсөлт тэдний орлогод шууд нөлөөлнө. Монголын МАА нь уламжлалт, бэлчээрийн аж ахуй бөгөөд цаг агаарын нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай. Тухайлбал, 2000-2002 оны жил дараалсан зуднаар их хэмжээний мал хорогдож, малчин өрхийн дундаж малын тоо 26-аар буюу 21% буурсан байна. Мөн 2010 оны зуднаар нэг малчин өрхийн мал дунджаар 43-аар буюу 22% буурчээ. 1999 онд малтай өрх дунджаар 124 толгой малтай байсан бол 2014 оны байдлаар нэг малтай өрх дунджаар 244 толгой малтай болж өссөн байна (Зураг 2.7). 1999 онд 70-аад мянган өрх 101-200 малтай байсан бол 2000-2002 оны зудны дараа 101-200 толгой малтай өрх 50 мянга хүрэхгүй болтлоо буурчээ. 2010 оны зуднаас өмнө 201-500 толгой малтай 55 мянган өрх байсан бол зудны дараа 40 мянга болтлоо буурчээ (Зураг 2.8). Үүнээс харахад малчин өрхийн орлогын гол эх үүсвэр болох малын тоо толгой байгаль цаг уурын нөхцөлөөс хамаарч тогтворгүй байгаа нь тэдний тогтвортой амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна. Үүнээс гадна малын бэлчээрийн даац, ургамлын бүтэц, талхигдал, дахин сэргэх чадавхи зэрэг хүчин зүйлс малчдын амьжиргаанд чухал нөлөөтэй юм. Швейцарын хөгжлийн агентлагийн судалгаанаас (SDC, 2015) харахад манай улсын нийт бэлчээрийн 60 орчим хувь нь бэлчээрийн доройтолд оржээ. Үүний 15 хувь нь дахин сэргэхэд 10 жил шаардагдах бөгөөд Архангай, Булган Төв Аймаг, Дундговь, Сэлэнгэ аймгуудад бэлчээрийн доройтол хамгийн хүнд байгаа ажээ. Үүний үндсэн шалтгаан нь тухайн бэлчээрт ногдох малын тоо хэт их, зохисгүй харьцаатай, талхлалт ихтэй байгаа явдал юм. Иймд бэлчээрийн дахин сэргэлт, шим тэжээл бүхий

[20] 2013 онд улсын дундаж цалинг тооцохдоо 100-с доош ажиллагсадтай, 100 ба түүнээс дээш ажиллагсадтай гэж гаргасан бөгөөд нэгдсэн дундаж цалингийн үзүүлэлтийг гаргаагүй болно.

ургамлын бүтцийг хадгалахын тулд бэлчээрийн 50 хувийг ашиглаж, үлдсэн 50 хувийг хадгалах олон улсын стандарт бүхий бэлчээрийн зохистой ашиглалтын менежментийг нэвтрүүлэх хэрэгтэй юм.

**ЗУРАГ 2.7 Малчин өрх дунджаар 244 малтай**




**ЗУРАГ 2.8 201-500 малтай 60-аад мянган өрх байна**




*Эх сурвалж: (Статистикийн Мэдээллийн Нэгдсэн Сан, 2015)*

Малчин өрхийн орлого малын тоо толгойноос гадна малын гаралтай бүтээгдэхүүний үнээс ихээхэн шалтгаалах нь ойлгомжтой. Малчдын орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлэгч мах, ноолуурын үнийг авч үзье. Хонины махны үнэ 2012 онд огцом өсч, түүнээс хойш харьцангуй тогтвортой байна. Ноолуурын үнэ 2008 онд огцом бууж, 2009-2010, 2013-2014 онд огцом өсч, 2011, 2012 онд тогтвортой байжээ. 2010 оны зуднаар их хэмжээний мал хорогдсон боловч мах, ноолуурын үнэ өссөн тул малчдын орлого бага боловч нэмэгджээ. Ийнхүү сүүлийн 5 жилийн хугацаанд хөдөөгийн өрхийн орлого эрс өсөхөд малын тооноос гадна малын гаралтай бүтээгдэхүүний үнийн өсөлт нөлөөлжээ.

**ЗУРАГ 2.9 Мах ноолуурын үнэ өндөр байна**




**ЗУРАГ 2.10 Малын тоо сүүлийн 5 жилд огцом өслөө**




*Эх сурвалж: (Статистикийн Мэдээллийн Нэгдсэн Сан, 2015)*

Ноолуурын үнэ үндсэндээ гадаад зах зээл дээр тодорхойлогддог. Ноолуурын үйлдвэрлэлийн дийлэнх хэсгийг экспортод гаргадаг тул дотоодын үнэ экспортын үнээс хамаарч байгааг Зураг 2.11-ээс харж болно. Энд үзүүлсэн экспортын үнэ нь угаагаагүй, угаасан, самнасан ноолуурын жигнэсэн дундаж үнэ бөгөөд түүхий ноолуур нь 75%-ийн угаасан ноолуур ба 50%-ийн самнасан ноолууртай тэнцэнэ гэж үзээд жигнэв[21]. Экспортын үнэ ам.доллар эсвэл юаниар, дотоодын үнэ төгрөгөөр илэрхийлэгдэнэ. Тухайлбал, 2011 онд гадаад зах зээл дээр ноолуурын үнэ өссөн боловч дотоодод төгрөгийн ханш чангарсан нь ноолуурын дотоодын үнийг өсгөөгүй байна (Зураг 2.12).

---

21 "Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх журам", Засгийн газрын 2014 оны 87 дугаар тогтоолын хавсралт: Түүхий ноолуурыг угаасны дараа 70-75%-тай тэнцэх угаасан ноолуур гарна, түүхий ноолуурыг угааж, самнасны дараа 45-50%-тай тэнцэх хэмжээний самнасан ноолуур гарна (Засгийн газрын 2014 оны 87-р тогтоолын хавсралт, 2014).

**ЗУРАГ 2.11 Ноолуурын үнэ гадаад үнийг дагаж байна**




**ЗУРАГ 2.12 Ханш ноолуурын үнэд нөлөөлнө**




*Эх сурвалж: (Статистикийн Мэдээллийн Нэгдсэн Сан, 2015), (Гаалийн Ерөнхий Газар, 2015)*

МАА-н гол бүтээгдэхүүн болох хонины махны үнэ аймгуудад хэр ялгаатай байгаа, энэхүү ялгаа хэрхэн өөрчлөгдөж байгааг Зураг 2.13, Зураг 2.14-д харууллаа. 2008 онд орон нутагт хонины махны үнэ Улаанбаатар хотын үнээс дунджаар 10 хувиар бага байсан бол 2014 онд 2%-иар бага болж үнийн зөрүү буурчээ. Ялангуяа сүүлийн 5 жилд үнийн зөрүү огцом буурсан нь орон нутаг руу тавьсан хатуу хучилттай зам нэмэгдсэнтэй холбоотой. Тухайлбал, 2010 онд Монгол улсын хэмжээнд хатуу хучилттай замын урт 3.0 мянган км байсан бол 2014 онд 6.5 мянган км болж 2.2 дахин өсчээ. Баян-Өлгий, Баянхонгор, Сүхбаатар, Говь-Алтай, Дорнод, Сүхбаатар зэрэг төвөөс алслагдсан аймгуудад махны үнэ бага байх хандлагатай байгаа бол уул уурхайн салбар хөгжсөн Өмнөговь, Орхон аймгуудад махны үнэ өндөр байна. Дэд бүтэц, зам сайжрахын хэрээр МАА-н бүтээгдэхүүний тээврийн зардал буурч, орон нутгийн аж ахуй эрхлэгчид Улаанбаатар гэх мэт төвлөрсөн зах зээлийн үнээр бүтээгдэхүүнээ борлуулах боломж гарлаа.

**ЗУРАГ 2.13 Махны үнэ хот, хөдөөд адил байна**




**ЗУРАГ 2.14 Алслагдсан байдал, махны үнийн зөрүү**




*Эх сурвалж: (Статистикийн Мэдээллийн Нэгдсэн Сан, 2015)*

Хөдөөгийн өрхүүдийн санхүүгийн зах зээлийн хүртээмжийг авч үзвэл, 2014 оны байдлаар орон нутагт олгож буй зээлийн хэмжээ 2.8 их наяд төгрөг байгаа нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 22%-ийг эзэлж байна. Мөн тухайн онд ХАА-н салбарт 8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгджээ. ХАА-н салбар нь орон нутгийн өрхийн орлогын 60%-ийг бүрдүүлж байхад нийт хөрөнгө оруулалтын 1% хүрэхгүй хэсэг ХАА-д орж байгаа нь хангалтгүй бөгөөд орон нутгийн иргэдийн бүтээмж, цаашлаад орлого өсөхгүй байх нэг нөхцөл болж байна. Өмнө дурдсанчлан орон нутгийн өрхийн 44% нь МАА эрхэлдэг бөгөөд орон нутагт зээлийн хэмжээг нэмэгдүүлбэл орон нутгийн иргэдийн өрхийн аж ахуйг дэмжих хөрөнгө оруулалт болж, МАА-н үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх, улмаар орон нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг нэмэгдүүлэхэд туслана.

**ЗУРАГ 2.15 Орон нутгийн зээлийн хэмжээ бага**




**ЗУРАГ 2.16 ХАА-н хөрөнгө оруулалт маш бага**




*Эх сурвалж: (Статистикийн Мэдээллийн Нэгдсэн Сан, 2015).*

## 2.2. Орон нутгийн хүн амын амьжиргааны түвшинд нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээ

Энэ хэсэгт орон нутгийн хүн амын амьжиргааны түвшинд нөлөөлж буй хүчин зүйлсийг үнэлэх хоёр төрлийн эмпирик үнэлгээг авч үзнэ. Эхний үнэлгээгээр хөдөөгийн иргэдийн орлогод нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлсон бол хоёр дахь үнэлгээгээр аймгуудын цалингийн ялгаатай байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлсон (Хавсралтын Хүснэгт A17, Хүснэгт A18).

Эхний үнэлгээгээр, хөдөөгийн хүн амын амьжиргаанд нөлөөлөгч хүчин зүйлсийг судлахдаа тэдний орлогын гол эх үүсвэр болох МАА-н бүтээгдэхүүний үнэ, малын тоо, орон нутагт олгосон зээлийн хэмжээнээс хамааруулан үнэллээ. 2001-2014 оны тоон мэдээллийг ашиглан хөдөөгийн өрхийн бодит орлогод хонины махны үнэ, ноолуурын үнэ, малын тоо, орон нутагт олгосон зээлийн хэмжээ хэрхэн нөлөөлөхийг судлав. Орон нутгийн зээлийн мэдээ 2001 оноос эхлэн гарсан байдаг тул 2001 оноос өмнөх үнэлгээг хийх боломжгүй юм.

Хоёрдугаар үнэлгээгээр, 2008-2014 оны 22 аймгийн тоон мэдээг ашиглан тухайн аймгийн иргэдийн бодит цалинд хонины махны үнэ, ноолуурын үнэ, тухайн аймгийн өрхийн зээлийн үлдэгдэл, тухайн аймгийн төсвийн орлогын улсын төсвийн орлогод эзлэх хувь хэрхэн нөлөөлөхийг судлав. Тухайн аймагт томоохон уурхай байдаг, энэ уурхайд олон тооны нутгийн иргэд ажилладаг бол хүн амын амьжиргааны түвшин өндөр байж болно. Энэ нөлөөллийг тусгахын тулд аймгийн төсвийн орлогын нийт төсвийн орлогод эзлэх хувийг үнэлгээнд орууллаа. ҮСХ-ноос ноолуурын үнийн мэдээллийг аймгуудаар 2008 оноос эхлэн гаргасан байдаг тул бид үнэлгээг тус оноос эхлүүлэв.

Эхний үнэлгээгээр хонины махны үнэ нэг хувиар өсөхөд хөдөөгийн өрхийн бодит орлого 0.6 хувиар, ноолуурын бодит үнэ 1 хувиар өсөхөд бодит орлого 0.2 хувиар тус тус өсдөг болох нь тогтоогдлоо. Түүнчлэн малын тоо нэг хувиар өсөхөд бодит орлого 2 жилийн дараа 0.9 хувиар, өмнөх жилийн зээлийн үлдэгдэл нэг хувиар өсөхөд тухайн жилийн бодит орлого 0.5 хувиар өсч байна (Хүснэгт 2.1).

**ХҮСНЭГТ 2.1 Хөдөөгийн өрхийн бодит орлогод нөлөөлөх хүчин зүйлсийн үнэлгээ**[22]

| Нөлөөлөгч хүчин зүйлс | Үзүүлэлт | Өрхийн бодит орлогод үзүүлэх нөлөө |
|---|---|---|
| **Махын үнэ** | махны үнэ/ХҮИ | 0.63 |
| **Ноолуурын үнэ** | ноолуурын үнэ/ХҮИ | 0.24 |
| **Малын тоо** | 2 жилийн өмнөх малын тоо | 0.85 |
| **Зээл** | 1 жилийн өмнөх зээлийн өсөлт | 0.52 |

[22] Үнэлгээний дэлгэрэнгүйг Хавсралт 4-ээс харна уу.

Дараах панел үнэлгээгээр хонины махны үнэ нэг хувиар өсөхөд аймгийн түвшний бодит цалин 0.4 хувиар өсч байхад, ноолуурын бодит үнэ 1 хувиар өсөхөд бодит цалин 0.1 хувиар өсч байна. Түүнчлэн малын тоо 1 хувиар өсөхөд бодит цалин дөрвөн жилийн дараа 0.1 хувиар өсч байхад, өмнөх жилийн зээлийн үлдэгдэл 1 хувь өсөхөд тухайн жилийн бодит орлого 0.2 хувь өсч байна. Мөн тухайн аймгийн орлогын нийт төсөвт эзлэх хувь хэмжээ нэг нэгж хувиар өсөхөд тус аймгийн бодит цалин 2.3 хувиар өсдөг байна. Энэ нь тухайн аймагт томоохон уурхай үйл ажиллагаа явуулж байвал тус аймгийн төсөвт оруулах хувь нэмрийг өсгөх төдийгүй дундаж цалинг өсгөдгийг харуулж байна (Хүснэгт 2.2).

**Хүснэгт 2.2 Орон нутгийн иргэдийн бодит цалинд нөлөөлөх хүчин зүйлийн үнэлгээ[23]**

| Нөлөөлөгч хүчин зүйлс | Үзүүлэлт | Орон нутгийн иргэдийн бодит цалинд үзүүлэх нөлөө |
|---|---|---|
| **Махын үнэ** | махны үнэ/ХҮИ | 0.42 |
| **Ноолуурын үнэ** | ноолуурын үнэ/ХҮИ | 0.08 |
| **Малын тоо** | 4 жилийн өмнөх малын тоо | 0.14 |
| **Зээл** | 1 жилийн өмнөх зээлийн өмнөх зээлийн хэмжээ | 0.25 |
| **Тухайн аймгийн онцлог** | 2 жилийн өмнөх аймгийн төсвийн орлогын улсын төсвийн орлогод эзлэх хувь | 2.28 |

Дээрх үнэлгээнүүдийг нэгтгэж дүгнэвэл махны үнэ нэг хувиар нэмэгдэхэд орон нутгийн иргэдийн орлого, цалин 0.4-0.6 хувиар өсдөг, ноолуурын үнэ нэг хувиар өсөхөд бодит орлого, цалин 0.1-0.2 хувиар өсдөг байна. Мөн орон нутагт зээл олголт нэмэгдэх нь тэдний амьжиргаанд эергээр нөлөөлжээ. Малын тооны өсөлт бодит орлогод хүчтэй нөлөөлж буй боловч тухайн орон нутгийн иргэдийн бодит цалинд бага нөлөө үзүүлж байна.

## 2.3. Орон нутгийн хүн амын амьжиргааны түвшинг сайжруулах боломж

Орон нутгийн иргэдийн орлогын гол эх үүсвэр нь МАА юм. Тухайлбал, тэд орлогынхоо 60%-ийг МАА-аас бүрдүүлж байна. Иймд малын тоо толгойг тогтвортой өсгөх, малын гаралтай бүтээгдэхүүний үнэ тогтвортой өсөх, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх нь орон нутгийн иргэдийн амьжиргааг нэмэгдүүлэх гол эх сурвалж юм. Өмнөх хэсэгт хийсэн үнэлгээнээс дүгнэхэд, нэгдүгээрт, орон нутгийн иргэдийн цалин, орлого хонины мах ба ноолуурын үнийн өсөлтөөс мэдэгдэхүйц эерэг хамаарч байгаа нь ***малын гаралтай бүтээгдэхүүний үнийн тогтвортой өсөлт тэдний амьжиргаанд маш чухал болохыг харуулж байна***.

23 Үнэлгээний дэлгэрэнгүйг Хавсралт 4-өөс харна уу.

Хоёрдугаарт, өрхийн амьжиргаа малын тооноос хамааралтай боловч малын тоо толгойн өсөлт цаг агаарын нөхцөл байдлаас ихээхэн хамаарч байгаа нь тэдний тогтвортой амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, нэг малчин өрхийн дундаж малын тоо 2000-2002 оны жил дараалсан зуднаар 21%-иар, 2010 оны зуднаар 22 хувиар буурч байсан. Малчин өрхийн амьжиргааны цаг агаараас хараат байдлыг бууруулахад малын тэжээлийн тариалалт, хадлангийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай боловч малын тэжээлийн тариалалт 1989 оны түвшинтэй харьцуулахад 2014 онд 92 хувь буурчээ.

Гуравдугаарт, орон нутагт нийт хүн амын 54% нь амьдарч байгаа боловч нийт зээлийн 22% нь орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжид олгогдсон байгаа нь тэдний хөрөнгө оруулалт хийж, бүтээмжээ нэмэгдүүлэн, амьжиргаагаа дээшлүүлэхэд санхүүгийн зуучлал хангалтгүй байгааг харуулж байна. Үнэлгээнээс харахад, орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжид олгох зээлийн хэмжээ өсвөл тэдний цалин, орлогыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байна. Түүнчлэн ХАА-н салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалт хангалтгүй, нийт хөрөнгө оруулалтын 1 хувь ХАА-н салбарт ноогдож байгаа нь уг салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх боломжийг олгохгүй байна.

Дүгнэхэд, орон нутгийн хүн амын амьжиргааны түвшин ХАА-н салбарын хөгжлөөс шууд хамаарч байгаа бөгөөд тэдний амьжиргааны түвшинг сайжруулахад ХАА-н салбарыг хөгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна. ХАА-н салбарыг хөгжүүлэх боломжийн талаар дараагийн бүлэгт авч үзнэ.

## III БҮЛЭГ. ХАА-Н САЛБАРЫН ХӨГЖИЛ

ХАА-н салбарын өсөлт зөвхөн ядуу өрхүүдийн амьжиргааг дээшлүүлээд зогсохгүй бусад салбартай харьцуулахад иргэдийн орлогын өсөлтөд дөрөв дахин илүү нөлөө үзүүлдэг (OECD, 2009). Манай орны ХАА-н салбар 2014 оны байдлаар ажиллах хүчний 28%, ДНБ-ий 13.5%-ийг бүрдүүлжээ. Үүнтэй харьцуулахад уул уурхайн салбар ДНБ-ий 17% бүрдүүлж байгаа хэдий ч ажиллах хүчний 3.7%-ийг шингээж байгаа нь улсын хэмжээнд нийт хүн амаа ажлын байраар тогтвортой хангах, хүн амын орлогыг нэмэгдүүлэхэд ХАА-н салбарын үр ашигтай ажиллах нөхцөлийг дэмжих нь чухал болохыг харуулж байна.

ХАА-н бодлогын хүрээнд бүтээмжээ нэмэгдүүлэх асуудлыг тэргүүн зорилтоо болгон тавих нь үр дүнтэй байж болох юм. Кругман (1996, 2001) аливаа улс экпортын хувьд өрсөлдөх чадвартай болох гэж хэт туйлшрах нь буруу төдийгүй аюултай гэдгийг судалгаандаа дурджээ. Дотоодын болон олон улсын эдийн засгийн өсөлтийг дэмжихээсээ илүүтэйгээр хамгаалалтын шинж чанартай бодлого баримтлан худалдааны илүүдлээр тодорхойлогдсон өрсөлдөөн рүү тэмүүлэх нь худалдааны дайн эсвэл бүр валютын дайн үүсгэхэд хүргэж болох талаар тэрээр онцолсон байна. Портер, Кругман нар жинхэнэ өрсөлдөөн бүтээмжээр хэмжигддэг бөгөөд экспортоо нэмэгдүүлэх бус, бүтээмжээ нэмэгдүүлэх нь гол зорилго байх учиртайг мөн тэмдэглэжээ (Latruffe, 2010). Мөн ХАА-н бүтээмжийн өсөлт нь бодит орлогыг нэмэгдүүлж, ажлын байр үүсгэж, хөдөөд фермерийн бус бизнесүүдэд үржүүлэгчийн нөлөө үзүүлж, хүнсний барааны үнэд нөлөөлж, түүгээрээ ядуурлыг бууруулж болдгийг (Schneider & Gugerty, 2011) судалгаа харуулдаг.

ХАА-н салбарт олон тулгамдсан асуудал байгаа боловч зайлшгүй шаардлагатай тэргүүлэх чиглэлээ юуны өмнө зөв тодорхойлох хэрэгтэй. Энэ нь ХАА-н салбар баримжаа, инерцээр бус **инновациар** хөгжих үндэс юм (Ж.Мижиддорж, 2015). ХАА-н хөгжил нь инноваци, инновацийн тогтолцоог шаардаж, мөн эдгээрээс шалтгаалдаг (Rajalahti, 2011). Инноваци нь хөгжсөн болон хөгжиж байгаа орнуудад бүтээмжийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах, эдийн засгийн өсөлтийг авчрах гол эх үүсвэр бөгөөд ажлын байр, орлогын эх үүсвэр бий болгох, ядууралтай тэмцэхэд нийгмийн хөгжлийг чиглүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Манай орны ХАА-н үйлдвэрлэлийн бүтээмж бусад улстай харьцуулахад маш доогуур байгааг бид эхний бүлэгт авч үзсэн билээ. Энэ нь тус салбарт ялангуяа инноваци ашиглан бүтээмжийг дээшлүүлэх, усжуулалт, бордоо, хөрс, технологи, хүлэмж зэрэг олон талаар инновацийг дэмжих, нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх арга зам, орчин, тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Судалгааны энэ бүлэгт ХАА-г хөгжүүлэх чиглэлээр бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх боломжит арга замуудыг судлах батус салбарын хөгжлийн чиг хандлага, авч хэрэгжүүлж буй бодлого, анхаарах шаардлагатай асуудлыг авч үзнэ. Ингэхдээ, ХАА-н тогтвортой өсөлт, хөгжлийг бий болгох чадамж бүхий тогтолцоог бүрдүүлэх асуудлыг, үүнд тулгарч буй сорилтуудыг гаргаж тавихыг чухалчилсан бөгөөд энэ дундаа онцгой чухал гэж үзсэн зарим тогтолцооны бус, процессийн шинж чанартай асуудлуудыг мөн дурдлаа. Нэгэнт тогтолцоо бүрдэн, үүнд оролцогчдын үүрэг оролцоо, уялдаа холбоо тодорхой болсноор тухайн системд оролцогчид өөрсдөө шийдэх шаардлагатай асуудлуудыг гарган тавьж, ХАА-н өсөлт хөгжил тогтолцооны доторх процессийн үйл явцаар биеллээ олох юм.

### 3.1. ХАА-н салбарын хөгжлийн олон улсын чиг хандлага, туршлага

ХАА-г хөгжүүлэх уламжлалт бодлого нь хүнсний аюулгүй байдалд ач холбогдол өгч, малчид, тариаланчдын өрхийн аж ахуйн түвшинд өөрсдийн хэрэгцээгээ ханган, илүү гарсан бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулахад нь туслахыг чухалчилдаг. Харин орчин үеийн хандлагаар, ХАА-г зах зээл гэх том хүрээгээр харж, зах зээлийн хөшүүргийг ашиглан тус салбарт ажиллагсдын ашиг орлогыг нэмэгдүүлэхэд анхаардаг. ХАА-н бүтээгдэхүүн эрэлттэй, зах зээлд нэвтрэх боломжтой байвал малчид, тариаланчид илүү их бүтээгдэхүүн нийлүүлэх идэвх, санаачлага нь нэмэгдэнэ. Энэ нь цаашлаад бүтээмжээ өсгөх, үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх, ашиг орлого, амьдрал ахуйгаа дээшлүүлэх хөшүүрэг болдог.

ХАА-н тогтвортой өсөлт нь технологи ашиглалтын ахиц, фермийн орц, тэдэнд хүрч буй үйлчилгээ болон ХАА-н бүтээгдэхүүний тогтвортой эрэлт зэргээс шалтгаалдаг. Энэ нь ХАА-н хөгжлийн бодлого нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлээс цааш нэмүү өртгийн гинжин холбоотой үйл явцыг харж, өөрөөр хэлбэл, бүтээгдэхүүн хэрэглэгчдэд очих хүртэлх үйл явцад анхаарлаа хандуулахыг шаардаж байдаг. Үүнийг шийдэхийн тулдсүүлийн үед эрчимтэй хэрэглэгдэж буй ойлголтууд болох инновацийн тогтолцоо, нэмүү өртгийн гинжин хэлхээний шинжилгээ, хөгжлийн ХАА-н судалгаа болон нөлөөллийн судалгаа зэргийг ХАА-н судалгааны явцад нэгтгэсэн байх хэрэгтэй. Мөн судалгаа-хөгжлийн тогтолцоо нь (R&D) инновацид хувь нэмрээ оруулдгийг бодолцох учиртай (Anandajayasekeram, Puskur, & Zerfu, 2009).

Фермийн аж ахуй эрхлэгчид, ХАА-н бизнес эрхлэгчид, улс орнууд хоорондоо хамтран ажиллах, өрсөлдөх аль ч тохиолдолд тэд тасралтгүй инноваци хийх хэрэгтэй. Шинжлэх ухаан, технологи дахь хөрөнгө оруулалт нь ХАА-н бүтээмж, инновацийг сайжруулж тогтвортой хадгалах ихэнх стратегийн түлхүүр орц нь болж байдаг. Боловсрол, нэвтрүүлэх үйлчилгээ (extension) зэрэг нь инноваци

бий болоход шаадлагатай зайлшгүй орцууд боловч хангалттай бус бөгөөд бусад нөхцөл, нэмэлт оролцоо хэрэгтэй (Rajalahti, 2011). Мөн инноваци болон бизнесийн хөгжил нь эдгээрийг бий болгоход тохиромжтой орчныг бүрдүүлэхэд шаардагдах нэмэлт хөрөнгө оруулалтгүйгээр биеллээ олдоггүй. ХАА-н инновацийн систем дэх хөрөнгө оруулалт нь агуулгын хувьд тодорхой, тухайн улс болон ХАА-н секторын хөгжлийн шат, алсын хараатай уялдсан байх хэрэгтэй. Нөөц хязгаарлагдмал учраас, ХАА-д оруулах хөрөнгө оруулалт нь үнэлэгдсэн, шаардагдах дараалалаар эрэмбэлэгдсэн, хэрэгцээ, тулгарч буй асуудал, байгаа нөөцдөө нийцүүлж нарийвчилсан байх хэрэгтэйг Дэлхийн банкны судалгаа зөвлөсөн байдаг.

Европын холбооны ХАА-н Судалгааны Хорооноос гаргасан судалгаанд (EU SCAR, 2012) инновацийг дэмжих, бий болгох орчинг бүрдүүлж загварчлах, хэрэгжүүлэх замаар хурдацтай өөрчлөгдөж буй дэлхий ертөнцөд хөдөлмөрийн бүтээмж болоод өрсөлдөх чадвараа сайжруулах арга, тогтолцоо чухал болохыг дурджээ. Үүний тулд Хөдөө аж ахуйн мэдлэг, инновацийн тогтолцооны (ХААМИТ) чадамжийг үнэлэх асуудлыг тавьсан байна. ХААМИТ-д судалгаа, нэвтрүүлэх үйлчилгээ, фермерийн аж ахуй эрхлэгчдийн хоорондох холбоо, хамтын ажиллагаа чухал болохыг тэмдэглэжээ.

ХААМИТ нь оролцогч байгууллагуудад, тэдгээрийн хоорондох холбоо харилцаа, институцийн түвшний дэд бүтэц түүний идэвхжүүлэлт болон төсвийн механизм зэрэгт ач холбогдол өгч “инновацийн тогтолцоог” тодорхойлох ойлголт юм. Хэдий нэвтрүүлэх үйлчилгээ, боловсрол, судалгаа нь гол чухал боловч, фермерийн аж ахуй эрхлэгчдийн шийдвэр гаргалт, тэдний инновац гаргалтад шууд нөлөөлж байдаг олон хүчин зүйл нэмүү өртгийн гинжин хэлхээнд байдаг гэдгийг санаж байх нь чухал юм (Зураг 4.1) (EU SCAR, 2012).

**ЗУРАГ 3.1 Нэмүү өртгийн гинжин хэлхээний ХАА-н инновацид шууд холбогдолтой ХААМИТ дахь оролцогчид**




*Эх сурвалж: (EU SCAR, 2012).*

*Тэмдэглэгээ: Арилжааны үйлчилгээнүүдэд лабораторууд, туршлагажсан мэргэжилтнүүд, удирдлагын программ хангамж, нотариатчид, газар зуучлагчид зэргийг багтаан ойлгоно. Зарим орнуудад стратегийн шийдвэр гаргалтанд нөлөөтэй байдаг гэдэг утгаар нягтлан бодогчид гэж тусад нь тусгайлан оруулсан болно.*

ХАА-н бодлогод төсвийн орлогын тодорхой хэсгийг фермерүүдийн чадавхийг сайжруулах үүднээс инноваци эрэлхийлсэн судалгааг дэмжихэд зориулж байх хэрэгтэй бөгөөд мэдлэг, ноухау-г оролцогчдын хооронд солилцох тоглогчийн үүргийг үүгээрээ гүйцэтгэж болох юм. Инноваци нь байгаа мэдлэгээ ашигласнаар эхэлдэг бөгөөд судалгаанаас хэрэгжүүлэх шат хүртэлх дээрээс доош чиглэсэн шатлалаас илүүтэйгээр доороос дээшээ гэсэн шатлалаар хэрэгжих хэрэглэгчдэд тулгуурласан нийгмийн процесс. (EU SCAR, 2012).

Нөгөө талд, мэдээллийн технологи нь ХАА-н системд оролцогчдын хоорондох харилцаа холбоо, хамтын ажиллагаа, инновацийг бэхжүүлэх түгээх зорилгын хүрээнд хамгийн нийцсэн хэрэгсэл юм. Мэдээллийн технологи нь “мэдээлэл дамжуулагчид” болон “брокерууд” зэрэг бизнес загваруудын, төрийн болон хувийн нэвтрүүлэх үйлчилгээ үзүүлэгчид, зөвлөгөө өгөгчид, фермерүүд болон компаниуд холбогдох, хамтрах үйл явцын, мөн мэдлэг түгээлт, хамтын ажиллагаа, оролцогч бүлгүүдийн хоорондох холбоо харилцаа зэргийн суурь нь болдог. ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээ, боловсролын хүрээнд их сургуулиудаас фермерүүдэд гэсэн чиглэлд суралцах боломжийг нээж өгдөг. ХАА-н инновацийн тогтолцоо ерөнхийдөө цогц, олон хүрээг хамарсан байдаг учраас хэн, ямар зорилтот бүлэг хасагдаж гээгдсэнийг тогтооход хүндрэлтэй. ХАА-н инновацийн тогтолцоо илүү дижитал болсноор тогтолцооны гүйцэтгэлийг илүү үр дүнтэй үнэлэх, олон тооны үйл явцад оролцож байгаа олон тооны оролцогчдын оролцоог тодорхойлох, тэднийг хянах боломж гарч ирдэг (World Bank, 2011).

Зах зээлийн үйл явц болон инноваци нь ХАА-г хөгжүүлэх хангалттай нөхцөл болж чаддаггүй. Инновацийн тогтолцоо нь бизнес эрхлэх ур чадвар (entrepreneurship) болон нэмүү өртгийн гинжин хэлхээ (value chain)-г хамардаг боловч эдгээр асуудалд тус бүрт нь анхаарч, уялдаа холбоог нь хангах хэрэгтэй байдаг (Anandajayasekeram P., 2011). Нэмүү өртгийн гинжин хэлхээ нь өртөг бүтээгдэж байгаа дээш ба доош холбоосыг хамарч, тухайн үе шат буюу нэгж нь нийт системдээ ямар хувь нэмэр оруулж буйг харах боломж олгодог. ХАА-н инновацийн тогтолцоог хувь хүний, фермерийн, бүлэг хоршоодын, аймгийн, улсын, олон улсын түвшинд хэрэгжүүлж болно. Нэмүү өртгийн гинжин хэлхээний шинжилгээ эдгээр түвшинд шаардлагатай оролцоог тодорхойлдог. Хэлхээний дагуу дээш, доош урсаж байгаа мэдээлэл, хэлхээний дамжлагууд дээрх зохион байгуулалт, хамтын ажиллагаанаас үүдэн инноваци бий болдог. Инновацийн тогтолцоо ба нэмүү өртгийн гинжин хэлхээний холбоог доорх зурагт харууллаа (Зураг 3.2).

**ЗУРАГ 3.2 Судалгаа-хөгжил (R&D), нэмүү өртгийн гинжин хэлхээ, инновацийн тогтолцооны уялдаа**

Асуудлыг тодорхойлох алхмууд

Зорилтод бүлгээ тодорхойлно

Зорилтод бүлгийнхээ амьдралын нөхцөлийн талаар өргөн ойлголт олж авна

Зорилтод бүлэг дэх бизнесийн байгууллагуудыг тогтооно.

Тэргүүлэх бизнесийн байгууллагуудын ямар нэмүү өртгийн гинжин хэлхээнд байгааг тогтооно

Тухайн нэмүү өртгийн гинжин хэлхээний гол бүрэлдэхүүн хэсгүүдийг чухал байдлаар нь эрэмбэлэнэ

Тогтоосон гол бүрэлдэхүүн хэсгүүдийнхээ гол асуудлуудыг тодорхойлно

Тодорхойлсон асуудлуудаа шинжилнэ.

Асуудлыг шийдэх гарц, оролцоог тодорхойлно

Хяналт хийнэ

Боломжит оролцоог (intervention) тогтооно

Оролцооны төлөвлөлт, хэрэгжүүлэлт, үнэлгээг хийнэ

Эцсийн хэрэглэгчид ашиглана, бусдад түгээн дэлгэрүүлнэ.

Өөр өөр түвшин дэх инновацийн тогтолцоо

**Үндэсний инновацийн тогтолцоо** (улсын түвшин дэх шинжлэх ухаан технологийн асуудлуудтай ажилллана)

**ХАА-н инновацийн тогтолцоо** (ХАА-н шинжлэх ухаан, технологийн асуудлуудтай ажилллана)

**Секторын бүтээгдэхүүнд суурилсан инновацийн тогтолцоо** (бизнесийн байгууллагуудын нэмүү өртгийн гинжин хэлхээн дээр ажиллана)

**Оролцоонд (intervention) тулгуурласан инновацийн тогтолцоо** (зайлшгүй шийдэх шаардлагатай асуудлууд дээр суурилсан)

***Source:*** *(Anandajayasekeram, Puskur, & Zerfu, 2009)*

## 3.2. Монгол улсын ХАА-н салбарыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, боломж

Энэ хэсэгт Монголын хөдөө аж ахуйн салбарын хөгжил, асуудал, боломжуудыг авч үзнэ. ХАА-н тогтортой хөгжлийг бий болгоход ХАА-н салбарын судалгаа, нэвтрүүлэх үйлчилгээ, ХАА-н боловсрол, болон нэмүү өртийн гинжин хэлхээ чухалболохыг дээр тэмдэглэсэн билээ. Эдгээр нь манай улсын хувьд ямар түвшинд байгааг товчхон авч үзэхдээ эхлээд Зураг 3.2-т ийм үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудыг үйл ажиллагааны чиглэлээр нь тоймлон харууллаа. Монгол улсад ХАА-н салбарыг хөгжүүлэх чиглэлээр ХХААЯ, улсын төсвийн санхүүжилтээр их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагууд ажиллахаас гадна олон улсын байгууллагын санхүүжилтээр төслүүд хэрэгжиж байна (төслүүдийн талаар дэлгэрэнгүйг Хавсралтын Хүснэгт А.19 өөс харж болно).

**ЗУРАГ 3.3. ХАА-г хөгжүүлэх төсөл, чиглэлээр[24]**




*Эх үүсвэр: ("Ногоон Алт" Бэлчээрийн Экосистемийн Удирдлага Төс, 2013)*

ХХААЯ-наас 2014 онд “Төрөөс ХАА-н талаар 2015-2025 онд баримтлах бодлого”-ыг гаргасан. Энэхүү бодлогын баримт бичиг нь ХАА-н гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн. Тухайлбал, уг бодлогод санхүүгийн дэд бүтэц, ХАА-н салбарын эрсдэл, инноваци ба хөгжлийг дэмжиж, салбарын нэмүү өртгийн хэлхээг түлхүү хөгжүүлэх замаар бодлогыг хэрэгжүүлнэ гэж тусгажээ. ХАА-н салбарын бодлогод дараах зарчмыг

[24] Судалгааны чиглэлээр Ус цаг уурын орчны шинжилгээний газар (УЦУОШГ), АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны харьяа Хорнадагийн эрдэм шинжилгээний хүрээлэн, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Хөдөө аж ахуйн их сургууль (ХААИС), Экстеншн буюу нэвтрүүлэлтийн чиглэлээр сүүлийн хоёр байгууллагаас гадна ХАА-н үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв (ХААҮШУОНТ), Малын эрүүл мэнд (МЭМ) төсөл болон орон нутгийн захилгаа, хэвлэл мэдээллийн байгууллагууд, Сумын бэлчээр ашиглагчдын холбоо (СБАХ), Бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ), төрийн бус байгууллага (ТББ)-ууд, Худалдаа аж үйлдвэрийн тэнхим (ХАҮТ), Монголын ХАА-н хоршоологчдын үндэсний холбоо (МХААХҮХ) зэрэг байгууллагууд ажиллаж байна. Маркетингийн чиглэлээр ХААЯ, СБАХ, БАХ, ХАҮТ, МХААХҮХ-ээс гадна Азийн хөгжлийн банк (АХБ)-ны төслүүд ажиллаж байна.

баримтална. Үүнд: цаашид салбарын бүтээмжийг механикжуулалт, өндөр технологи нэвтрүүлэх, нэгжээс авах чанар, гарцыг өсгөх замаар нэмэгдүүлэх; ХАА-н салбарын байгаль, цаг уурын өөрчлөлтөөс хамаарах эрсдэлийг бууруулж, үйлдвэрлэлийн улирлын хамаарлыг багасгаж тогтвортой байдлыг хангах; Салбарын үйлдвэрлэлийн нэмүү өртгийн гинжин хэлхээг хөгжүүлэх, ХАА-н гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх; Дотоодын хүнсний хэрэгцээг хангаж, экспортлох; Санхүүгийн дэд бүтцийг хөгжүүлж, санхүүгийн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, урт хугацааны төсвийн болон мөнгөний тогтвортой бодлогоор салбарыг дэмжинэ.

ХАА-н эрсдэлийг бууруулахдаа нэгдүгээрт, цаг агаарын өөрчлөлт зуд болон ган, хоёрдугаарт, бодлогын тогтвортой байдал, гуравдугаарт, малын халдварт өвчин, дөрөвдүгээрт, үнийн хэлбэлзлийг бууруулах систем бий болгоно. Салбарын үйлдвэрлэлийн “судалгаа ба хөгжил”-ийг дэмжиж, өндөр технологид суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. Экспортлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх нэмүү өртгийн гинжин хэлхээг “Тэргүүлэгч компани”-уудыг бий болгох замаар хөгжүүлнэ гэсэн байна.

Монгол улсын ХАА-н салбарыг хөгжүүлэх бодлогын талаар эхлээд ХАА-н судалгаа, дараа нь ХАА-н нэвтрүүлэлт (экстейншн), ХАА-н боловсрол, сургалт, ХАА-н хөрөнгө оруулалт гэсэн дэд хэсгүүдээр авч үзнэ.

***ХАА-н судалгаа***

ХАА-н шинжлэх ухаан болон бусад салбарыг хамарсан шинжлэх ухаан-технологийн тогтолцоо нь инноваци хөгжүүлэх боломжийг үүсгэн, тогтвортой, хүртээмжтэй ХАА-н хөгжилд хувь нэмэр оруулна гэж үздэг. Мэдлэгийг бий болгож, түүнийгээ улс орны хэмжээнд, ялангуяа орон нутгийн түвшинд хэрэглэхгүйгээр хөгжил урагшлахгүй.

Манай улсад шинжлэх ухаан технологийн салбарт 2014 онд нийт 1196 эрдэм шинжилгээний ажилтан ажиллаж байсан бол тэдгээрийн 22% нь ХАА-н салбарт харъяалагдаж буй нь чамлахааргүй үзүүлэлт юм. Сүүлийн жилүүдэд шинжлэх ухааны ажлын цар хүрээ улам тэлж буй бөгөөд ХААИС 2008 онд 29 шинжлэх ухаан-технологийн төсөл, 15 онолын судалгааны ажил гүйцэтгэсэн нь 2003 оныхтой харьцуулахад 33% нэмэгдсэн байна. Харин 2015 оны байдлаар ХААИС, харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд ХАА-н шинжлэх ухаан технологийн төсөл 19, инновацийн төсөл 8, онолын суурь судалгааны төсөл 6-г хэрэгжүүлж байна (ХАА-н Шинжлэх Ухааны Академи, 2015).

Судалгааны үр дүнг бизнест өргөн хүрээгээр ашиглах нь ХАА-н салбарын хөгжлийг түргэтгэх тул судлаачид, тэдний ажлыг ХАА-н бизнес эрхлэгчид,

хувийн секторынхонтой холбох үйл ажиллагааг боловсронгуй болгоход анхаарах хэрэгтэй байна. Үүний тулд өмнө дурдсан олон улсын түвшний судалгаа болон нэвтрүүлэх үйлчилгээнд гарч байгаа туршлагуудыг дэлгэрүүлэх хэрэгтэй. Ялангуяа, судалгааны байгууллагуудын удирдах зөвлөлд болон зөвлөгөө өгөх байгууллагуудад малчид, тариаланчид, ХАА-н бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлж судалгааны шийдвэр, тэргүүлэх чиглэлд тэдний нөлөөг бодитой болгохын зэрэгцээ судалгааныүр дүнг амьдралд хэрэгжүүлэх тал дээр мэдээлэл солилцож түншлэх бололцоог бизнес эрхлэгчид судлаачдад олгох талбарыг бий болгох хэрэгтэй байгаа юм.

***ХАА-н нэвтрүүлэх үйлчилгээ (extention) болон зөвлөх үйлчилгээ***

Манай орны хувьд ХАА-н салбарт тулгамдаж буй нэг бэрхшээл бол боловсрол, эрдэмшинжилгээний хөгжлийн өнөөгийн түвшин дэх мэдлэг, инновацийн нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулдаг нэвтрүүлэх үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгаа явдал юм. Энэ нь институцийн тохиромжтой орчин, үзэл баримтлал буюу “Хөдөө аж ахуйн инновацийн тогтолцоо” төлөвшиж амжаагүйтэй холбоотой.

Манай улсад ХХААЯ-ны харъяа ХАА-н үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх төв 1996 оноос, ХААИС-нй харъяа Экстейншиний сургалтын төв 2006 оноос хойш нэвтрүүлэх үйлчилгээ үзүүлж буй боловч сургалт, зөвлөх үйлчилгээнд голлон анхаарч, инноваци нэвтрүүлэх үйл ажиллагааг орхигдуулж иржээ. Тухайлбал, сүүлийн гурван жилийн хугацаанд 20 гаруй сургалт хийж, 21 аймгийн 900 гаруй хүнийг хамруулж зөвлөгөө өгсөн байна (Mongol News, 2015). Энэ чиглэлээр хандивлагч орнуудаас санхүүжилт авахад хялбар байдаг нь нэвтрүүлэх үйлчилгээг тасалдалгүй хүргэх боломж бүрдүүлж буй боловч, нөгөө талаас,энэ үйлчилгээний хөгжлийг дараагийн түвшинд гаргахад саад болж байна (Б.Эрдэнэболор & А.Бакей, 2009). Тухайлбал, малын мах, ноосны гарцыг сайжруулах чиглэлээр эрдэмтэн судлаачид төслөө уг төвд ирүүлдэг боловч санхүүжилт байхгүйн улмаас дээрх төслүүдийг хэрэгжүүлж, малчид судлаачдыг холбох үүрэгтэй тус байгууллага үүргээ бүрэн гүйцэтгэж чаддаггүй байна (Mongolia Economy, 2012).

Нөгөө талаар, олон улсын түвшинд гарч байгаа ололт амжилтуудаас суралцах нь ХАА-н салбарт инновацийг нэвтрүүлэх нэг гол алхам юм. Монгол орны бүх аймаг, сум шилэн кабелийн интернэтэд холбогдсон учраас үүнийг ашиглан мэдээлэл түгээх, ХАА-н салбарт оролцогчдын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, судалгаа ололтыг түгээхэд мэдээллийн технологийг идэвхитэй ашиглах нь энэ салбарын хөгжлийг түргэтгэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэнэ. Өнөөгийн байдлаар фермерүүд, малчдын мэдээлэл хүлээн авч байгаа гол

эх үүсвэрүүд нь цахим хуудас, Youtube.com, телевиз, цөөн тооны хэвлэмэл ном материалаар хязгаарлагдаж байна. Ялангуяа бичил аж ахуй эрхлэгчдэд нэтврүүлэх үйлчилгээ тэр бүр хүрч чадахгүй, нийтэд дэлгэрэхгүй байна. Энэ нь, нэг талаас, тус салбарын олон нийттэй харилцах чадавх, мэдээлэл түгээж сурталчлах санхүүжилт дутмаг, нөгөө талаас, өөр боломж хайх буюу мэдээлэл солилцох талбар (platform) бий болгох хэрэгтэйг харуулж байна. Иймд ХАА-н холбоод, хоршоодын оролцоотойгоор нэгдсэн мэдээлэл солилцдог цахим хуудас, видео хичээл, зах зээлийн мэдээг илүү ойлгомжтой болгож,өргөн хүрээнд нэвтрүүлбэл ХАА-н салбарын оролцогчид инноваци дэвшүүлэх, ашиглах, түгээн дэлгэрүүлэхэд дөхөм болно.

***ХАА-н боловсрол болон сургалт***

Боловсрол, сургалтын институцууд хүний нөөцийг хөгжүүлж, мэдлэг, технологийн эх үүсвэр болж байдгаараа ХАА-н инновацийн тогтолцоонд чухал юм. ХАА-н боловсрол сургалтын хувьд, гол саадь эдгээр институц хөдөлмөрийн зах зээлд хэрэгтэй мэдлэг, практик чадавхийг олгож чадахгүй байгаад оршиж байна. Ялангуяа ХАА-н бизнес, бизнесийн менежмент, асуудал шийдэх болон хувь хүний дотоод чадавхийг хөгжүүлэх тал дээр уг тогтолцоонд оролцогчдод хангалттай чадамж олгож чадахгүй байгаа юм.

Манай орны хувьд ХАА-н боловсон хүчин бэлтгэх хүрээнд ХААИС-ийн бүрэлдэхүүн 8 сургууль, ХААИС-ийн орон нутаг дахь салбар 3 сургууль, 4 сургалт судалгааны төв ажиллаж байна. Мөн 12 эрдэм шинжилгээний байгууллага, 94 сургалт эрдэм шинжилгээний лаборатори ажиллаж байна. ХААИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын 25 хөтөлбөрт 50 мэргэжлээр 9000 гаруй оюутан ХАА-н чиглэлээр суралцаж, жилд 1500 орчим боловсон хүчин бэлтгэгдэн гардаг. Гэхдээ залуу үеийнхэн бизнес, эдийн засаг, менежментийн мэргэжлийг илүү сонгон суралцах хандлагатай байгаагаас ХАА-н салбарт шаардлагатай инженерийн болоод нарийн мэргэжлийн боловсон хүчин хангалттай бэлтгэгдэж чадахгүй байна. Иймээс боловсролын хөтөлбөр, агуулгад анхаарах хэрэгтэй болжээ.

***ХАА-н салбар дахь хөрөнгө оруулалт***

Шинжлэх ухаан, технологийн хөрөнгө оруулалт нь ХАА-н бүтээмжийг нэмэгдүүлэх нэг гол хүчин зүйл юм. ХАА-н судалгаа, зөвлөх үйлчилгээ, боловсролд хөрөнгө оруулалт нэмэгдвэлсалбарын бүтээмж нэмэгдэх, хэрэглэгчдэд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, салбарын оролцогчдын хамтын ажиллагаа сайжрах, ядуурлыг бууруулах зэрэг эерэг нөлөө үзүүлдэг (ILRI, 2013). 2012 оны байдлаар, манай улсын нэг хүнд ноогдох ХАА-н салбарын зардал БНХАУ-ынхаас 5 дахин, Казакстанаас 3 дахин бага, ОХУ-ынхтай

ойролцоо түвшинд байна. Харин нийт ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ХАА-д зарцуулж буй зардлын эзлэх хувийн хэмжээгээр Хятад 22.8%, Казакстан 14.9%, Орос 8.4% байхад манай улсын хувьд энэ тоо дөнгөж 4.8% байгаа нь ХАА-н салбарт манай улс бага анхаарч байсныг илтгэж байгаа юм (IFPRI, 2015). Түүнчлэн манай улсын хувьд ХАА-н салбарт ноогдох төсөв улсын төсвийн зарцуулалтын 2%-г эзэлж байхад БНХАУ-д 9.5%, Казакстанд 3.6%, ОХУ-д 1% байна (IFPRI, 2015).

2010-2013 онд ХАА-н салбарт 4 сая ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт орсон бөгөөд энэ нь нийт ГШХО-ын 0.04%-г эзэлж байгаа юм (ХХААЯ, 2014). Энэ нь ХАА-н салбар арилжааны хэлбэрээр хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж чадахгүй байгааг, энэ салбарын чадавхийг нэмэгдүүлэх шаардлага байсаар байгааг харуулж байна. Гэхдээ сүүлийн жилүүдэд ХАА-н салбар дахь хөрөнгө оруулалт эрс нэмэгдсэн. Монгол банк, ҮХААЯ-ны хамтарсан үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд 2013-2014 онд нийт 367.7 тэрбум төгрөгийн хөнгөлттэй зээлийг мах бэлтгэл, гурилын үйлдвэрлэл, зоорь, агуулахын барилга, эрчимжсэн МАА-н салбарт олгожээ. Мөн 2013-2014 онд Чингис бонд, Самурай бонд болон ЗГ-ийн үнэт цаасны 689 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг ноос, ноолуур, арьс, шир, сүү, оёдол, хүлэмжийн салбарт хөнгөлттэй зээл хэлбэрээр олгохоор төлөвлөж, 220 тэрбум төгрөгийг олгосон байна. Нийт дүнгээрээ ХАА-н салбарт 2013-2014 онд төсвөөс гадуур 587.7 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Энэ нь 2011-2012 онд ХАА-н салбарт зарцуулж байсан санхүүжилтээс олон дахин давсан дүн юм.

Сүүлийн хоёр жилийн хугацаанд ХАА-н салбарт оруулсан санхүүжилт нь нэмүү өртөгийн гинжин хэлхээний дагуу хийгдсэнээрээ онцлог болсон. Тухайлбал, газар тариалангийн салбарт үр, бордоо, тоног төхөөрөмж зэргээр хангадаг бэлтгэн нийлүүлэгчээр эхлээд ХАА-н үйлдвэрлэгчид болох тариаланч, завсрын үйлдвэрлэгч болох хүлэмж, зоорины салбарынхан мөн ХАА-н эцсийн бүтээгдхүүн болох гурил, махны үйлдвэрүүдэд санхүүжилт олгосон нь ХАА-н салбарыг цогцоор дэмжих бодлого боллоо. Малчид, тариаланчдад урамшуулал олгож, үйлдвэрлэгчдэд хөнгөлттэй зээл олгох байдлаар уг санхүүжилтийг хийсэн болохыг Зураг 3.4-өөс харж болох юм.

**ЗУРАГ 3.4. ХАА-н салбарт олгосон хөнгөлттэй зээл, урамшуулал, нэмүү өртөгийн гинжин хэлхээгээр**




*Эх сурвалж: (Х.Золжаргал, 2014)*

## 3.3. ХАА-н салбарыг хөгжүүлэх боломж, шийдвэрлэх шаардлагатай асуудлууд

ХАА-н салбарын судалгаа нь бизнестэй холбогдох байдал нь сул байна. Мөн хэрэглээний судалгаа (applied research) нь голдуу шинжлэх ухааны үр дүн гаргахад чиглэхээс, практикт холбогдох байдлаар хийгдэх нь бага байна. Манай орны хувьд инноваци, инновацийн тогтолцооны одоогийн байдлыг үнэлэх, хянах механизм байхгүй бөгөөд нөгөө талдаа агуулгын хувьд энэ ажлыг хийхэд хүч хөдөлмөр шаардагдах нь дамжиггүй.

Монгол улсын хувьд ХАА-н инновацийн тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд ХАА-н тэргүүлэх салбаруудын **нэмүү өртгийн гинжин хэлхээнд** тулгарч буй суурь асуудлуудад анхаарал хандуулбал илүү үр дүнтэй байх юм. Малчны хотноос эцсийн бүтээгдэхүүн болж зарагдах цэг хүртэлх МАА-н салбарын нэмүү өртгийн гинжин хэлхээний нарийвчилсан шинжилгээг АНУ-ын олон улсын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэй хийсэн байдаг (EPRC, 2005). Энэ төрлийн шинжилгээг ХАА-н бусад салбарт хийж, өртгийг бууруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх боломжийг судлах хэрэгтэй. Салбарын хэлхээний нэгжүүд дээр олон ТББ байгуулагдаж, ХАА-н салбарт ажиллагсад эрх ашгаа хамгаалахаар ажиллаж байгаа боловч, эдгээр нь инновацийг нэвтрүүлэх, тухайн салбарын бүтээмжийг өсгөх инновацийн талбар болж чадахгүй байна. Иймд

эдгээр байгууллагыг инновацийг нэвтрүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулах мөн нэмүү өртгийн хэлхээ болон инновацийн тогтолцоог уялдуулах зөөлөн дэд бүтцийг бий болгох дээр анхаарах шаардлагатай байна.

ХАА-н салбарын тогтвортой өсөлт, хөгжлийг дэмжихийн тулд үйлдвэрлэгчдийг үр ашигтай ажиллах боломжоор нь хангаж өгөх ёстой. ХАА-д тулгарч буй тээвэр логистик, судалгааг практикт буулгаж хэрэглэх, хөдөөгийн дэд бүтэц, санхүүгийн үйлчилгээ зэрэг олон асуудлуудад оновчтой гарцыг ХАА-д оролцогчдын хамтын ажиллагааны үр дүнд гаргаж ирэх, гарцаа Засгийн газар, олон улсын байгууллагуудын тусламжтайгаар хамтын хүчээр бодит болгох бололцоотой болно.

Ерөнхийдөө сүүлийн жилүүдэд салбарын хэмжээнд хууль, бодлогын баримт бичгүүд гарч, нэлээд ажил хийгдэж байгаа нь төрийн зүгээс ХАА-н салбарт анхаарлаа хандуулж эхэлж буйг харуулж байгаа юм. Гэвч эдгээр хууль, бодлого бодит байдалд хэр хэрэгжиж чадах, хэр уялдаа холбоотой байгаа, олон улсын туршлага судалгааны үр дүнг хэр сайн тусгаж буйг олон талаас нь шүүн хэлэлцэх хэрэгтэй. Нэг талаас, дэлхийн хандлага, гадаад улсуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, бодлогуудыг манай улс бодлогын түвшинд хэлэлцэж, харгалзан үзэж буй нь чухал алхам юм. Гэвч тус салбарын бодлогын төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ-үнэлгээний тухайд зарим талаар тодорхой бус байсаар байна. Иймээс ХАА-н салбарыг хөгжүүлэх бодлогын хүрээнд анхаарах шаардлагатай зүйлсийг тодорхойлж, хэрэгжиж буй ажлын явцыг байнга хянаж, үнэлж байх нь чухал .

Цаашилбал, мэдээллийн технологийн ололт амжилтыг ХАА-н салбарын хөгжилд түлхүү ашиглах хэрэгцээ байгаа юм. Мэдээллийн технологи нь ХАА-н салбарын олон төрлийн оролцогчид хоорондоо харилцах, хамтран ажиллах шинэ арга замуудыг нээж, үүгээрээ инновацийн үйл явцыг улам бэхжүүлж, ХАА-н шинжлэх ухаан, инноваци, хөгжилд маш том өөрчлөлт авчрах боломжтой юм.

Нөгөөтэйгүүр, Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, олон улсын байгууллагуудын болон гадны орны санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүд, их сургуулиудын судалгаа мөн хувь хүмүүсийн идэвх санаачлагын үр дүнд ХАА-н чиглэлийн мэдээлэл авах боломжтой олон тооны дижитал эх үүсвэр бий болсон хэдий ч тэдгээрийг зангидаж ашиглахад хялбар, ойлгомжтой болгох хэрэгцээ байсаар байна. Энэ нь бичил аж ахуй эрхлэгчид мэдээлэл авах, их сургуулиуд, судалгааны байгууллагууд, бизнес эрхлэгчид судалгаа шинжилгээ хийх, мэдээллийг цэгцтэй болгосноор ХАА-н салбарт оролцогчдын уялдааг сайжруулах, энэ салбарт хэр ажил хийгдэж байгааг, тогтолцоо хэр ажиллаж байгааг хянахад хялбар болох зэрэг олон талын ач холбогдолтой юм.

## ДҮГНЭЛТ

Монгол улсын ХАА-н өрсөлдөх чадвар, орон нутгийн хүн амын амьжиргааны түвшинд судалгаа хийж үзэхэд ХАА-н салбар Монгол улсын ДНБ-ий 14%-ийг бүрдүүлж байгаа боловч ажиллах хүчний 28%-ийг хамарч байна. Тус салбарын 80 гаруй хувийг МАА дангаараа бүрдүүлж байна. Орон нутгийн өрхийн 60 гаруй хувь нь мал маллаж байгаа бөгөөд эдгээр өрхийн амьжиргаа нь МАА-гаас шууд хамааралтай байна. Орон нутгийн иргэдийн өрхийн орлогын 60 хувийг МАА-аас орсон орлого бүрдүүлж байна. Иймд ХАА, ялангуяа МАА салбарын хөгжил нь орон нутгийн иргэдийн тогтвортой амьжиргааг бий болгоход чухал үүрэгтэй юм.

ХАА-н салбарын өрсөлдөх чадварыг олон улсад өргөн ашиглагддаг RCA индексээр тооцоход адууны мах, үхрийн мах, малын арьс шир, ноолуур, ноолууран бүтээгдэхүүний хувьд харьцангуй давуу талтай болох нь харагдсан. Эдгээр бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд махны хувьд эрүүл ахуйн шаардлага (тухайлбал, халдварт өвчнөөс сэргийлэх системийг бүрдүүлэх), махны харьцангуй үнийг дотоодод бага байлгах, түүнчлэн худалдааны түнш орнуудтай мах, махан бүтээдхүүний монголоос авах импортын тарифаа бууруулах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна.

МАА салбар нь өрхийн жижиг аж ахуй эрхлэгчдээс бүрдсэн, тэдний амьжиргааг залгуулах түвшинд хөгжсөн. Тухайлбал нэг өрх дундажаар 244 малтай ба орон нутагт амьдарч буй иргэдийн 19% нь ядуу амьдарч байна. Орон нутгийн иргэдийн орлогод малын тоо толгойн өсөлт, МАА-н бүтээгдэхүүний үнийн өсөлт, орон нутагт олгож буй зээлийн өсөлт зэрэг нь эергээр нөлөөлж байгаа нь эмпирик шинжилгээгээр харагдсан. Гэвч нэгдүгээр хүчин зүйл болох малын тоо толгойн өсөлт нь бэлчээрийн даацаар хязгаарлагдах тул орлогыг тогтвортой нэмэгдүүлэх хүчин зүйл болохгүй. Хоёрдугаар хүчин зүйл МАА-н бүтээгдэхүүний үнэ, тэр дундаа махны үнэ гадаад үнээс өндөр байгаа, ноолуурын үнэ гадаад үнээр тодорхойлогддог зэргээс дүгнэхэд үнийн өсөлт нь мөн орлогыг тогтвортой нэмэгдүүлэхгүй юм. Гуравдугаар хүчин зүйл болох орон нутагт олгосон зээл, МАА-н салбарт оруулах хөрөнгө оруулалт нь одоогоор хангалтгүй байгаа тул зээлийг нэмэгдүүлэх, төсвийн болон хувийн хөрөнгө оруулалтыг дэмжсэнээр МАА салбарын бүтээмжийг нэмэгдүүлж, олон улсын түвшинд хүргэх нь орон нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх гол эх сурвалж болох юм.

ХАА салбарын хөгжил нь инноваціас шууд хамаардаг болохыг олон улсын туршлага харуулдаг. ХАА-н инноваци нь зөвхөн техник, технологийн хөгжлөөс гадна тус салбарт ажиллагсдын ур чадвар, зах зээлийн тогтолцооноос ихээхэн хамаарна. Түүнчлэн ХАА-н инновацийн тогтолцоог хөгжүүлэхдээ нэмүү өртгийн гинжин хэлхээтэй уялдуулан ажиллах нь тус салбарын хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байна. Монгол улсын хувьд

ХАА-н салбарыг хөгжүүлэх бодлогын арга хэмжээ, хөрөнгө оруулалтыг сүүлийн хоёр жилийн хугацаанд эрс нэмэгдүүлсэн боловч цаашид ХАА-н салбарыг хөгжүүлэхэд анхаарах хэд хэдэн чиглэл байна. Үүнд: нэгдүгээрт, ХАА-н чиглэлийн судалгааг нэмэгдүүлэх, судалгааны үр дүнг бодитой ажил хэрэг болгох; хоёрдугаарт, судалгааны чиглэлийг нарийсгаж, орон нутгийн боломжид төвлөрүүлэх; гуравдугаарт, мэдээллийн технологийг тус салбарт өргөн ашиглаж мэдээлэл, судалгааг хүртээмжтэй болгох; дөрөвдүгээрт, ХАА-н чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүд, төслийн хоорондын уялдааг сайжруулж, хяналт-шинжилгээ-үнэлгээг тогтмолжуулах зэрэг болно.

## 4. НОМ ЗҮЙ

"Ногоон Алт" Бэлчээрийн Экосистемийн Удирдлага Төс. (2013 оны 07 3). *www.greengold.mn*. Retrieved 2015 оны 09 22 from http://www.greengold.mn/index.php/mn/2012-11-19-13-05-05/2012-11-27-07-20-27

Anandajayasekeram, P. (2011). The Role of Agricultural R&D Within The Agricultural Innovation Systems Framework . *The ASTI/IFPRI-FARA conference* (pp. 1-33). Accra, Ghana: International Food Policy Research Institute.

Anandajayasekeram, Puskur, & Zerfu. (2009). *Applying innovation system concept in agricultural research for development: Learning module.* Nairobi, Kenya: ILRI (International Livestock Research Institute).

Bela, B. (1965). Trade Liberalization and Revealed Comparative Advantage. *Manchester Shcool of Economic and Social Studies No.33* , 99-123.

BIS. (2014). *Bank for International Settlement* . Retrieved 2014 оны July 22 from Long series on total credit and domestic bank credit to the private nonfinancial sector: http://www.bis.org/statistics/credtopriv.htm

Bureau of Labor Statistics. (2014 оны July 20). *Bureau of Labor Statistics.* Retrieved 2014 оны July 21 from Databases, Tables and Calculators : http://data.bls.gov/timeseries/LNS14000000

C.Martin Webber, Partrick Labaste. (2010). *Building Competitiveness in Africa's Agriculture: A Guide to Value Chain Concepts and Applications.* World Bank.

*Competitiveness of Selected South African Agricultural Products in the European Union Market.* Agriculture, Forestry and Fisheries.

E.Leamer, E. (1995). The Heckscher-Ohlin Model in Theory and Practice. *Princeton Studies In International Finance* .

Economic Intelligence Unit. (2012). Shake it all about. *The Economist* , http://www.economist.com/node/21543468.

Economic Intelligence Unit. (2011 оны June 30). *Some like it hot.* Retrieved 2014 оны June 25 from Economist.com: (http://www.economist.com/node/18895150?story_id=18895150&CFID=173052931&CFTOKEN=76541139)

Eknhbold, V. (2015). *Research Analysis on Mongolian Export Oriented Meat Products.* GIZ Monterrey Project.

Enkhbold, V., Nomintsetseg, U., Bolor, B. (2015). *Research Analysis on Mongolian Export Oriented Meat Products.*

EPRC, M. E. (2005). *A Value Chain Analysis of the Mongolian Cashmere Industry.* Ulaanbaatar: USAID.

EU SCAR, E. U. (2012). *Agricultural Knowladge and Innovation Systems in Transition- a Reflection Paper* . Brussels.

Eurostat. (2014 оны April 23). *Eurostat.* Retrieved 2014 оны July 21 from epp.eurostat.ec.europa.eu: http://epp.eurostat.ec.europa.eu/cache/ITY_PUBLIC/2-23042014-AP/EN/2-23042014-AP-EN.PDF

IFPRI, I. F. (2015). *2014-2015 Global Food Policy Report.* Washington, DC: International Food Policy Research Institute (IFPRI).

ILRI. (2013). *Innovation Platforms Practice Brief.* Kenya: International Livestock Research Institute.

IMF. (2014b оны August 30). International Financial Statistics Public Data.

IMF. (2014 оны April). *International Monetary Fund*. Retrieved 2014 оны July 22 from World Economic Outlook Database: http://www.imf.org/external/data.htm

Janet Dwyer et all. (2012). *How to Improve the Sustainable Competitiveness and Innovation of the EU Agricultural Sector.* Brussels: Europian Parliament, Policy Department.

Joe Dewbre, Dalila Cervantes-Gody, Silvia Sorescu. (2011). Agricultural Progress and Poverty Reduction. *OECD Food, Agriculture and Fisheries Papers No.49* .

Latruffe, L. (2010). Compotetitiveness, Productivity and Efficiency in the Agricultural and Food Sectors. *OECD Food, Agriculture and Fisheries Papers* , p. 30.

Mill, J. (1848). *On the Laws of Interchange Between Nations; and The Distribution of Gains of Commerce Among The Countries of Commercial World.*

MoFALI. (2009). *National Food Security Programme.* Ulaanbaatar: Government of Mongolia, Ministry of Food, Agriculture and Light Industry(MoFALI).

Mongol News. (2015 оны 08 12). *mongolnews.mn*. Retrieved 2015 оны 09 21 from http://mongolnews.mn/%D0%90%D1%80%D1%85%D0%B8%D0%B2/1nbp

Mongolia Economy. (2012 оны 12 25). *mongolianeconomy.mn*. Retrieved 2015 оны 09 20 from http://mongolianeconomy.mn/mn/i/3287

OECD. (2009). *Growing Prosperity. Agriculture, Economic Renewal and Development. Draft Outcome Document from the Experts Meeting on "Innovating Out of Poverty".* Paris: OECD.

R.Kaplan, D.Norton. (2008). The Execution Premium: Linking Strategy to Operations for Competitive Advantage. *Harvard Business School Publishing* .

Rajalahti, R. (2011). *Agricultural Innovation Systems: Investment Sourcebook.* Washington DC: World Bank.

Reserve Bank of India. (2014). *Major monetary policy rates*. Retrieved 2014 оны September 2 from http://dbie.rbi.org.in/DBIE/dbie.rbi?site=home

Ricardo, D. (1815). *An Essay on The Influence of a Low Price of Corn on The Profits of Stock.*

Schneider, K., & Gugerty, M. K. (2011). gricultural Productivity and Poverty Reduction: Linkages and Pathways. *The Evans School Review*, 56-69.

Shneider. (2015). *http://www.gschneider.com/*. Retrieved 2015 оны 09 04 from http://www.gschneider.com/: http://www.gschneider.com/

Smith, A. (1776). *An Inquiry Into The Nature and Causes of The Wealth of Nations.*

Swiss Agency for Development and Cooperation. (May 2015). *National Report on RangeLand Health of Mongolia.* SDC.

UNDP. (2009). *Trade Policy and Human Development in Mongolia.* Ulaanbaatar: Munkhiin Useg Group.

World Bank. (2014). *Global Economic Perspective.* Washington: World Bank Group.

World Bank. (2011). *ICT IN AGRICULTURE: Connecting Smallshareholders to Knowledge, Networks, Institutions.* Washington DC: World Bank.

World Bank. (2014). *World Databank*. Retrieved 2014 оны 07 22 from World Databank: http://databank.worldbank.org/data/home.aspx

А.Энх-Амгалан. (2013). *Бэлчээрийн Эрх Зүйн Орчныг Сайжруулах нь Мал Аж Ахуйн Хөгжлийн Тулгамдсан Асуудлыг Шийдвэрлэх Гарц Мөн.*

Б.Мөнхзаяа. (2012). *Монголын эдийн засгийн мөчлөгийн шинжилгээ ба индикатор.*

Б.Эрдэнэбат. (2012). *Макро эдийн засгийн эрсдлүүд ба тэдгээрээс зайлсхийх арга замууд.*

Б.Эрдэнэболор, & А.Бакей. (2009). Хөдөө аж ахуйн салбар дахь инновацийн тогтолцоо . *"Үндэсний инновацийн тогтолцоо: инноваци ба аж үйлдвэрийн бодлого" сэдэвт онол практикийн бага хурал* (pp. 1-14). Улаанбаатар: Компьютер Менежментийн Сургууль.

Г.Ганбат. (2012 оны 10 25). *www.mace.mn.* Retrieved 2015 оны 07 02 from www.mace.mn/images/news/news20121025_1.pptx

Г.Ёндонсамбуу. (2015 оны 05 05). Монголын ноос, ноолуурын холбоо, Дэд Тэргүүн. (Д.Эрдэнэбулган, Interviewer)

Гаалийн Ерөнхий Газар. (2015). *customs.gov.mn*. Retrieved 2015 оны 7 01 from http://customs.gov.mn/statistics/index.php?module=users&cmd=info

Гаалийн Ерөнхий Газар. (2014). *Барааны Экспорт Импортын Статистикийн мэдээлэл.*

Д.Ган-Очир. (2012). *Монголын эдийн засгийн эмзэг байдлын үнэлгээ: Инфляци, Эдийн засгийн өсөлтийн хөтөч үзүүлэлтийг тодорхойлох нь.*

Дэлхийн банк. (2008). *Мал Ахуйн Салбарын Судалгаа.*

Дэлхийн банк. (2002). *Монголын хүрээлэн буй орчны мониторинг.*

Дэлхийн Банк. (2003). *Ямаанаас Хувцас хүртэл: Монгол Улсын Ноолуурын Салбарын Бүтцийн Шинэтгэл.* Ядуурлыг Бууруулах, ЭДийн Засгийн Удирдлагын Нэгж, Зүүн Ази, Номхон Далайн Бүс.

Ж.Мижиддорж. (2015 оны 7 9). Чөлөөт бүс ХАА-д инновацийг хөгжүүлэх эхлэл болно. (http://economy.news.mn, Interviewer)

Засгийн газрын 2014 оны 87-р тогтоолын хавсралт. (2014). *Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх журам.* Улаабаатар.

МАА-н эрдэм шинжилгээний хүрээлэн. (2013 оны 12 5). *riah.mn*. Retrieved 2015 оны 9 5 from http://www.riah.mn/index.php/buteegdekhuun/uulder/79-%D0%B3%D0%BE%D0%B2%D1%8C-%D0%B3%D1%83%D1%80%D0%B2%D0%B0%D0%BD-%D1%81%D0%B0%D0%B9%D1%85%D0%B0%D0%BD-%D2%AF%D2%AF%D0%BB%D0%B4%D1%8D%D1%80

Монголбанк. (2007-2014). *Сарын бюллетень.* Монголбанк.

Монголбанк. (2015). *mongolbank.mn*. Retrieved 2015 оны 07 01 from http://www.mongolbank.mn/dblistneerreer.aspx

Монголбанк. (2007-2013). *Мөнгөний статистикийн тойм.* Монголбанк.

Монголбанк. (2007-2013). *Төлбөрийн тэнцэл.* Монголбанк.

С.Дарьмаа. (2015 оны 09 10). ҮСХ-ны Хүн ам, Нийгмийн Статистикын газрын шинжээч. (Г.Бумчимэг, Interviewer)

Статистикийн Мэдээллийн Нэгдсэн Сан. (2015). *1212.mn*. Retrieved 2015 оны 07 01 from http://www.1212.mn/statHtml/statHtml.do#

Т.Сэмчин. (2015). *Монголын Мал Аж Ахуй, Эдийн Засаг.* Улаанбаатар.

Үндэсний Статистикийн Хороо. (1998-2014). *Монгол Улсын Статистикийн Эмхтгэл.* ҮСХ.

Үндэсний Статистикийн Хороо. (2007-2014). *Сарын бюллетень.* ҮСХ.

ҮСХ. (2014). *Монгол Улсын Статистикийн Эмхэтгэл* . Улаанбаатар.

ҮХС. (n.d.). *www.nso.mn*.

Х.Золжаргал. (2014). *“ХХААЯ, Төрөөс ХАА-н талаар баримтлах бодлого” илтгэл, “ХАА-н салбарын санхүүжилтийн шинэ арга хэрэгслүүд” зөвлөгөөн.* Улаанбаатар.

ХАА-н Шинжлэх Ухааны Академи. (2015). *www.maas.edu.mn*. Retrieved 2015 оны 09 05 from http://www.maas.edu.mn/index.php

Хүнс Хөдөө Аж Ахуйн Яам. (2015 оны 9 1). *Нүүр Хуудас: Хөтөлбөр, төсөл*. Retrieved 2015 оны 9 1 from ХХААЯ-ны вэб сайт: http://www.mofa.gov.mn/new/index.php?option=com_content&view=article&id=118

Хүн-Эвсэл, ТББ. (2008). *Атрын 3 дахь аян үндэсний хөтөлбөр-зорилтот бүлэгт.* Улаанбаатар.

ХХААЯ. (2015 оны 07 02). (Г.Бумчимэг, Interviewer)

ХХААЯ. (2014). *Төрөөс ХАА-н талаар баримтлах бодлого.* Улаанбаатар: Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яам.

# ХАВСРАЛТ

## 1. Дэлхийн махны хэрэглээ ба Монголын экспорт[25]

2013 онд үхрийн махны дэлхийн нийт импорт 21,2 тэрбум ам.долларт хүрч, 2009-2013 онд импорт 14-16 хувь өсчээ. Манай улсын худалдааны гол түнш БНХАУ, ОХУ-ын үхрийн махны хэрэглээ 2000 оноос хойш өсч байна. Эдгээр улсын хувьд 2000 онд нэг хүнд ногдох үхрийн махны хэрэглээ тус тус 2.9 кг ба 10.36 кг байсан бол 2014 онд 3.47 кг ба 13.09 кг болж өсчээ. Харин Япон болон Европын холбооны хэрэглээ буурсан байна (Хүснэгт А.1).

**Хүснэгт А.1. Үхрийн махны нэг хүнд ноогдох хэрэглээ (кг), 2000-2014 он**

| Улс | 2000 | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **БНХАУ** | 2.9 | 2.96 | 3.15 | 2.89 | 2.96 | 2.96 | 2.98 | 3.16 | 3.16 | 3.27 | 3.34 | 3.29 | 3.31 | 3.4 | 3.47 |
| **ЕХ (28)** | 11.76 | 11.13 | 11.72 | 11.85 | 12.07 | 12.05 | 12.07 | 12.09 | 11.61 | 11.48 | 11.33 | 11.17 | 10.84 | 10.66 | 10.77 |
| **Япон** | 8.61 | 7.67 | 7.22 | 7.41 | 6.36 | 6.22 | 6.18 | 6.45 | 6.43 | 6.6 | 6.7 | 6.77 | 6.89 | 6.81 | 6.88 |
| **БНСУ** | 8.66 | 7.5 | 8.53 | 826 | 6.72 | 6.19 | 6.86 | 7.67 | 7.89 | 7.37 | 8.51 | 8.89 | 8.24 | 9.24 | 9.42 |
| **ОХУ** | 10.36 | 11.27 | 12.01 | 12.3 | 12.17 | 12.71 | 12.04 | 12.49 | 14.31 | 12.98 | 13.27 | 13.51 | 14.11 | 13.18 | 13.09 |

Харин хонины махны хэрэглээ үхрийн махтай харьцуулахад бага хэдий ч хөрш орнуудын хувьд өсч байна. БНХАУ-ын хонины махны нэг хүнд ногдох хэрэглээ 2000 онд 1.89 кг байсан бол 2014 онд 2.88 кг, ОХУ-ын хувьд 2000 онд 0.85 кг байсан бол 2014 онд 1.3 кг болж тус тус өссөн байна. Харин Япон, Европын холбооны улсын тухайд хэрэглээ буурчээ.

**Хүснэгт А.2. Хонины махны нэг хүнд ноогдох хэрэглээ (кг), 2000-2014 он**

| Улс | 2000 | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Хятад** | 1.89 | 2.02 | 2.17 | 2.1 | 2.24 | 2.34 | 2.42 | 2.54 | 2.52 | 2.58 | 2.61 | 2.58 | 2.64 | 2.8 | 2.88 |
| **ЕХ (28)** | 2.78 | 2.76 | 2.59 | 2.52 | 2.48 | 2.5 | 2.46 | 2.4 | 2.27 | 2.22 | 2.05 | 2.02 | 1.89 | 1.9 | 1.9 |
| **Япон** | 0.32 | 0.31 | 0.3 | 0.26 | 0.32 | 0.37 | 0.37 | 0.27 | 0.27 | 0.27 | 0.22 | 0.22 | 0.19 | 0.2 | 0.2 |
| **БНСУ** | 0.11 | 0.09 | 0.11 | 0.1 | 0.11 | 0.11 | 0.11 | 0.11 | 0.11 | 0.1 | 0.1 | 0.12 | 0.12 | 0.12 | 0.12 |
| **ОХУ** | 0.85 | 0.82 | 0.82 | 0.76 | 0.8 | 0.95 | 1.03 | 1.1 | 1.16 | 1.13 | 1.18 | 1.2 | 1.25 | 1.27 | 1.3 |

Нөгөө талаас дэлхийн үхрийн махны үйлдвэрлэлд хамгийн их хувь нэмэр оруулж байгаа улс бол БНХАУ юм. Тус улс 2013 онд 79 сая тонн үхрийн мах үйлдвэрлэсэн бол Монгол улс 227 мянган тонн үйлдвэрлэж дэлхийд 95-р байр эзэлж байна (Хүснэгт А.3).

[25] Судалгааны энэ хэсэг доктор В.Энхболд нарын “Монголын экспортод чиглэсэн махны үйлдвэрлэлийн шинжилгээ” судалгааны ажилд тулгуурлав (Enkhbold, V., Nomintsetseg, U., Bolor, B., 2015).

**Хүснэгт А.3. Үхрийн махны үйлдвэрлэл (тонн), 2013 он**

| № | Улс | Хэмжээ | № | Улс | Хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | БНХАУ | 78,840,368 | 6 | Энэтхэг | 6,179,551 |
| 2 | АНУ | 42,203,219 | 7 | Мексик | 5,909,233 |
| 3 | Бразил | 24,029,211 | 8 | Франц | 5,776,846 |
| 4 | ХБНГУ | 8,164,672 | 9 | Испани | 5,406,502 |
| 5 | ОХУ | 7,421,010 | **95** | **Монгол** | **227,057** |

Манай улсын мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нарийвчлан авч үзвэл, хонь, ямааны мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2000 оны дунд үе хүртэл буурч, дараа нь эргээд өсчээ. Энэ нь 1999-2002 онд жил дараал тохиолдсон зуд, ган гачгаас шалтгаалж нийт малын тоо толгой 26 хувиар буурсан боловч түүнээс хойш ноос, ноолуурын үнэ өссөнөөр үржлийн эрчим өндөртэй, бие гүйцэтлээ бага хугацаа зарцуулдаг, түүхий эдийг нь бэлэн мөнгөөр арилжих боломж өндөртэй хонь, ямааны тоо өссөнтэй холбоотой байна (Дэлхийн банк 2009). Харин адуу болон үхрийн мах, махан бүтээгдэхүүний гарц ихээхэн буурсан байна. Тухайлбал, 2000 онд адууны махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 40 мянган тонн байсан бол 2013 онд 31 мянган тонн болж буурчээ.

**Хүснэгт А.4. Монгол улсын мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл (тонн)**

| | Үхрийн мах | Хонины мах | Адууны мах |
|---|---|---|---|
| **2000** | 113,400 | 90,000 | 40,667 |
| **2001** | 66,900 | 76,600 | 32,499 |
| **2002** | 60,700 | 74,900 | 38,988 |
| **2003** | 43,600 | 61,900 | 26,000 |
| **2004** | 52,300 | 65,100 | 39,953 |
| **2005** | 45,300 | 57,400 | 40,390 |
| **2006** | 44,200 | 54,400 | 31,883 |
| **2007** | 46,600 | 68,400 | 28,999 |
| **2008** | 54,200 | 72,300 | 38,075 |
| **2009** | 58,565 | 91,243 | 35,578 |
| **2010** | 47,547 | 77,369 | 24,335 |
| **2011** | 53,591 | 76,034 | 24,939 |
| **2012** | 59,704 | 67,240 | 31,062 |
| **2013** | 56,436 | 92,414 | 31,062 |

*Эх сурвалж: http://faostat3.fao.org/*

Мах, махан бүтээгдэхүүний гарц тогтворгүй байгаа нь манай улсын мал аж ахуйн салбар цаг агаарын эрс тэс уур амьсгал, зуд, ган гачиг зэрэг байгалийн гэнэтийн нөлөөлөлд өртөмтгий нөхцөл байдалтай холбоотой юм.

## 1.1. БНХАУ-д экспортлох

Манай улсын худалдааны хамгийн том түнш БНХАУ 2013 онд нийт 5 тэрбум ам.долларын мах, махан бүтээгдэхүүн импортолж, энэ нь дэлхийн нийт махан бүтээгдэхүүний импортын 5.02 хувьтай тэнцэж, дэлхийд 8 дугаар байрт оржээ. Гол экспортлогчид болох НАФТА-ийн гишүүн орнууд (АНУ болон Канад) импортын 19 хувь, Европын Холбоо 26 хувь, Латин америк 20 хувь, Австрали ба далайн орнууд 15 хувийг тус тус бүрдүүлж байгаа юм.

**Хүснэгт А.5. БНХАУ-ын мах махан бүтээгдэхүүний импорт, улсаар (сая ам.доллар)**

| No | Экспортлогч | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
|---|---|---|---|---|---|---|
| | **Дэлхий** | 1,701 | 2,225 | 3,411 | 4,108 | 5,927 |
| **1** | АНУ | 910 | 405 | 1,359 | 1,340 | 1,177 |
| **2** | Австрали | 83 | 107 | 169 | 301 | 1,132 |
| **3** | Шинэ Зенланд | 91 | 98 | 178 | 298 | 716 |
| **4** | Бразил | 45 | 562 | 604 | 594 | 490 |
| **5** | Дани | 196 | 358 | 320 | 365 | 417 |
| **18** | **Монгол** | | **3.9** | **4.8** | **0.2** | **2.6** |

БНХАУ Австрали, Шинэ Зеланд, Канад, Аргентин, Уругвайгаас голлон үхэр, хонины махыг импортолдог бол манай улс эдгээр бүтээгдэхүүний импортын маш бага хувийг нийлүүлж байна. Энэ нь манай улс мах, махан бүтээгдэхүүний экспортын хэмжээгээ нэмэгдүүлж, тус улсын импортын зах зээлд орон зайгаа тэлэх боломж их байгааг харуулж байна.

Дараах хүснэгтэд БНХАУ-ын үхэр, хонь ямаа, адууны хөлдөөсөн махны импортын хэмжээг дэлгэрэнгүй харуулав. Үүнээс харахад үхрийн хөлдөөсөн махны импорт 2009 – 2013 онд жил бүр өсч, 2013 он гэхэд өмнөх оноос 394 хувь өсчээ. Мөн хонь, ямааны хөлдөөсөн махны хувьд жилд бүр өсөлттэй байсан бөгөөд 2013 онд өмнөх оноос 126.3 хувийн өсөлттэй гарчээ. Адууны махны хувьд манай улс гол экспортлогч орон бөгөөд 2013 онд 2.5 сая ам.долларын экспорт тус улсад хийжээ. Энэ нь манай улсын адууны махны экспортын 34 хувьтай тэнцэж буй юм.

**Хүснэгт А.6. БНХАУ-ын мах, махан бүтээгдэхүүний импорт, нэр төрлөөр, сая ам.доллар, 2009-2013 он**

| Код | Бүтээгдэхүүн | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
|---|---|---|---|---|---|---|
| HS0202 | Үхрийн хөлдөөсөн мах | 37 | 77 | 86 | 243 | 1,201 |
| HS0204 | Хонь, ямааны хөлдөөсөн мах | 13 | 157 | 276 | 422 | 954 |
| HS0205 | Адууны мах | | 3.9 | 4.7 | 0.2 | 2.6 |

БНХАУ-ын мах, махан бүтээгдэхүүний импорт жилээс жилд өсөж байгаа нь тус улсын эдийн засгийн өсөлт, хүн амын хотжилт, хүмүүсийн орлогын өсөлт, дэд бүтцийн өсөлтөөс улбаатай.

Монгол улс үхэр, хонь ямааны махны экспортыг нэмэгдүүлэх боломж бүрэн байгаа бөгөөд энэ тохиолдолд манай гол өрсөлдөгчид Австрали, Уругвай, Шинэ Зеланд байх юм. 2013 оны байдлаар Австрали 658 сая, Уругвай 268 сая, Шинэ Зеланд 153 сая ам.долларын үхрийн хөлдөөсөн махны экспорт тус тус хийжээ. Хонь, ямааны махны тухайд 2013 онд Шинэ Зеланд 544 сая, Австрали 377 сая, Уругвай 34 сая ам.долларын экспорт тус тус хийжээ.

***БНХАУ-аас манай улсын мах, махан бүтээгдэхүүнд ноогдуулах импортын тариф***

БНХАУ ХАА-н бүтээгдэхүүнд дунджаар 15.8 хувийн баунд тариф [26] (bound), 15.6 хувийн апплайд тариф (applied) тавьдаг. Манай улс хонь, адууны махны хувьд өндөр татвартай (20 хувь) байгаа бөгөөд харин үхрийн махны тухайд харьцангуй бага (12 хувийн) татвартай байгаа юм. Манай улсын экспортод тавьж буй БНХАУ-ын тарифын дэлгэрэнгүйг HS 6 цифрийн хувьд Хүснэгт А.7-д харуулав.

**Хүснэгт А.7. БНХАУ манай улсын мах, махан бүтээгдэхүүнд ноогдуулж буй тариф**

| Код | Бүтээгдэхүүн | Үнийн дүнгээс (ad valorem) |
|---|---|---|
| HS020210 | Үхрийн хөлдөөсөн мах | 25% |
| HS020220 | Үхрийн хөлдөөсөн ястай, хэсэгчилсэн мах | 12% |
| HS020230 | Үхрийн хөлдөөсөн ясгүй мах | 12% |
| HS020410 | Хурганы шинэ ястай цул мах | 15% |
| HS020421 | Хонины шинэ ястай цул мах | 23% |
| HS020423 | Хонины шинэ ясгүй мах | 15% |
| HS020430 | Хурганы хөлдөөсөн мах | 15% |
| HS020441 | Хонины хөлдөөсөн мах | 23% |
| HS020442 | Хонины хөлдөөсөн ястай мах | 12% |
| HS020443 | Хонины хөлдөөсөн ясгүй мах | 15% |
| HS020450 | Ямааны шинэ, хөлдөөсөн мах | 20% |
| HS020500 | Адууны хөлдөөсөн мах | 20% |

26 Дэлхийн Худалдааны Байгууллагын гишүүн орнуудын хооронд тохирсон татварын хамгийн дээд хэмжээ.

***БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлоход тавих стандарт ба зохицуулалт***

БНХАУ-д хүнсний бүтээгдэхүүн экспортлох тохиолдолд тус улсын Хүнсний аюулгүй байдлын тухай хуульд заасан нөхцөлийг хангасан байх шаардлагатай. Энэ хуулийн зорилго нь тухайн хүнсний бүтээгдэхүүний гарал үүслээс эхлэн, эцсийн хэрэглэгч хүртэлх шат дамжлагыг хянахад оршдог бөгөөд хүнсний аюулгүй байдлын стандарт нь НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO) болон Дэлхийн худалдааны байгууллага (WTO)-ын санал болгодог хүнсний аюулгүй байдлыг хангах шалгуур үзүүлэлтэд тулгуурладаг.

Стандартууд:

- GB 2707-2005: Hygienic Standard for Fresh (Frozen) Meat of Livestock
- GB 168689-2005: Poultry National Standard
- GB 9959-2-2001: Fresh and Frozen Pork Muscle Cuts Standard
- GB 16869-2000 : Fresh and Frozen Poultry Product Standard
- GB/T 17238-2008: Fresh and Frozen Beef Cuts Standard
- GB/T 20094-2006: Hygienic Practice for Meat Processing Establishment
- GB 2760-2011: National Food Safety Standards for Uses of Food Additives

Тус улсын Хүнсний аюулгүй байдлын тухай хуульд заасны дагуу гадаад ба дотоодын махан бүтээгдэхүүний хяналт, хорио цээрийн захиргааны арга хэмжээний тухай заалт 2011 оны 6 сарын 1-ээс хүчин төгөлдөр болсон бөгөөд БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэхэд шаардлагатай чухал үе шатыг танилцуулжээ.

Протокол гэдэг нь тус улсын Чанарын хяналт, хорио цээрийн ерөнхий газар (AQSIQ) болон экспортлогч улсын хүнсний аюулгүй байдлыг хариуцагч байгууллага хооронд мах, махан бүтээгдэхүүний эрүүл ахуйн шаардлагын хувьд харилцан тохиролцсон гэрээг хэлэх бөгөөд тус протоколоор мах, махан бүтээгдэхүүнийг экспортлоход тавих хяналт шалгалт, хорионы талаарх үүрэг хариуцлагыг экспортлогч улсад шилжүүлдэг. Уг протокол дараах үндсэн агуулгатай. Үүнд:

- Экспортлогч улсын зүгээс AQSIQ-д менежментийн зохицуулалт болон мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн процесс, төрөл бүрийн өвчний эсрэг авч буй арга хэмжээ, хяналтын системийг танилцуулна.
- Тухайн экспортлогч улс малын халдварт өвчингүй бүс нутаг болохыг баталсан экспортлогч улсын хариуцагч албан тушаалтны баталгаажуулалт.
- Тухайн мах, махан бүтээгдэхүүний гарал үүсэл нь экспортлогч орных

болохыг баталсан экспортлогч улсын хариуцагч албан тушаалтны баталгаажуулалт.

- Экспорттой холбоотой дэлгэрэнгүй бүртгэлийг БНХАУ-ын Гэрчилгээ, Магадлан итгэмжлэлийн албанд (CNCA) хийлгэх.
- Экспортлогч улсын малын өвчний эсрэг малын эмч нар болон холбогдох мэргэжилтнүүдийн авч буй арга хэмжээний дэлгэрэнгүй.
- Мал нядалгааны газар болон мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үйл ажиллагаа зөвхөн шаардлагад нийцсэн байх ёстой. Бүтээгдэхүүн хадгалалтын горимыг хангах хүйтэн зоорьтой байх.
- Бүтээгдэхүүнийг савлах сайн орчинтой байх, шошго хийх
- Экспортолж буй контейнер бүрд Экспортын эрүүл ахуйн баталгаа (Export Health Certificate)-ны дэлгэрэнгүйг хавсаргах. Экспортлогч улс нь малын эмчийн гарын үсэг бүхий эрүүл ахуйн шаардлга хангаж буйг баталгаажуулах бичиг баримтыг AQSIQ-д өгнө.
- Ямар нэгэн халдварт өвчин гарсан, эсвэл халдварт өвчин гарах магадлалтай тохиолдолд AQSIQ-д мэдээлэх ёстой бөгөөд нэн даруй экспортын үйл ажиллагааг зогсооно. Дахин экспортын үйл ажиллагааг эхлүүлэхийн тулд экспортлогч улсын хариуцагч албан тушаалтан, мэргэжилтэн AQSIQ-тэй ойр ажиллах хэрэгтэй.

Экспортлогч тал дээрх шаардлагатай бичиг баримтыг Хятад улсын импортлогч талд тээвэрлэлт боомтод орж ирэхээс 3-5 хоногийн өмнө өгсөн байх хэрэгтэй. Импортлогч тал боомт хотын Чанарын хяналт, хорио цээрийн газарт импортолж буй бүтээгдэхүүнд хяналт, шалгалт хийх хүсэлт гаргаж, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж өгнө. HS код, халдварт өвчин гарсан эсэхээс шалтгаалан нэмэлт материал бүрдүүлэх шаардлага гарч болно.

### 1.2. Япон улсад экспортлох

Япон улс үхрийн мах импортлогч томоохон улсуудын нэг юм. Австрали, АНУ, Бразил нь тус улсад экспортлогч хамгийн гол орнууд. Япон улсын хувьд дотоодын хэрэгцээнд зориулж махыг вагюу, өдөр тутмын, эрлийз үүлдрийн гэж гурав ангилдаг. Дотоодын вагюу нь япончуудын хувьд онцгой тохиолдолд хэрэглэдэг тансаг бүтээгдэхүүнд тооцогддог бөгөөд түүний нийт хэрэглээний 40 хувийг дотоодоос, 36 хувийг Австрали, 15 хувийг АНУ-аас тус тус ханган нийлүүлдэг байна.

2012 онд Япон улсын үхрийн махны үйлдвэрлэл 2011 онтой харьцуулахад 4 хувиар буурч 363,065 тоннд хүрсэн нь 2011 оны Фукушимагийн атомын цахилгаан станцын ослын цацраг идэвхт бодисын хордлогоос шалтгаалан дотоодын хэрэгцээ буурсантай холбоотой юм.

**Хүснэгт А.8. Японы мах, махан бүтээгдэхүүний импорт, улсаар (сая.ам доллар)**

| No | Экспортлогч | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
|---|---|---|---|---|---|---|
| | **Дэлхий** | 7,390 | 8,553 | 10,320 | 9,893 | 8,762 |
| 1 | АНУ | 2,153 | 2,498 | 3,146 | 3,221 | 2,983 |
| 2 | Австрали | 1,655 | 1,785 | 1,957 | 1,854 | 1,621 |
| 3 | Бразил | 777 | 1,008 | 1,481 | 1,096 | 1,057 |
| 4 | Канад | 1,084 | 1,201 | 1,277 | 1,276 | 899 |
| 5 | Денмарк | 690 | 800 | 861 | 768 | 613 |
| **32** | **Монгол** | **0.11** | **0.09** | **0.09** | **0.07** | **0.04** |

Манай улсын хувьд 2013 оны байдлаар Япон улсын нийт импортын махны зах зээлийн 0.3 хувийг эзэлж 32-р байранд оржээ. Монгол улсын тухайд тус улсад адууны махыг их хэмжээгээр экспортлох боломжтой юм. Учир нь манай улсын адууны махны экспортод Япон улс тариф тогтоогоогүй бөгөөд тус улсад 2009 онд 35 сая ам.долларын экспорт хийж байсан нь адууны махны экспортыг нэмэгдүүлэх зах зээлийн орон зай байгааг илэрхийлж байна.

***Япон улсаас манай улсын мах, махан бүтээгдэхүүний импортод ноогдуулах тариф***

Япон улс манай улсын үхрийн маханд 38.5 хувийн импортын татвар ногдуулдаг бол хонь, ямаа, адууны маханд импортын татвар ноогдуулдаггүй (Хүснэгт А.9).

ХАА-н эцсийн бүтээгдэхүүнд дунджаар 19 хувийн баунд тариф (bound), 19 хувийн апплайд тариф (applied)бол мал амьтны гаралтай бүтээгдэхүүнд 12.3 хувийн баунд тариф, 11 хувийн апплайд тариф тус тус тавьдаг.

**Хүснэгт А.9. Япон улс манай улсын мах, махан бүтээгдэхүүнд ноогдуулж буй тариф**

| Код | Бүтээгдэхүүн | Үнийн дүнгээс (ad valorem) |
|---|---|---|
| HS020210 | Үхрийн хөлдөөсөн мах | 38.5% |
| HS020220 | Үхрийн хөлдөөсөн ястай, хэсэгчилсэн мах | 38.5% |
| HS020230 | Үхрийн хөлдөөсөн ясгүй мах | 38.5% |
| HS020410 | Хурганы шинэ бүтэн мах | 0% |
| HS020421 | Хонины шинэ бүтэн мах | 0% |
| HS020422 | Хонины шинэ ястай мах | 0% |
| HS020423 | Хонины шинэ ясгүй мах | 0% |
| HS020430 | Хурганы хөлдөөсөн бүтэн мах | 0% |
| HS020441 | Хонины хөлдөөсөн бүтэн мах | 0% |
| HS020442 | Хонины хөлдөөсөн ястай мах | 0% |
| HS020443 | Хонины хөлдөөсөн ясгүй мах | 0% |
| HS020450 | Ямааны шинэ, хөлдөөсөн мах | 0% |
| HS020500 | Адууны хөлдөөсөн мах | 0% |

Япон улсад мах, махан бүтээгдэхүүн экспортлох тохиолдолд дараах тарифын бус шалгуур тавигддаг. Үүнээс Дотоодын малын халдварт өвчний хяналтын тухай хууль тогтоомж, Хүнсний эрүүл ахуйн тухай хууль болон JAS хууль (ХАА болон ойн бүтээгдэхүүний зохих шошгожуулалт, стандартын тухай хууль) нь мах, махан бүтээгдэхүүний хувьд хамгийн чухал зохицуулалт юм. Тус улс дараах тарифын бус шалгуур тавьдаг. Үүнд:

- Баталгаажуулалтын шаардлага
- SPS (Sanitary and Phytosanitary) буюу хүнсний эрүүл ахуй болон ургамал, амьтны эрүүл ахуйн шаардлагатай холбоотой зохицлын үнэлгээ
- Хүнс болон малын тэжээлийн процесс
- Шошгоны шаардлага
- Бүтээгдэхүүн эсвэл SPS-ын шалтгаантай бодисын хязгаарлалт
- Хүнс болон малын тэжээлд тодорхой хориотой бодис хэрэглэсэн эсэх
- SPS-н талаарх тусгай зөвшөөрөл
- Хадгалалт болон тээвэрлэлтийн нөхцөл байдал
- SPS-с улбаатай газарзүйн түр зуурын хорио цээр
- Халдварт болон бохир бодисын байж болох хэмжээнээс хэтэрсэн эсэх
- Дотоодын малын халдварт өвчний хяналтын тухай хууль,тогтоомж
- Хүнсний эрүүл ахуйн тухай хууль

Тухайн мах, махан бүтээгдэхүүнийг импортлоход экспортлогч улсын Засгийн газрын холбогдох агентлагаас эрүүл ахуйн шаардлага хангаж буй, ямар нэгэн халдварт өвчинд өртөөгүй гэдгийг баталгаажуулах бичиг хавсаргах ёстой.

<u>JAS систем:</u>

Хүнсний шошго: Тухайн бүтээгдэхүүн нь бүтээгдэхүүний нэр, махны гарал үүслийн улс, орц, хэмжээ, үйлдвэрлэгч, хиам болон зайдас зэрэг махан бүтээгдэхүүний хадгалах горим зэргийг бичсэн, JAS хуулийн шаардлагыг хангах шошготой байх шаардлагатай.

1. Махан бүтээгдэхүүн

- Хамгийн ихдээ 70 ппм нитритийн агууламж бүхий лаазалсан, халаадаггүй бүтээгдэхүүнийг “For Export to Japan” гэж шошголох.
- Усны агууламж, pH, хоол бэлтгэхэд шаардлагатай температур, бүтээгдэхүүнийг савлаж боохоос өмнө болон дараа халаасан эсэх зэргийг япон хэлээр ойлгомжтой бичих.
- Хэрэв Японд хэрэглэгддэг мах, мах бүтээгдэхүүн боловсруулалтын стандартыг ашиглаагүй тохиолдолд япон хэл дээрх тайлбар бүхий шошго хэрэглэж болно.

2. Цэвэр жин

- Хэрэв шошго дээр цэвэр жинг бичигдээгүй байвал гараар бичиж, тамга дарж болно.
- Цэвэр жин бичигдээгүй тохиолдолд Япон улсын Хэмжил зүйн хуулийн дагуу тухай бүтээгдэхүүний цэвэр жинг хэмжиж, шошго хийнэ.

3. Нэмэлт хүнсний бүтээгдэхүүний орц

- Энэ шалгуур нь хамгийн хэцүү бөгөөд тухайн экспортлох бүтээгдэхүүний дээжийг Япон улсын Эрүүл мэнд, нийгмийн яаманд өгч, бүх орц бүтээгдэхүүний шинжилгээг хийлгэн баталгаажуулах шаардлагатай. Иймд экспортлогч тал тухайн импортлогч талтай ойр ажиллаж, Япон улсын зүгээс нэмэлт хүнсний бүтээгдэхүүний орцын шаардлагыг хангах хэрэгтэй.

**Хүснэгт А.10. Япон улсын мах, махан бүтээгдэхүүний стандарт[27]**

| Бүлэг | Стандарт |
|---|---|
| Ерөнхий стандарт | Кали нитрит: 0.07грамм/клограмм эсвэл бага |
| Хатаасан махан бүтээгдэхүүн | E coli: Сөрөг (0.1гх5)<br>Чийгийн агууламж: 0.87-с бага |
| Халаагаагүй махан бүтээгдэхүүн | E coli: 100 грамм<br>Yellow staphylococcus: 1000грамм-аас ихгүй<br>Salmonella belonging bacterium: Сөрөг |
| Тусгай халаасан махан бүтээгдэхүүн | E coli: 100грамм, Yellow staphylococcus: 1000 грамм-аас ихгүй<br>Clostridium belonging bacterium: 1000г-аас ихгүй<br>Salmonella belonging bacterium: Сөрөг |
| Халаасан махан бүтээгдэхүүн | Coliform group: Сөрөг<br>Clostridium belonging bacterium: 1000грамм-аас хэтрэхгүй<br>Yellow staphylococcus: 1000грамм-аас хэтрэхгүй<br>Salmonella belonging bacterium: Сөрөг |

[27] Мах, боловсруулсан махан бүтээгдэхүүнд тавигдах эрүүл ахуйн шаардлагын тухай хууль (Specification Standards of Meat and Prepared Products under the Food Sanitation Act).

## 2. Монгол улсын гадаад худалдааны үзүүлэлтүүд

Монгол улсын гадаад худалдааны гол үзүүлэлтүүд болох гол түнш орнуудтай хийх худалдааны хэмжээ, экспортын гол бүтээгдэхүүнүүд,

**Хүснэгт А.11. Монгол улсын түнш орнуудтай хийх худалдаа (сая ам.доллар) ба тэдгээрийн эзлэх хувь, 2013 он**

| | | Экспорт | Импорт | Нийт эргэлт | Экспорт | Импорт | Нийт эргэлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийт дүн | 4,269.1 | 6,357.8 | 10,626.9 | 100% | 100% | 100% |
| **1** | БНХАУ | 3,706.3 | 1,822.6 | 5,528.9 | 86.8% | 28.7% | 52.0% |
| **2** | Канад | 135.5 | 80.4 | 215.9 | 3.2% | 1.3% | 2.0% |
| **3** | ОХУ | 61.8 | 1,561.9 | 1,623.7 | 1.4% | 24.6% | 15.3% |
| **4** | Итали | 51.5 | 54.3 | 105.8 | 1.2% | 0.9% | 1.0% |
| **5** | ХБНГУ | 18.4 | 252.2 | 270.6 | 0.4% | 4.0% | 2.5% |
| **6** | БНСУ | 13.0 | 467.8 | 480.8 | 0.3% | 7.4% | 4.5% |
| **7** | Швейцарь | 3.1 | 11.6 | 14.7 | 0.1% | 0.2% | 0.1% |
| **8** | Их Британи | 200.7 | 46.5 | 247.2 | 4.7% | 0.7% | 2.3% |
| **9** | АНУ | 3.9 | 512.7 | 516.6 | 0.1% | 8.1% | 4.9% |
| **10** | Япон | 10.5 | 444.2 | 454.7 | 0.2% | 7.0% | 4.3% |

**Хүснэгт А.12. Монголын экспортын барааны бүтэц, хувиар**

| № | Бүтээгдэхүүний төрөл | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн | 2.40 | 2.39 | 0.83 | 0.55 | 0.60 | 0.29 |
| 2 | Ургамлын гаралтай бүтээгдэхүүн | 0.30 | 0.02 | 0.11 | 0.10 | 0.20 | 0.39 |
| 3 | Мал, амьтан, ургамлын гаралтай өөх тос | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 4 | Хүнсний бэлэн бүтээгдэхүүн | 0.30 | 0.21 | 0.16 | 0.20 | 0.30 | 0.20 |
| 5 | Эрдэс бүтээгдэхүүн | 66.40 | 80.95 | 89.25 | 89.17 | 81.90 | 82.97 |
| 6 | Химийн болон химийн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.01 |
| 7 | Хуванцар, каучук, эгээрээр хийсэн бүтээгдэхүүн | 0.00 | 0.05 | 0.03 | 0.03 | 0.10 | 0.04 |
| 8 | Мод, модон эдлэл | 0.00 | 0.01 | 0.01 | 0.01 | 0.00 | 0.01 |
| 9 | Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн бүтээгдэхүүн | 1.50 | 1.12 | 1.06 | 0.70 | 0.80 | 0.62 |
| 10 | Целлюлоз, цаас, картон, эдгээрээр хийсэн бүтээгдэхүүн | 0.00 | 0.05 | 0.03 | 0.03 | 0.00 | 0.00 |
| 11 | Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн | 10.20 | 7.44 | 5.01 | 5.33 | 6.60 | 5.87 |
| 12 | Гутал, малгай, шүхэр, өд хиймэл цэцэг | 0.10 | 0.03 | 0.04 | 0.03 | 0.00 | 0.02 |
| 13 | Чулуу, гөлтгөнө, цемент, шөрмөсөн чулуу эдгээрээр хийсэн бүтээгдэхүүн | 0.00 | 0.05 | 0.03 | 0.03 | 0.00 | 0.00 |
| 14 | Үнэт, хагас үнэт чулуу, металл, гоёлын зүйл | 16.40 | 6.13 | 2.28 | 2.79 | 7.30 | 7.02 |
| 15 | Үндсэн төмөрлөг болон төмөрлөг бүтээгдэхүүн | 0.90 | 0.76 | 0.53 | 0.45 | 0.50 | 0.83 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | Машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, сэлбэг, эд анги | 0.80 | 0.32 | 0.28 | 0.29 | 1.10 | 1.01 |
| 18 | Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги | 0.50 | 0.46 | 0.20 | 0.26 | 0.50 | 0.61 |
| 19 | Хараа зүй, гэрэл, кино зураг, хэмжүүр, хяналт, эмнэлэг, мэс заслын багаж, цаг, хөгжмийн зэмсэг | 0.10 | 0.03 | 0.12 | 0.02 | 0.00 | 0.06 |
| 20 | Үйлдвэрийн төрөл бүрийн бараа | 0.10 | 0.07 | 0.07 | 0.05 | 0.10 | 0.04 |
| 21 | Бусад | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |

**Хүснэгт А. 13. Монголын экспортын бүтээгдэхүүний илэрсэн харьцангүй давуу талын индекс (RCA), 2011-2013 он**

| Бүтээгдэхүүний ангилал | Код | Нэр (ITC) | (Галийн мэдээ)* | 2011 | 2012 | 2013 |
|---|---|---|---|---|---|---|
| Мал, амьтад тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн | '0101 | Амьд адуу | | 0.08 | 0.09 | 0.26 |
| | '0202 | Үхрийн хөлдүү мах | | 2.80 | 0.42 | - |
| | 0204 | Хөлдөөсөн хонь, ямааны мах | | - | 0.07 | 0.03 |
| | 0205 | Адууны мах, шинэ, хөлдөөсөн | Адууны мах | 83.73 | 33.25 | 33.41 |
| | 0210 | Гэдэс, цувдаа | | - | 0.06 | 0.03 |
| | 0504 | Өлөн гэдэс, давсаг, гүзээ | | 7.73 | 8.12 | 8.14 |
| | '0506 | Яс, тугалмай | | 3.89 | 2.72 | 0.01 |
| | '0507 | Зааны яс, боловсруулаагүй халимны яс | Эвэр, туурай, зааны яс, соёо, яст мэлхийн хуяг, шувууны хошуу, савар, хумс | 5.77 | 4.32 | 14.79 |
| | '0511 | Амьтны гаралтай бусад бүтээгдэхүүн | | 0.40 | 0.42 | 0.31 |
| Түүхий болон боловсруулсан арьс, шир | '4101 | Үхэр, адууны боловсруулаагүй шир | Үхэр, адууны боловсруулаагүй шир | 4.55 | 3.89 | 2.01 |
| | '4103 | Бусад мал, амьтдын арьс | | 4.40 | 2.72 | 4.40 |
| | '4104 | Үхэр, адууны боловсрууласан шир (4108/4109-с бусад) | | 2.90 | 4.07 | 5.24 |
| | '4105 | Хонь, хурганы боловсруулсан шир (4108/4109-с бусад) | | 45.07 | 69.30 | 61.53 |
| | '4106 | Ямаа, ишигний боловсруулсан арьс буюу шевро (4108/4109-с бусад) | | 15.55 | 10.59 | 40.50 |
| | 4107 | Бусад амьтдын боловсруулсан арьс, шир | | 0.02 | 0.01 | 0.01 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Ноос, амьтны үс, нэхмэлийн утас болон даавуу, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн** | '5101 | Хонины сэмлээгүй буюу самнаагүй ноос. | | 6.60 | 7.60 | 3.11 |
| | '5102 | Бусад мал, амьтаны нарийн болон бүдүүн үс, сэмлээгүй буюу самнаагүй ноос | Бусад мал, амьтны сэмлээгүй буюу самнаагүй, хялгас. | 1,646.31 | 2,264.15 | 1,679.56 |
| | '5103 | Ноосны хаягдал | | 0.71 | 0.87 | 1.95 |
| | '5105 | Ноос, мал амьтны нарийн болон бүдүүн самнасан үс, хялгас | Мал амьтны самнасан үс, хялгас | 80.60 | 91.05 | 107.33 |
| | '5108 | Мал амьтны нарийн ширхэгт үс, ээрмэл (жижиглэн баглаагүй) | | - | 0.21 | 0.16 |
| | 5109 | Ноосон ээрмэл, мал амьтны нарийн ширхэгт үс | | - | 0.09 | 0.20 |
| | '5111 | Мал амьтны нарийн ширхэгт сэмэлсэн үс, ноосон даавуу | | - | 0.10 | 7.36 |
| | 5112 | Мал амьтны нарийн ширхэгт сэмэлсэн үс, ноосон даавуу | | - | - | 1.11 |
| | '5702 | Үслэг биш, хээгүй хивс буюу бусад нэхмэл дэвсгэрэн зүйлс ба даавуун хивс, гар хивс | | 1.30 | 1.69 | 0.52 |
| | '5705 | Хивс, бусад нэхмэл шалны дэвсгэр | | 0.17 | 0.002 | - |
| **Ноос, ноолууран болон сүлжмэл бүтээгдэхүүн** | 6101 | Ямааны ноолууран пальто, хүрэм, жакет | | - | 0.06 | 0.01 |
| | 6102 | Эмэгтэй, охидын ямааны ноолууран үйлс | | 0.40 | 0.45 | 0.24 |
| | 6103 | Сүлжмэл костюм буюу комплект, ансамбль, жакет, өмд, комбинзон (эр) | | 0.001 | 0.003 | 0.002 |
| | 6104 | Ноолууран өмд, цамц, пальто, банзал (эм) | Сүлжмэл костюм, ансамбль, хантааз, платья, банзал, ємд, комбинзон (эм) | 0.05 | 0.06 | 0.05 |
| | 6105 | Сүлжмэл цамц (эр) | | 0.0004 | 0.001 | 0.01 |
| | 6106 | Нэхмэл, сүлжмэл цамц (эм) | Сүлжмэл дотуур цамц (эм) | 2.24 | 1.49 | 0.07 |
| | 6107 | Дотуур өмд, гэрийн хувцас, усны алчуур (эр) | | - | 0.01 | 0.01 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 6108 | Дотуур өмд, гэрийн хувцас, усны алчуур (эм) | | - | 0.02 | 0.02 |
| | 6109 | Сүлжмэл футболка, майк | | 0.0005 | 0.01 | 0.003 |
| | 6110 | Свитер, пуловер, джемпер болон бусад сүлжмэл гадуур цамц | | 0.46 | 1.10 | 1.28 |
| | 6111 | Хүүхдийн сүлжмэл өмсгөл, хувцас | | 0.04 | 0.02 | 0.01 |
| | 6114 | Бусад сүлжмэл хувцас | | 0.01 | 0.04 | 0.06 |
| | 6116 | Сүлжмэл ноосон бээлий | | 0.03 | 0.12 | 0.08 |
| | 6117 | Бусад, хувцасны сүлжмэл тоноглол | Хувцасны сүлжмэл бэлэн эд анги, тоног хэрэглэл | 2.56 | 5.07 | 2.12 |
| **Тэмдэглэл:** | * Бүтээгдэхүүний Гаалийн мэдээлэл болон ITC-н нэршил ялгаатай үед | | | | | |

**Хүснэгт А.14. Худалдааны гол түнш орнуудын импортын 2010-2014 оны дундаж ба дэлхийд эзлэх байр, сая ам.доллар**

| Код | Бүтээгдэхүүн | БНХАУ | Канад | ОХУ | Итали | ХБНГУ | БНСУ | Швейцар | Их Британи | АНУ | Япон |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| '0202 | Үхрийн мах, хөлдөөсөн | 402 (11) | 202 (22) | 2,351 (1) | 294 (16) | 270 (18) | 1,178 (4) | 17 (85) | 284 (17) | 1,693 (2) | 1,178 (3) |
| 0204 | Хөлдөөсөн хонь, ямааны мах | 588 (1) | 145 (11) | 53 (25) | 174 (10) | 348 (5) | 29 (34) | 116 (14) | 623 (3) | 693 (2) | 141 (12) |
| '0205 | Адууны мах, хошного, луус - шинэ, хөлдөөсөн | 3.5 (11) | 0.8 (72) | 74 (4) | 113 (1) | 3.7 (10) | - | 49 (5) | 11 (53) | 1.8 (15) | 28 (6) |
| 0210 | Гэдэс, цувдаа | 2.9 (58) | 91 (10) | 10.6 (36) | 131 (7) | 441 (4) | 7.6 (41) | 61 (14) | 1,225 (1) | 165 (6) | 51 (16) |
| 0504 | Өлөн гэдэс, давсаг, гүзээ | 251 (5) | 72 (14) | 82 (13) | 167 (10) | 646 (1) | 71 (15) | 45 (22) | 41 (24) | 171 (9) | 289 (4) |
| '0506 | Яс, тугалмай | 2.9 (11) | 0.8 (22) | 0.1 (41) | 1.4 (15) | 21 (6) | 1.4 (14) | 1.2 (18) | 24 (4) | 0.003 (132) | 69 (1) |
| '0507 | Эвэр, туурай, зааны яс, соёо, яст мэлхийн хуяг, шувууны хошуу, савар, хумс | 12,209 (3) | 1,455 (10) | 2.3 (75) | 1,247 (12) | 11,838 (4) | 27,107 (1) | 1,071 (15) | 1,958 (7) | 1,390 (11) | 2,766 (6) |
| '0510 | Эмийн бэлдмэлд зориулсан амьтаны цөс, булчирхай | 3,042 (12) | 4,435 (10) | 861 (18) | 2,655 (13) | 14,860 (7) | 15,969 (5) | 628 (20) | 504 (25) | 16,541 (4) | 18,843 (3) |
| '0511 | Бусад амьтны гаралтай бүтээгдэхүүн | 47,349 (13) | 87,344 (8) | 25,102 (23) | 41,715 (16) | 178,030 (2) | 18,086 (31) | 20,374 (27) | 79,601 (10) | 510,073 (1) | 156,699 (7) |
| '4101 | Үхэр, адууны түүхий шир | 2,306,054 (1) | 7,038 (35) | 1,023 (58) | 1,140,940 (2) | 197,227 (6) | 438,235 (3) | 136 (82) | 51,146 (18) | 52,480 (17) | 76,684 (11) |
| '4103 | Түүхий, боловсруулаагүй арьс шир | 43,982 (4) | 519 (33) | 69.6 (58) | 72,583 (2) | 23,725 (10) | 12,042 (12) | 410 (36) | 2,029 (22) | 2,107 (21) | 58,398 (3) |
| '4104 | Үхэр, адууны боловсруулсан шир (4108/4109-с бусад) | 1,410,943 (1) | 9,936 (40) | 921 (71) | 1,352,668 (2) | 96,285 (13) | 96,184 (14) | 4,266 (53) | 20,604 (32) | 53,052 (21) | 70,196 (18) |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **'4105** | Хонь, хурганы боловсруулсан шир (4108/4109-с бусад) | 49,029 (3) | 839 (26) | 1,055 (25) | 183,115 (1) | 1,361 (22) | 4,895 (15) | 235 (40) | 4,064 (17) | 2,622 (20) | 7,929 (12) |
| **'4106** | Ямаа, ишигний боловсруулсан арьс буюу шевро (4108/4109-с бусад) | 73,763 (3) | 886 (32) | 123 (63) | 179,076 (1) | 7,689 (16) | 5,181 (20) | 809 (33) | 3,410 (23) | 7,608 (17) | 12,030 (13) |
| **4107** | Бусад амьтдын боловсруулсан арьс, шир | 2,176,173.2 (1) | 72,022.8 (33) | 40,062.2 (41) | 629,419.2 (4) | 667,629 (3) | 244,377.6 (13) | 50,427.2 (36) | 160,988.4 (16) | 501,135.6 (5) | 57,130.4 (35) |
| **5101** | Хонины сэмлээгүй буюу самнаагүй ноос. | 3,462,259.6 (1) | 94,059.8 (24) | 3,3422 (47) | 1,662,924.6 (2) | 1,008,678 (3) | 361,494.2 (9) | 104,272.4 (21) | 482,706 (6) | 301,521.2 (12) | 533,006.4 (5) |
| **5102** | Нарийн болон бүдүүн амьтны үс, сэмлээгүй буюу самнаагүй | 87,480.8 (2) | 179.8 (35) | 135.8 (41) | 280,189.2 (1) | 18,494.6 (5) | 8,521.6 (6) | 339.4 (30) | 72,706.4 (3) | 2,564 (12) | 20,702.6 (4) |
| **5103** | Ноосны хаягдал | 12,536.4 (2) | 1,228 (18) | 53.4 (37) | 52,744 (1) | 4,015.6 (7) | 1,728.2 (12) | 54.2 (36) | 5,679.8 (4) | 1,673.2 (14) | 7,589 (3) |
| **'5105** | Мал амьтны самнасан үс, хялгас | 125,191 (5) | 10,969 (23) | 2,025 (45) | 417,126 (1) | 206,585 (2) | 163,155 (3) | 3,938 (36) | 20,535 (17) | 22,240 (14) | 89,925 (9) |
| **'5108** | Мал амьтны нарийн ширхэгт үс, ноосон ээрмэл (жижиглэн баглаагүй) | 27,552 (3) | 720 (29) | 97.8 (54) | 45,590 (2) | 8,783 (11) | 6,228 (14) | 612 (32) | 8,818 (10) | 5,376 (15) | 15,632 (4) |
| **5109** | Ноосон ээрмэл, мал амьтаны нарийн ширхэгт үс | 815.2 (39) | 7,127.2 (14) | 6,333.8 (23) | 11,491.4 (12) | 81,127.6 (1) | 5,738.6 (20) | 18,436.2 (7) | 11,660.8 (11) | 42,537.8 (2) | 9,542.8 (13) |
| **'5111** | Мал амьтны нарийн ширхэгт сэмэлсэн үс, ноосон даавуу | 81,425 (1) | 8,015 (34) | 7,853 (35) | 36,724 (8) | 72,188 (2) | 31,000 (11) | 13,489 (23) | 22,243 (17) | 33,456 (9) | 32,534 (10) |
| **5112** | Мал амьтны нарийн ширхэгт сэмэлсэн үс, ноосон даавуу | 429,912.6 (1) | 52,424.8 (15) | 6,585.2 (55) | 139,521.2 (4) | 193,566.6 (2) | 55,570.4 (11) | 54,706.2 (13) | 37,198.8 (18) | 96,980.8 (8) | 166,798.2 (3) |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **'5702** | Үслэг биш, хээгүй хивс буюу бусад нэхмэл дэвсгэрэн зүйлс ба даавуун хивс, гар хивс | 146,174 (23) | 818,629 (4) | 247,275 (14) | 250,275 (12) | 1,387,183 (2) | 88,075 (29) | 221,546 (15) | 1,171,702 (3) | 2,178,934 (1) | 663,830 (5) |
| **5705** | Хивс, бусад нэхмэл шалны дэвсгэр | 10,700 (28) | 30,057.6 (8) | 24,234.2 (11) | 34,895.8 (6) | 63,482.2 (4) | 22,233.8 (16) | 15,566.8 (20) | 52,031.4 (5) | 168,755.4 (1) | 120,953.8 (2) |
| **'5905** | Нэхмэл ханын өнгөлгөө (wall covering) | 6,724 (2) | 2,631 (8) | 3,848 (6) | 1,549 (15) | 2,497 (9) | 885.6 (23) | 2,099 (11) | 5,968 (4) | 16,226 (1) | 363 (41) |
| **'5906** | Резинтэй нэхмэл даавуу (5902-с бусад) | 100,339 (3) | 53,255 (6) | 12,444 (32) | 33,052 (11) | 140,989 (2) | 13,402 (29) | 12,644 (30) | 28,753 (14) | 152,075 (1) | 25,787 (15) |
| **'5907** | Зурагт, зотон нэхмэл даавуу (театр, тайзны зориулалттай) | 66,876 (2) | 17,676 (13) | 27,293 (7) | 11,298 (22) | 71,189 (1) | 4,496 (34) | 4,115 (39) | 27,272 (8) | 33,799 (5) | 4,205 (36) |
| **'5908** | Дэнлүү, зуухны нэхмэл гол | 1,379 (9) | 1,191 (11) | 172.8 (45) | 453.2 (23) | 3,887 (3) | 395.8 (28) | 292.4 (36) | 717.2 (16) | 7,195 (1) | 300 (34) |
| **'5909** | Нэхмэл хоолой, гуурс | 4,930 (20) | 8,112 (7) | 16,885 (2) | 6,517 (9) | 6,300 (12) | 5,516 (16) | 5,075 (17) | 6,094 (13) | 38,808 (1) | 11,761 (5) |
| **'5910** | Туузан дамжуулагч | 27,985 (3) | 22,496 (4) | 9,666 (14) | 7,237 (21) | 30,277 (2) | 14,238 (9) | 19,208 (5) | 12,946 (10) | 60,590 (1) | 6,019 (24) |
| **'5911** | Нэхмэл бүтээгдэхүүн, цахилгааны хэрэгсэлд зориулсан | 461,525 (2) | 128,951 (8) | 98,444 (13) | 155,130 (6) | 426,938 (3) | 97,993 (14) | 41,322 (33) | 93,988 (15) | 726,096 (1) | 140,263 (7) |
| **6002** | Сүлжмэл болон нэхмэл даавуу | 13,899 (8) | 2,854 (35) | 2,936 (34) | 4,235 (24) | 12,312 (13) | 569.4 (74) | 3,023 (32) | 3,078 (31) | 7,976 (17) | 3,975 (25) |
| **6101** | Ямааны ноолууран пальто, хүрэм, жакет | 11,425.2 (29) | 109,781.8 (4) | 28,377.2 (14) | 68,951.8 (9) | 155,736.4 (2) | 19,377 (19) | 21,188.2 (17) | 129,697.4 (3) | 1,055,465 (1) | 84,157.2 (6) |
| **6102** | Эмэгтэй, охидын ямааны ноолууран үйлс | 14,264.4 (29) | 129,487.8 (6) | 26,818.8 (20) | 84,099.4 (9) | 466,724 (2) | 21,905.6 (22) | 50,638.2 (13) | 222,843 (3) | 1,041,317.6 (1) | 201,633.2 (4) |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **6103** | Сүлжмэл костюм буюу комплект, ансамбль, жакет, өмд, комбинзон | 82,399.6 (18) | 102,319 (15) | 102,975 (14) | 242,917.6 (6) | 206,003.8 (7) | 80,699 (19) | 2,8312 (34) | 350,955.2 (4) | 982,050 (1) | 413,183.2 (3) |
| **6104** | Ноолууран өмд, цамц, пальто, банзал (эмэгтэй) | 201,946 (21) | 545,902.4 (13) | 576,520.4 (12) | 797,711.8 (9) | 2,000,909.8 (2) | 155,974.6 (23) | 291,713.2 (17) | 1,609,796 (3) | 5,173,771.2 (1) | 1,523,226.4 (15) |
| **6105** | Ноолууран цамц (эрэгтэй) | 112,232.8 (15) | 150,175.2 (11) | 66,038 (23) | 390,499.2 (6) | 587,158.4 (3) | 93,536.2 (16) | 83,062.4 (19) | 610,980 (2) | 2,166,491.8 (1) | 517,046 (4) |
| **6106** | Нэхмэл, сүлжмэл цамц (эмэгтэй) | 20,616.4 (39) | 112,198.6 (13) | 99,276.2 (15) | 162,107.6 (8) | 578,067.2 (3) | 58,981.6 (22) | 76,558.6 (19) | 364,266 (4) | 923,073 (2) | 1,130,953.6 (1) |
| **6107** | Дотуур өмд, гэрийн хувцас, усны алчуур (эр) | 32,619.2 (27) | 134,215.8 (10) | 101,465.4 (13) | 263,902 (6) | 397,961 (3) | 73,301 (16) | 64,643.2 (18) | 388,736.2 (4) | 1,420,046.4 (1) | 544,270.8 (2) |
| **6108** | Дотуур өмд, гэрийн хувцас, усны алчуур (эм) | 34,886.2 (36) | 288,419.2 (10) | 216,636.4 (13) | 396,129.2 (7) | 768,903.6 (3) | 8,1563.8 (20) | 148,976.6 (16) | 745,715 (4) | 3,002,312.2 (1) | 788,053.6 (2) |
| **6109** | Сүлжмэл футболка, майк | 308,255.8 (21) | 709,626.2 (11) | 560,398.8 (13) | 1,524,656 (7) | 4,141,899.2 (2) | 512,793 (16) | 306,285 (22) | 2,666,529.8 (3) | 5,404,354.6 (1) | 2,279,571.4 (4) |
| **6110** | Свитер, пуловер, джемпер болон бусад сүлжмэл гадуур цамц | 400,055.6 (20) | 1,254,143 (10) | 89,1371.2 (12) | 2,092,795 (7) | 4,497,826.4 (3) | 461,649.4 (19) | 869,316.8 (13) | 3,230,053.8 (4) | 1,4703,169.6 (1) | 4,871,118.4 (2) |
| **6111** | Хүүхдийн сүлжмэл өмсгөл, хувцас | 53,414.6 (16) | 165,014.2 (9) | 98,679.8 (14) | 313,515.6 (5) | 378,174.2 (4) | 28,958.6 (32) | 51,260 (25) | 600,914.6 (2) | 1,939,933.6 (1) | 257,101.8 (7) |
| **6114** | Бусад сүлжмэл хувцас | 26,020.8 (27) | 154,278.6 (10) | 13,802.6 (35) | 506,221 (2) | 381,733.6 (3) | 136,912.8 (11) | 110,135.8 (14) | 247,885.2 (6) | 923,315.8 (1) | 285,666.4 (4) |
| **6116** | Сүлжмэл ноосон бээлий | 12,106.2 (37) | 112,779.8 (7) | 78,155.8 (11) | 102,358.8 (8) | 318,239 (3) | 83,971.6 (9) | 33,967.6 (22) | 165,247.8 (5) | 742,154.8 (1) | 433,467.2 (2) |
| **6117** | Бусад, хувцасны сүлжмэл тоноглол | 36,603.8 (19) | 510,01.6 (12) | 46,382.4 (16) | 85,679.6 (9) | 221,218.4 (2) | 27,442.2 (24) | 32,777.8 (20) | 123,524.6 (6) | 378,806.2 (1) | 158,500 (4) |

**Хүснэгт А.15. Монгол улсын экспортын дундаж болон худалдааны түнш орнуудын импортод эзлэх хувь (2011-2013 , мянган ам.доллар)**

| Код | Бүтээгдэхүүн | БНХАУ | Канад | ОХУ | Итали | ХБНГУ | БНСУ | Швейцарь | Их Британи | АНУ | Япон |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **'0202** | Үхрийн мах, хөлдөөсөн | | | 7502.5$ (1.9%) 2878.5 тонн | | | | | | | |
| **'0205** | Адууны мах, шинэ, хөлдөөсөн | 2526.6$ (72.2%) 2367 тонн | | 4526.6$ (6.1%) 1735 тонн | | | | | | | |
| **0210** | Гэдэс, цувдаа | | | | | | | | | | 37$ (0.1%) 2.6 тонн |
| **0504** | Өлөн гэдэс, давсаг, гүзээ | 80.67$ (0.03%) 68.3 тонн | | | | 5868.67 $ (0.9%) 205 тонн | | 3122.4$ (7.6%) 87.9 тонн | | | 5$ (0.002%) 53.3 тонн |
| **'0506** | Яс, тугалмай | 154.3$ (5.3%) 2722 тонн | | | | 0.5$ (0.002%) 1 тонн | 2.1$ (0.2%) 2.3 тонн | | | | |
| **'0507** | Эвэр, туурай, зааны яс, соёо, яст мэлхийн хуяг, шувууны хошуу, савар, хумс | | | | | 173.6$ (1.5%) 9.6 тонн | | | | 14$ (1%) 7 тонн | |
| **'0511** | Амьтны гаралтай бүтээгдэхүүн nes; | 139.6$ (0.3% ) 279 тонн | | | | | | | | | |
| **'4101** | Үхэр, адууны түүхий шир | 2941.3$ (0.1%) 3541 тонн | | | 63.3$ (0.01%) 30 тонн | | | | | | |
| **'4103** | Түүхий, боловсруулаагүй арьс шир | | | | 664.3$ (0.9%) 153 тонн | | | | | | |
| **'4104** | Үхэр, адууны боловсруулсан шир (4108/4109-с бусад) | 2611.6$ (0.2%) 2518 тонн | | | 3552.3$ (0.3%) 1275.6 тонн | | | 0.3$ (0.007%) 1.4 тонн | | | 37.7$ (0.05%) 199 тонн |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **'4105** | Хонь, хурганы боловсруулсан шир (4108/4109-с бусад) | 7635.3$ (15.6%) 8921 тонн | | | 2.5$ (0.3%) | | | | | | 25.6$ (0.3%) |
| **'4106** | Ямаа, ишигний боловсруулсан арьс буюу шевро (4108/4109-с бусад) | 2254$ (3.1%) 2629 тонн | | | 869.6$ (0.5%) 199 тонн | | 233$ (4.5%) 50 тонн | | | | 18.6$ (0.2%) |
| **4107** | | 43.67$ (0.002%) | | | | | | | | | |
| **5101** | Хонины сэмлээгүй буюу самнаагүй ноос. | 5946.67$ (0.2%) | | 406.67$ (1.2%) | | 189$ (0.02%) | | | | | 7.5$ (0.001%) |
| **5102** | Нарийн болон бүдүүн амьтны үс, сэмлээгүй буюу самнаагүй | 72866$ (83.3%) | | 70.67$ (52%) | 39228$ (14%) | 119$ (0.6%) | 2$ (0.02%) | | 1413.3$ (1.9%) | | 285.6$ (1.4%) |
| **5103** | Ноосны хаягдал | | | 31$ (58.1%) | | | 2$ (0.1%) | | | | |
| **'5105** | Мал амьтны самнасан үс, хялгас | 7196.6$ (5.7%) 108 тонн | | 46.6$ (2.3%) 43.3 тонн | 82$ (0.02%) 0.5 тонн | 309$ (0.1%) 31.6 тонн | 77.3$ (0.05%) 60 тонн | 556.5$ (14.1%) | 4571.6$ (22.3%) | 0.5$ (0.002%) | 44.6$ (0.05%) |
| **'5108** | Мал амьтны нарийн ширхэгт үс, ноосон ээрмэл (жижиглэн баглаагүй) | | | | 6.67$ (0.01%) | | | | | | 13.3$ (0.1%) |
| **5109** | Ноосон ээрмэл, мал амьтаны нарийн ширхэгт үс | | 0.33$ (0.005%) | | 5.33$ (0.05%) | | 1$ (0.02%) | | | 4.33$ (0.01%) | |
| **'5111** | Мал амьтны нарийн ширхэгт сэмэлсэн үс, ноосон даавуу | | | | 3$ (0.01%) | | 21.3$ (0.1%) 6 тонн | | | 0.3$ (0.00001%) | 1$ (0.003%) |
| **5112** | Мал амьтны нарийн ширхэгт сэмэлсэн үс, ноосон даавуу | | | | 1$ (0.001%) | | | | | | 45.6$ (0.03%) |
| **'5702** | Үслэг биш, хээгүй хивс буюу бусад нэхмэл дэвсгэрэн зүйлс ба даавуун хивс, гар хивс | 954$ (0.7%) 193 тонн | | 138.6$ (0.1%) 18.3 тонн | | 96$ (0.007%) 10 тонн | | | | 8.5$ (0.0004%) 140 тонн | 91.6$ (0.01%) |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **6101** | Эмэгтэй, охидын ямааны ноолууран үйлс | 7.33$ (0.1%) | | | | 3$ (0.002%) | 0.33$ (0.002%) | | | 0.3$ (0.0003%) | |
| **6102** | Эмэгтэй, охидын ямааны ноолууран үйлс | 4.73$ (0.03%) | 20$ (0.02%) | 8.67$ (0.03%) | 33$ (0.04%) | 26$ (0.01%) | 2.6$ (0.01%) | 4.3$ (0.01%) | 0.3$ (0.0001%) | 3.6$ (0.0003%) | 27.3$ (0.01%) |
| **6103** | Сүлжмэл костюм буюу комплект, ансамбль, жакет, өмд, комбинзон (эр) | 3.67$ (0.004%) | 0.3$ (0.0003%) | 0.67$ (0.001%) | | | | | | 0.3$ (0.00003%) | 4$ (0.001%) |
| **6104** | Ноолууран өмд, цамц, пальто, банзал (эмэгтэй) | 41$ (0.02%) | 22.3$ (0.004%) | 198.3$ (0.03%) | 54.3$ (0.01%) | 105.6$ (0.01%) | 16.5$ (0.01%) | 13$ (0.004%) | 18$ (0.001%) | 4.6$ (0.0001%) | 24.3$ (0.002%) |
| **6105** | Ноолууран цамц (эрэгтэй) | | | | | 4.67$ (0.00001%) | 1.5$ (0.00002%) | | | | |
| **6106** | Нэхмэл, сүлжмэл цамц (эмэгтэй) | 0.33$ (0.002%) | 0.33$ (0.0003%) | 0.33$ (0.0003%) | 2.5$ (0.002%) | 22.3$ (0.004%) | 0.3$ (0.001%) | | 886.2$ (0.2%) | 0.5$ (0.0001%) | |
| **6107** | Дотуур өмд, гэрийн хувцас, усны алчуур (эр) | | | | | | | | | 3.66$ (0.0003%) | 4.5$ (0.001%) |
| **6108** | Дотуур өмд, гэрийн хувцас, усны алчуур (эм) | | 1$ (0.0003%) | | | 1.67$ (0.0002%) | 0.5$ (0.001%) | | 3.66$ (0.0005%) | 5.5$ (0.0002%) | 24.3$ (0.003%) |
| **6109** | Сүлжмэл футболка, майк | 0.67$ (0.0002%) | 1.3$ (0.0002%) | | 4.67$ (0.0003%) | 2$ (0.00005%) | 13$ (0.03%) | 6.33$ (0.002%) | | 0.6$ (0.00001%) | 3.66$ (0.0002%) |
| **6110** | Свитер, пуловер, джемпер болон бусад сүлжмэл гадуур цамц | 1807$ (0.5%) | 208.3$ (0.02%) | 417.67$ (0.05%) | 1,593.67$ (0.08%) | 2,006.67$ (0.04%) | 853.6$ (0.2%) | 201.33$ (0.02%) | 2985.3$ (0.1%) | 203$ (0.001%) | 1,253.6$ (0.03%) |
| **6111** | Хүүхдийн сүлжмэл өмсгөл, хувцас | | | | | 29.33$ (0.008%) | | 3$ (0.02%) | | 1.5$ (0.0001%) | |
| **6114** | Бусад сүлжмэл хувцас | 0.33$ (0.001%) | 0.6$ (0.0004%) | | 7$ (0.001%) | 15.67$ (0.004%) | 0.6$ (0.0004%) | 1$ (0.001%) | 16$ (0.01%) | 3.3$ (0.0004%) | 9$ (0.003%) |
| **6116** | Сүлжмэл ноосон бээлий | 11$ (0.09%) | 3.3$ (0.003%) | 7.67$ (0.01%) | 15.33$ (0.01%) | 15.3$ (0.005%) | | 10$ (0.03%) | 9$ (0.001%) | 0.66$ (0.0001%) | 3$ (0.001%) |
| **6117** | Бусад, хувцасны сүлжмэл тоноглол | 74.67$ (0.2%) | 38.3$ (0.08%) | 29.3$ (0.06%) | 144.6$ (0.2%) | 201.3$ (0.09%) | 28.3$ (0.1%) | 19.3$ (0.1%) | 1193.17$ (1%) | 35$ (0.009%) | 159$ (0.1%) |

**Хүснэгт А.16. Монгол улсын мах, махан бүтээгдэхүүн, тонн**

| | Үхрийн мах | Хонь, ямааны мах | Адууны мах |
|---|---|---|---|
| **2000** | 113,400 | 120,000 | 40,000 |
| **2001** | 66,900 | 104,600 | 32,500 |
| **2002** | 60,700 | 94,900 | 39,000 |
| **2003** | 43,600 | 80,900 | 26,000 |
| **2004** | 52,300 | 98,100 | 40,000 |
| **2005** | 45,300 | 94,600 | 40,400 |
| **2006** | 44,200 | 88,400 | 31,900 |
| **2007** | 46,600 | 107,000 | 29,000 |
| **2008** | 54,200 | 119,810 | 38,100 |
| **2009** | 58,565 | 168,819 | 35,582 |
| **2010** | 47,547 | 126,444 | 24,388 |
| **2011** | 53,591 | 124,262 | 24,964 |
| **2012** | 59,704 | 123,576 | 31,082 |
| **2013** | 227,057 | - | - |

## 3. ХАА-Н САЛБАРЫН МЭРГЭЖИЛТНҮҮДТЭЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГА СУДАЛГААНЫ ТЭМДЭГЛЭЛ

### А) *Швейцарын хөгжлийн агентлаг, Малын эрүүл мэнд төсөл, төслийн менежер С.Батсайхан*

Манай улсын мал сүрэг эрүүл байна гэдэг нь Монгол улсын нийт ард түмний эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, амьжиргааны эх үүсвэр найдвартай байна гэсэн үг билээ. Иймд 2012-2015 онуудад Швейцарын Засгийн газрын дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй Малын эрүүл мэнд төсөл нь Бодлого, хууль эрх зүйн орчин, Малын өвчинтэй үр дүнтэй тэмцэх, Малын эмч бэлтгэх боловсролын тогтолцоог сайжруулах гэсэн үндсэн гурван чиглэлд үйл ажиллагаа явуулж байна.

Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд нэн түрүүнд тулгарч буй асуудал бол малын эрүүл мэнд юм. Манай улсын мал эмнэлэгийн тогтолцоо муу, улс төрийн тогтворгүй байдлаас үүдэн удирдах түвшин болон мэргэжилтний тухайд залгамж чанар хангагдахгүй байгаа нь салбарын хувьд суурь шалтгаан болж байна.

Энэхүү малын эрүүл мэндийн асуудлыг шийдэхийн тулд Улсын нэгдсэн мал эмнэлгийн газартай болох шаардлагатай байна. Ингэснээр, орон нутагт малын шүлхий, бруцеллёз зэрэг халдварт өвчин гарахад тухайн газарт шуурхай арга

хэмжээ авах боломж бий болох, малыг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх, түүнийг эргээд үнэлэх механизмыг бий болгох, малын эмч нарын боловсролыг сайжруулах, дэлхийн стандартад нийцүүлэх, улмаар мах, махан бүтээгдэхүүний эрүүл ахуйн стандартыг дэлхийн жишигт нийцүүлэх боломж бүрдэх юм.

Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх шатанд тулгарч буй бэрхшээлийг дараах байдлаар тодорхойлж байна.

- Улс төрийн тогтворгүй байдал, салбарын мэргэжилтний залгамж чанар хангагдахгүй байгаа явдал
- Малын эмч нарын боловсрол дутмаг, сургалтын хөтөлбөр хоцрогдсон, практик сургалт бага

**Б)** ***Хүнс ХАА-н яам, Болортуяа***

Олон улсын стандартын (OIE) дагуу мал эмнэлгийн хорио цээрийн шаардлагыг хангаж буй тохиолдолд тухайн улс мах экспортлох боломжтой болдог. Үүгээр онц ноцтой 6-н өвчин гарсан тохиолдолд хорио цээр тавьдаг бөгөөд манай улсын хувьд онцгой анхаарах ёстой нь шүлхий өвчин юм. Хэдийгээр шүлхий нь хүнд халдварлахгүй боловч түүнээс үүдэх эдийн засгийн зардал өндөр байдаг. Жишээ нь, Австрали улсад нэг удаа шүлхий гарсан тохиолдолд хорио цээрээс үүсэх хохирол болон зардал нь 30 тэрбум ам.долларт хүрсэн тохиолдол байдаг. Монгол улсын тухайд 2013 онд 5 тэрбум орчим төгрөг, 2014 онд 10,6 тэрбум төгрөгийг шүлхийнээс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад зарцуулсан байна.

Адуу нь шүлхий өвчин тусдаггүй учир адууны мах экспортлоход асуудал төдийлөн үүсдэггүй. Үхэр, хонины мах экспортлох тохиолдолд эрүүл ахуйн стандарт, тухайн мал шүлхий өвчингүй нутгаас гаралтай болохыг баталсан гэрчилгээ хэрэгтэй болдог. Энэхүү эрүүл ахуйн стандартыг хангахын тулд хэрэгжүүлэх, хяналтын тогтолцоо сул байна.

Хэрэглэгчийн хувьд хүнсний эрүүл, аюулгүй талаас Farm to Table буюу тухайн махны аюулгүй байдал нь малчны хотоос эхлээд хэрэглэгчид хүртлэх бүхий л шатыг нэгдсэн нэг газар хянаж, түүнд эрүүл ахуйн стандартыг хангаж буй хэмээн баталгааг олгож байх хэрэгтэй юм. Ингэснээр мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох боломж нээгдэх юм. Харин Монгол улсын хувьд одоогоор тийм байгууллага эрх зүйн хувьд ч, институцийн хувьд ч бий болоогүй байна.

Манай улсын тухайд салбарын институцийн чадамж муу, тогтолцоо нь буруу байгаагаас мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд бэрхшээл болж байна. Үүнийг хэвтээ болон босоо чиглэлд дараах байдлаар ойлгож болно.

- Босоо чиглэлд: Command Chain буюу салбарын удирдлагын босоо тогтолцоо бүрдээгүй байна. Босоо тогтолцоотой болсноор малын халдварт өвчин гарсан тохиолдолд тухайн орон нутагт шуурхай арга хэмжээ авах, удирдлагын хувьд ойлгомжтой болох зэрэг ихээхэн ач холбогдолтой.
- Хэвтээ чиглэлд: Малчны хотоос хэрэглэгч хүртлэх бүх шатыг хянаж, удирдаж байх нэгдмэл нэг тогтолцоотой болох шаардлагатай байна. Ингэснээр, малын гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуйн стандарт, хүнсний аюулгүй байдал, баталгааг хангах боломж бий болно.

**B)** ***ХАА-н бирж, Арилжааны албаны ахлах мэргэжилтэн Т.Баасанжав***

2014 оны байдлаар улсаас ноос, ноолууранд 500 тэрбум төгрөг, мах, мах махан бүтээгдэхүүнд 700 тэрбум төгрөг тус тус зарцуулсан бөгөөд энэ нь мал аж ахуй эрхэлж буй нэг хүнд 3,3 сая төгрөг орлого болж очсон хэмээн ойлгож болно. Гэвч энэ дүн бол малчин өрхийн нэг жилийн орлого гэж бодвол төдийлөн хангалттай биш тоо. Энэхүү орлогыг нэмэгдүүлэх боломж бол ХАА-н бирж.

ХАА-н бирж бол зах зээлд худалдах болон худалдан авах талуудыг учруулж, тэдгээрийн хооронд хэлцэл явагдах боломжийг олгодог дэд бүтэц юм. Ноос, ноолууран бүтээгдэхүүний арилжааны тухайд бирж байгуулагдахаас өмнө малчны хотоос эцсийн үйлдвэрлэгч хүртэл дундын ченж оролцдог байв. Малчин ноос, ноолуурын үнийн мэдээлэлгүй учраас ченжид 1 кг нь 10 мянган төгрөгөөр хямдхан худалддаг, харин эцсийн үйлдвэрлэгчид хүрэхдээ 60 мянган төгрөг болж очдог байсан.




ХАА-н биржид брокероор дамжуулан малчид ноос, ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүнээ худалдаалах, нөгөө талаас үйлдвэрүүд шууд худалдан авах үнийн санал, тоо хэмжээгээ өгснөөр арилжаа шууд хийгддэг. Ингэснээр, дундын ченж оролцохгүй, малчид үнийн мэдээлэл сайтай болж байгаа юм.

Одоогийн байдлаар бирж дээр ноос, ноолуурыг 10кг-аар багц болгон, өнгөөр нь цайвар, бараан, цагаан гэж гурав ангилж арилжаалдаг. Үүнийг улам сайжруулах шаардлага байгаа. Тухайлбал, өнгөөр ялгахаас гадна ноос, ноолуурын микрон болон урт зэргээр ангилан ялгаатай үнээр бирж дээр худалдаалах хэрэгтэй юм. Итали, Англи зэрэг улсын томоохон компаниуд дээд зэрэглэлийн стандартын ноос, ноолуур худалдан авах сонирхолтойгоо илэрхийлдэг бөгөөд манайх одоогийн байдлаар ийм түвшинд хүрээгүй байна. Үүний тулд малчид хоршоо болон ноос, ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүнээ тухай аймгийн төвд нэгтгэн

бөөгнөрүүлэх хэрэгтэй. Мөн, ХАА-н төлөөлөл болсон аймгийн салбарт ноос, ноолуурын стандарт тогтоодог, баталгаажуулдаг механизм бий болгох шаардлагатай юм.

Бусад ХАА-н бүтээгдэхүүн болох гурил, улаан буудайн тухайд бирж мөн амжилттай арилжаалж байгаа боловч мах, махан бүтээгдэхүүний хувьд боломжгүй байна. Иймд мах, махан бүтээгдэхүүний хувьд зах зээлийн өрсөлдөөнт зарчим үйлчлэх боломжгүй гэсэн үг.

Улаан буудайн тухайд төрийн оролцоо энэ салбарт их байдаг нь зах зээлд хүндрэл бий болгодог. Улсаас улаан буудайг тонн тутмыг 550 мянган төгрөгөөр худалдан авна гэсэн бодлого нь чанарыг үл хайхарч, тариалан эрхлэгчид тооны араас хөөцөлддөг нөхцөл байдал руу түлхэж байна. Улмаар чанарын шаардлага хангахгүй, шилэнцэр, цавуулаг багатай буудай их хэмжээгээр нийлүүлэгдэж, түүнийг төрөөс баталгаатай худалдан авч байгаа нь талх, нарийн боовны үйлдвэрүүдэд хүндрэл үүсгэж байна. Иймд үйлдвэрлэгчид аргагүйн эрхэнд Орос улсаас буудай импортолж, талх, нарийн боов зэрэг гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа юм. 2014 онд бирж дээр улаан буудайг 1, 2, 3-р зэргийн гэж гурав ангилан арилжаалсан бөгөөд хамгийн сайн чанарын 1, 2-р зэргийн буудай 1 тонн нь 565, 000 – 580,000 төгрөгөөр үйлвэрүүд худалдан авсан бол 3-р зэргийн буудайг 1 тонн 550,000 төгрөг болж үнэ буурсан ч арилжаалагдаагүй. Энэ нь манай төрийн оролцоо сөрөг нөлөөтэй, буудайн чанар бус тооны араас хөөцөлдөж буйг харуулж байна.

**Г)** ***Монголын ноос, ноолуурын холбоо, дэд тэргүүн Г.Ёндонсамбуу***

Манай улсын ноос, ноолууран бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд экспортлоход хүндрэл үүсгэдэг үндсэн гурван шалтгаан дараах эрэмбэтэй байдаг.

1. Монгол бол жижиг улс, далайд гарцгүй.
2. Тогтвортой, их хэмжээгээр нийлүүлэх боломжгүй.
3. Чанарын асуудал

Дэлхийн худалдааны зах зээлийн нэгэнт тогтсон системд манай улс шиг жижиг орон нэвтрэх боломж маш бага. Том гүрний, том компаниуд Монголын бүтээгдэхүүнийг төдийлөн сонирхдоггүй. Бүтээгдэхүүний түүх, суртачилгаа хийх чадамж манай улсад сул байна. Ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортыг дэмжихийн тулд төрийн томоохон албан тушаалтангаас эхлээд холбогдох мэргэжилтнгүүд гадаад төрийн айлчлал их хийдэг боловч гадаад улсын хувьд тухайн бүтээгдэхүүнийг худалдан авах эсэхийг төрийн ажилтан биш худалдааны компаниуд, дэлгүүрийн эзэд шийддэг юм.

Манай улсын хэмжээнд жилд дунджаар 1,6 сая ширхэг кашмер, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Гэтэл гадаадын харилцагч жилдээ 5-6 сая ширхэг

захиалага өгмөөр байхад манай улсын тухайд тогтвортой ханган нийлүүлэх боломж нь хязгаарлагдмал байдаг.

Чанарын хувьд уян зөөлөн, хэлбэрээ хадгалах чадвар гэсэн олон улсын хэрэглэгчийн шаардлага хангах нь хэцүү байдаг. Жишээ нь Япон улсын зах зээл маш өндөр шаардлагатай бөгөөд тус улсын Uniqlo сүлжээ дэлгүүр Өвөр Монголоос кашмер импортолж зах зээлд худалдаалдаг. Иймд манай улсын гол өрсөлдөгчид бол Өвөр Монгол, БНХАУ зэрэг юм.

Монгол улсын хувьд ноос, ноолуурын гол худалдан авагч нь БНХАУ юм. 2014 оны байдлаар 600 тонн самнасан ноос экспортолсноос 400 тонныг БНХАУ, үлдсэн 200 тонныг Итали улс худалдан авчээ. Тус улсын эдийн засаг өсөлттэй, хүн амын орлого нэмэгдэж байсан 1995-2010 онуудын хооронд ноос, ноолуурын эрэлт ихсэж, үнэ нь өсөж байсан бол сүүлийн жилүүдэд эрэлт буурсантай холбоотойгоор үнэ нь буурч байна.

Эдгээр асуудлыг төрийн нэгдсэн бодлого хэрэгжүүлж, тогтвортой хариуцлагатай системтэй болгосоноор ноос, ноолуурын салбар хөгжиж, эдийн засагт хувь нэмэр оруулах боломжтой болох юм.

**Д) Швейцарын хөгжлийн агентлаг, Ногоон Алт төслийн менежер, Ц.Энх-Амгалан**

Монгол улсын нийт газар нутгийн 2/3 хэсгийг бэлчээр эзэлдэг. 2014 оны байдлаар малын тоо хонин толгойд шилжүүлснээр 85,5 сая болж түүхэнд хамгийн өндөр түвшинд хүрлээ. Гэвч малын өсөлт болон сүргийн бүтцийг зохистой түвшинд барих бодлого, зах зээлийн урамшуулал зэрэг байхгүйн улмаас малчид орлогоо нэмэгдүүлэхийн тулд малын тоог ихэсгэх гэсэн өрөөсгөл хандлага сүүлийн олон жилийн турш үргэлжилж байна. Малын тоог хэт өсгөсний улмаас бэлчээрийн тэжээлийн нөөц хомсдож, ихээхэн хэмжээгээр талхлагдаж, бэлчээрийн доройтол нэмэгдэж байна.

Хүнс ХАА-н Яам болон Швейцарын хөгжлийн агентлаг хамтран манай улсын 7 аймгийг хамруулж, түүвэрлэлтийн аргаар нийт 1450 цэгийн тоон мэдээллийг ашиглан Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайланг (2015) боловсруулжээ. Энэхүү судалаагаагаар бэлчээрийн ургамлын бүтэц өөрчлөгдөж, доройтолд орсон байгаа бөгөөд нийт бэлчээрийн 90 хувь нь дахин сэргэхэд 10 жил шаардлагатай ажээ. Бэлчээрийн доройтлын томоохон шалтгаанаар уул уурхайн салбарын өсөлт, хайгуулын лиценз олголтын талбай ихэссэн явдал, цаг агаарын дулаарал, жил ирэх тусам багасаж буй хур тунадасны хэмжээ, малчид бэлчээрийн сэлгээ хийдэггүй зэргийг нэрлэж байна. Эдгээр хүндрэл, үүсээд буй асуудлыг шийдвэрлэхийн тулд малын тоог хянах, бэлчээрийн сэргэх чадавахад суурилсан ашиглалтыг нэвтрүүлэх шаардлагатай юм. Ингэснээр малын тоог

нэмэгдүүлэх нь малчдын амьжиргааг дээшлүүлдэг гэсэн өрөөсгөл хандлагаас татгалзаж, бэлчээрийн даацыг сэргэх чадавхид суурилан тооцдог болсноор бэлчээр сэлгэлтийг оновчтой хийх, бэлчээрийн ургамлын бүтэц сайжрах зэрэг олон эерэг нөлөөтэй ажээ. Жишээ нь, А.Энх-Амгалан (2013)-н судалгааг харахад бэлчээрийн ачааллыг 8 хувиар бууруулахад малчдын орлого 10 хувиар нэмэгдэх боломжтой гэжээ.

Мөн бэлчээр ашиглуулах гэрээг улам чанаржуулж албажуулах хэрэгтэй. Одоогоор хэрэгжиж буй гэрээг бүх улирлын бэлчээрийг хамруулж, сэргэх чадвахад суурилсан даацад малын тоог зохицуулах талаар малчдын хүлээх үүргийг илүү тодорхой болгох хэрэгтэй юм. Засгийн газраас хэрэгжүүлж эхэлсэн урамшуулал олгох хөтөлбөрийг мал аж ахуйн түүхий эд бүтээгдэхүүний тооны өсөлтөөс илүүтэйгээр чанарыг сайжруулахад зарцуулах хэрэгтэй. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг гадаад болон дотоод зах зээлд гарах боломжийг ашиглахын хувьд малын тоог 4-6 жилийн дотор бууруулах, малын чанарыг эрхэмлэх урт хугацааны бодлоготой болох нь зүйтэй.

**Сарлагийн хөөврийн шинэ үнэлэмжийг бий болгож, онцлог чанарт нь түшиглэн бүтээгдэхүүн хийсэн тухай**

Сарлагийн хялгасан доор нарийн зөөлөн хөөвөр ургадаг. Гэвч түүнийг 2000 он хүртэл ашиглаж чаддаггүй байлаа. Гол шалтгаан нь түүхий эд бэлтгэлийн чанар муу байдагтай холбоотой юм. Малчид сарлагаа ноослохдоо дээд талын хялгас үс болон хөөврийг хамтад нь хяргаж авдаг байснаас үүдэн үйлдвэрүүдэд ашиглах боломжгүй болдог байв. Мөн 1 кг сарлагийн хөөвөр 500 төгрөгийн үнэтэй байсан. Дотоодын боловсруулах үйлдвэрүүд хэдийгээр сарлагийн хөөврөөр бүтээгдэхүүн хийх сонирхол байвч бэлтгэлийн чанар муу учраас худалдан авах сонирхолгүй, нөгөө талаас малчид үнэ багатай түүхий эд хэмээн үзэн сарлагийн хөөврөө урьдын адил хялгастай холин самнах үзэгдэл түгээмэл хэвээр байв.

Үйлдвэрүүдийн хувьд худалдан авсан 1 кг сарлагийн хөөврийн ойролцоогоор 80-90 хувь нь хялгас болон бусад гологдол бүтээгдэхүүн бөгөөд ердөө 10-15 хувийг ашиглах боломжтой юм. Түүнчлэн малчид хяргах үедээ сарлагийн хөөврийг тайрч тасалснаас үйлдвэрийн технологийн шаардлага хангахгүй хэт богино хөөвөр болдог учраас гологдол бүтээгдэхүүн болгохоос өөр аргагүй болдог байв.

2004-2005 онд Ногоон Алт Төслөөс санаачлан мэргэжилтнүүдтэй хамтран

сарлагийн хөөврийн хялгасны хольцыг бууруулан, чанартай түүхий эд бэлтгэх үүднээс сарлагийн хөөврийг самнаж бэлтгэх аргыг малчдад зааж сургах туршилтын төслийг хэрэгжүүлсэн. Ингэснээр сарлагийн хөөврийн гарц 1 кг бүрд 30 хувь хүртэл нэмэгдэж хөөврийн бэлтгэлийн чанар сайжирсан байна. Мөн хялгасны хольц буурч хөөврийг таслалгүйгээр урт хэвээр нь авах, өнгө чанараар нь бэлтгэх боломж бүрдсэн.

Сүүлийн 8 жилийн туршид сарлагийн хөөврийн бэлтгэлийн үнэ буюу 1 кг тутам нь 500 төгрөгөөс 10-15 мянган төгрөг болтол өсөж тэр хэмжээгээр малчдын орлогод эерэг нөлөө үзүүлж байна. Манай улсын хэмжээнд байгаа нийт 450мянган сарлагийн тал орчим хувийг самнан жилдээ 40-60 тонн сарлагийн хөөвөр бэлтгэн үйлдвэрүүдэд ханган нийлүүлж байна. Энэ нь нийтдээ 5 аймгийн 15мянга гаруй малчин өрхийн орлогод энэ хэмжээгээрээ хувь нэмэр оруулж буй гэсэн үг юм.Түүнчлэн манай улс жилдээ нийт 40 гаруй тонн сарлагийн хөөвөр бэлтгэж байгаагаас 30 тонн буюу 1,5 сая ам.долларын экспортыг ОХУ, Европ, Канад зэрэг улсуудад хийж байна. Салбарт бүтэн цагийн 150, хагас цагийн 500 гаруй ажлын байр бий болжээ.

Сарлагийн хөөврийн бэлтгэлийн чанар сайжирснаас түүгээр эцсийн бүтээгдэхүүн хийдэг дотоодын үйлдвэрүүд бий болсон байна. Өнөөгийн байдлаар эдгээр үйлдвэрүүд сарлагийн хөөврөөр хийсэн бүтээгдэхүүнээ гадаадын зах зээлд гаргаж эхэлсэн бөгөөд тэдгээрийг дурдвал:

- Сор кашмер: http://sorcashmere.mn
- Жинст мөрөн: https://www.facebook.com/jinst.jinstmurun
- Баялал өлзий : http://www.bodios.mn/
- Уужин : http://uujinyak.com
- Ашид нэхмэл: https://mongoltextile.com/

Мөн сүүлийн жилүүдэд Монгол сарлагийн нэгдсэн барааны тэмдэг бий болгох чиглэлээр ажиллаж байна (www.yakmongolia.com).

# 4. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНГҮҮД

**Хүснэгт А.17. Хөдөөгийн өрхийн бодит орлогод нөлөөлөгч хүчин зүйлс**

Dependent Variable: LOG(INC_R)
Method: Stepwise Regression
Date: 06/22/15 Time: 16:19
Sample (adjusted): 2003 2014
Included observations: 12 after adjustments
Number of always included regressors: 3
Number of search regressors: 5
Selection method: Stepwise forwards
Stopping criterion: p-value forwards/backwards = 0.2/0.2

| Variable | Coefficient | Std. Error | t-Statistic | Prob.* |
|---|---|---|---|---|
| C | -4.658643 | 3.657307 | -1.273790 | 0.2434 |
| LOG(MUTTON_R) | 0.630051 | 0.248518 | 2.535234 | 0.0389 |
| LOG(CASH_RP) | 0.241757 | 0.152889 | 1.581254 | 0.1578 |
| LOG(MALS(-2)) | 0.850642 | 0.317832 | 2.676395 | 0.0317 |
| LOG(LOAN_EXUB(-1)/LOAN_EXUB(-2)) | 0.522416 | 0.250320 | 2.086994 | 0.0753 |

| | | | |
|---|---|---|---|
| R-squared | 0.724526 | Mean dependent var | 7.170625 |
| Adjusted R-squared | 0.567113 | S.D. dependent var | 0.215775 |
| S.E. of regression | 0.141967 | Akaike info criterion | -0.772106 |
| Sum squared resid | 0.141083 | Schwarz criterion | -0.570062 |
| Log likelihood | 9.632638 | Hannan-Quinn criter. | -0.846910 |
| F-statistic | 4.602697 | Durbin-Watson stat | 1.862076 |
| Prob(F-statistic) | 0.038795 | | |

Selection Summary

Added LOG(MALS(-2))
Added LOG(LOAN_EXUB(-1)/LOAN_EXUB(-2))

*Note: p-values and subsequent tests do not account for stepwise selection.

**Хүснэгт A.18. Аймгийн иргэдийн бодит цалинд нөлөөлөгч хүчин зүйлс**

Method: Panel Least Squares
Date: 06/24/15 Time: 17:50
Sample (adjusted): 2008 2014
Periods included: 7
Cross-sections included: 22
Total panel (balanced) observations: 154

| Variable | Coefficient | Std. Error | t-Statistic | Prob. |
|---|---|---|---|---|
| C | -4.453602 | 0.399358 | -11.15190 | 0.0000 |
| LOG(MALS(-4)) | 0.144777 | 0.048128 | 3.008187 | 0.0032 |
| LOG(HONI_MEAT/CPI) | 0.421235 | 0.044858 | 9.390315 | 0.0000 |
| LOG(NOOLUUR_UNE/CPI) | 0.084137 | 0.018854 | 4.462567 | 0.0000 |
| LOG(LOAN(-1)) | 0.245300 | 0.027638 | 8.875325 | 0.0000 |
| BUDGET_REV_RATIO(-2) | 2.277848 | 1.705939 | 1.335246 | 0.1842 |

Effects Specification

Cross-section fixed (dummy variables)

| | | | |
|---|---|---|---|
| R-squared | 0.945196 | Mean dependent var | 1.272395 |
| Adjusted R-squared | 0.933977 | S.D. dependent var | 0.382486 |
| S.E. of regression | 0.098280 | Akaike info criterion | -1.644112 |
| Sum squared resid | 1.226684 | Schwarz criterion | -1.111659 |
| Log likelihood | 153.5966 | Hannan-Quinn criter. | -1.427831 |
| F-statistic | 84.24457 | Durbin-Watson stat | 1.691335 |
| Prob(F-statistic) | 0.000000 | | |

## 5. ХАА-г хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд

**Хүснэгт А.19. ХАА-г хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд**

| | Хөтөлбөр | Зорилт |
|---|---|---|
| Үндэсний хөтөлбөр | 1. Хүнсний аюулгүй байдал үндэсний хөтөлбөр (2009-2016) | Иргэн, төр, олон нийт, хувийн хэвшлийн зохистой оролцоог хангах замаар хүн амыг тэжээллэг, эрүүл ахуйн баталгаатай хүнсээр жигд, хүртээмжтэй, тогтвортой хангаж, эрүүл аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх, Монгол брэндийн органик хүнсийг бий болгож гадаад, дотоодын зах зээлд өрсөлдөхүйц эдийн засгийн шинэ чадавхийг бүрдүүлэхэд оршино |
| | 2. Монгол мал үндэсний хөтөлбөр (2010-2021) | Мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж, зах зээлийн нөхцөлд өрсөлдөх чадвартай, эдийн засгийн үр ашигтай салбар байх нөхцөлийг бүрдүүлж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, экспортыг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино |
| | 3. Чацаргана хөтөлбөр (2010-2016) | Чацарганыг аж ахуйн болон өрхийн тариалангийн чиглэлээр 20 мянган га хүртэл талбайд тариалж цөлжилтөөс сэргийлэх, хөрс, байгаль орчныг хамгаалах, хүн амыг амин дэм бүхий жимс, жимсгэнээр тогтвортой хангахад оршино |
| | 4. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр (2003-2015) | Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх замаар олон улсын жишиг, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, импортыг бууруулах |
| | 5. Цаа бугын аж ахуйг сэргээх, цаачдын амьдралын түвшинг сайжруулах хөтөлбөр (2008-2015) | Гэрийн тэжээвэр цаа бугын удмын сан, эрүүл мэндийг нь хамгаалж өсгөх, ашиг шимийг нь зохистой ашиглах замаар цаачдын ахуй нөхцөлийг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх |
| | 6. Ус үндэсний хөтөлбөр (2010-2021) | Монгол орны усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглан улс орны хөгжлийн түлхүүр болгох, монгол хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино |
| Гадаадын хөтөлбөр | 1. Монгол төмс хөтөлбөр (2004-2015) | Төмсний үр үйлдвэрлэлийг үр ашигтай, тогтвортой болгон хөгжүүлж, үрийн хангалтын системийг төвлөрлөөс гаргаж, сайн чанарын үрийн хүрэлцээ хангамжийг сайжруулах замаар төмс үйлдвэрлэлийн үр ашгийг үндэсний болон орон нутгийн түвшинд сайжруулах болно |
| | 2. Цаг Уурт дасан зохицсон хөдөөгийн амьжиргааг бүрдүүлэх (2012-2016) | Малчдын бүлэг өртөг нэмсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бусад орлого нэмэгдүүлэх үйл ажиллагааг эрхлэх боломжтой болно. Орлогын төрлөө нэмэгдүүлэх нь байгаль цаг уурт өртөмхий мал аж ахуйгаас бага хамаарч цаг уурт зохицох зорилготой |
| | 3. Малын эрүүл мэнд төсөл (2012-2015) | Малчин өрхийн мал сүргийн тогтвортой менежентийг сайжруулах замаар мал аж ахуйн салбарын бүтээмжийг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулах юм |
| | 4. “Ногоон алт” бэлчээрийн экосистемийн удирдлага хөтөлбөр (2004-2015) | Бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх замаар малчдын амьжиргааг дээшлүүлэх, ядуу бүлгийн малчдыг дэмжих зэрэг болно |

| | | |
|---|---|---|
| | 5. Өмнөд Өмнөдийн хамтын ажиллагааны хүрээнд Хүнсний баталгаат байдал хөтөлбөрийг дэмжих Техник туслалцааны төсөл (2014-2016) | Мал үржүүлэг зохиомол хээлтүүлэг, шувууны аж ахуй, хүлэмжийн аж ахуй, зөгийн аж ахуйн чиглэлээр БНХАУ-ын мэргэжилтнүүд аж ахуйн нэгжүүдэд ажиллаж мэргэжил аргазүйн зөвлөгөө өгнө |
| | 6. Хөдөө аж ахуйн маркетинг төсөл (2012-2016) | Улс орнууд хүнсний баталгаат байдлыг хангах, хөдөө аж ахуйн хөгжлийн стратегийг хэрэгжүүлэхэд дутагдаж буй санхүүжилтыг нэмэгдүүлнэ |
| | 7. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл (2012-2016) | Хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлж амьжиргааг дээшлүүлэх замаар ядуурлыг бууруулна |
| | 8. Халх голын бүс нутагт загвар аж ахуй байгуулах төсөл (2011-2014) | МУ-ын Зүүн бүсэд мал аж ахуй, газар тариалангийн салбарыг байгалиас хараат бус байгальд ээлтэй, экспортын баримжаатай салбар болгон хөгжүүлж, бүс нутгийн хүнсний баталгаат байдлыг ханган, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортод гаргаснаар хязгаар нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг түргэтгэх зорилготой |
| | 9. “Монгол Улсад амьтны гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи, эрүүл ахуйн хяналтын системийг сайжруулах”-төсөл (2013-2015) | Технологи нэвтрүүлэх, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх, эрүүл ахуйн хяналтын системийг сайжруулах зорилго бүхий төсөл |
| | 10. “Монгол Улс дахь Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил”-төсөл (2013-2014) | Төслийн хүрээнд хөдөө аж ахуйн салбарын аж ахуйн нэгж байгууллагуудыг мэдээллийн олон талт үйл ажиллагаа, сургалтуудад оролцуулах замаар онолын мэдлэгийг практикт хэрэгжүүлэх боломжийг олгоно |
| | 11. Монгол Улсын Органик хөдөө аж ахуйд дэмжлэг үзүүлэх төсөл (2014-2016) | Органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн стандартын шаардлага хангасан органик хүнсний сүлжээний бүх үе шатанд баталгаажуулалтын эрх зүй, бүтэц зохион байгуулалтын орчинг бүрдүүлэх, органик хүнсний үйлдвэрлэлд хэрэглэх бодисын жагсаалт гаргах, олон улсын жишигт нийцүүлэх |
| | 12. Загас, загасан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх цөөрмийн аж ахуйг Монголд хөгжүүлэх төсөл (2014-2016) | Загасны аж ахуйг дэмжих замаар хүн амын хүнсний хэрэглээнд загас, загасан бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх улмаар хүмүүсийн шим тэжээллэг хоол хүнсний хэрэглээг нэмэгдүүлж эрүүл мэндийг хамгаалах юм. Хот орчмын бүсэд загасны аж ахуйг дэмжсэнээр хүмүүсийн амьжиргаанд мөн эерэгээр нөлөөлөх юм |
| | 13. Ургамлын салбарын чадавхыг бэхжүүлэх төсөл (2013-2015) | Хөнөөлт организмын цогц менежмент, ургамлын хорио цээр, пестицедийн менежмент гэсэн 3 дэд хэсэгээс бүрдэж энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. |
| | 14. Буудайн элит үр гаргах, үр үржүүлэх” “Олон наст тэжээлийн ургамал, царгас тариалах, тэжээлийн ургамлын үр үржүүлгийн загвар аж ахуй байгуулах”, “Тэжээл, тэжээллэгийг сайжруулан мах, ноосны хонины ашиг шим удамшлын чанарыг дээшлүүлэх” “Телевизийн цахим видео студи байгуулах” (2014-2017) | БНСУ-ын хөдөө аж ахуйн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, газар тариалан, мал аж ахуйн чиглэлээр улаанбуудайн шинэ элит сорт турших, үр үржүүлэх мөн малын үр ашгийг нэмэгдүүлэх, тэжээлийн олон наст ургамлын тариалалт, хангамжийг нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх |

*Эх үүсвэр: (Хүнс Хөдөө Аж Ахуйн Яам, 2015)*